Mongolian Marketing Consulting Group
YOUR RESEARCH PARTNER

GOVERNMENT OF MONGOLIA

# МОНГОЛЫН УНАГАН БАЙГАЛИЙН ХҮЛЦЭЛ ТОГТВОРЖИЛТЫГ ХАНГАХ НЬ ТӨСӨЛ – **МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА (КАР) –ЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



**2019.08.12**

Захиалагч: НҮБХХ, БОАЖЯ

Гүйцэтгэгч: "ЭМ ЭМ СИ ЖИ" ХХК

ASIA PACIFIC RESEARCH COMMITTEE

ISO 20252 CERTIFIED RESEARCH STANDARD

ESOMAR'19 corporate

# АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт ..... 3

Графикийн жагсаалт ..... 5

1. КАР СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ..... 9

2. ӨРХИЙН АМЬЖИРГААТАЙ ХОЛБООТОЙ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ..... 11

3. БЭЛЧЭЭР, БЭЛЧЭЭРИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА ..... 18

4. ОЙ, ОЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА ..... 47

5. ХОВОР АН АМЬТАН, УРГАМАЛ ..... 57

- 5.1. Олон нийтийн ховор ан амьтанд хандах хандлага ..... 57
- 5.2. Гол оролцогч талуудын ховор ан амьтанд хандах хандлага ..... 66
- 5.3. Ховор ургамал ..... 73

6. МЭДЭЭЛЛИЙН СУВГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 78

- 6.1. Иргэдийн оролцоо ..... 78
- 6.2. Сургалтад хамрагдсан байдал ..... 83
- 6.3. Мэдээллийн эх үүсвэр ..... 85

ДҮГНЭЛТ ..... 104

ЗӨВЛӨМЖ ..... 110

- Олон нийтийн хувьд гол хүргэх мессеж ..... 110
- Гол оролцогч талуудын хувьд гол хүргэх мессеж ..... 112

ХАВСРАЛТ ..... 114

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1: Боловсрол ....10
Хүснэгт 2: Малын зүй бус хорогдол, 2018 оны байдлаар Улсын статистик үзүүлэлт....11
Хүснэгт 3: Сумдын бэлчээрийн доройтолд өртсөн хувь....43
Хүснэгт 4: Малын тоо, толгойг бууруулахад анхаарч ажилладаг өрхийн давтамж аймаг болон хувиар....46
Хүснэгт 5: Ойтой сум болон багийн эзлэх хувь....47
Хүснэгт 6: Ойн доройтлын түвшин сум болон хувиар ....54
Хүснэгт 7: Ховор ан амьтны талаарх хандлага ....58
Хүснэгт 8: Ховор ан амьтантай холбоотой хандлагын үзүүлэлтүүд, нас хүйс, орлогоор ....59
Хүснэгт 9: Сум орон нутагт нь нутагладаг ховор ан амьтан, байршлаар....60
Хүснэгт 10: Аргаль хонины ач тус....60
Хүснэгт 11: Янгирын ач тус ....61
Хүснэгт 12: Тарваганы ач тус ....61
Хүснэгт 13: Халиун бугын ач тус ....61
Хүснэгт 14: Ирвэсний ач тус....62
Хүснэгт 15: Хар сүүлтийн ач тус ....62
Хүснэгт 16: Баданга хүдрийн ач тус....62
Хүснэгт 17: Ан амьтны ховордож буй байдал, аймгаар....63
Хүснэгт 18: Ан амьтны ховордож буй шалтгаан ....63
Хүснэгт 19: Ховордсон ан амьтныг хамгаалахын тулд авах арга хэмжээ....64
Хүснэгт 20: Ховордож буй ан амьтныг хамгаалдаг хэлбэр ....65
Хүснэгт 21: Цаашид орон нутагтаа ховордсон ан амьтныг хамгаалах хэлбэр....66
Хүснэгт 22: Гол оролцогч талуудын ан амьтантай холбоотой асуудалд хандах хандлага ....70
Хүснэгт 23: Улаангоёо ургадаг эсэх ....73
Хүснэгт 24: Улаангоёоны талаарх хандлага ....74
Хүснэгт 25: Улаангоёоны ач тус ....74
Хүснэгт 26: Улаангоёо ховордох болсон шалтгаан ....75
Хүснэгт 27: Улаангоёог хамгаалах арга зам ....75
Хүснэгт 28: Хармаг жимс ургадаг эсэх ....76
Хүснэгт 29: Хамраг жимсний ач тус ....76
Хүснэгт 30: Иргэдийн оролцоо, байршлаар....79
Хүснэгт 31: Иргэдийн нэгдсэн нөхөрлөл, хоршооны төрөл, аймгаар....80
Хүснэгт 32: Иргэдийн оролцооны давуу тал, тулгарч буй асуудал бэрхшээл, анхаарах зүйлс....81
Хүснэгт 33: Иргэдийн сургалтад хамрагдсан байдал, сургалтын төрлөөр ....83

Хүснэгт 34: Сургалтад хамрагдсан байдал, нас хүйсээр ........................................................... 84
Хүснэгт 35: Цаашид сургалтад хамрагдах хэрэгцээ, сургалтын төрлөөр ..................................... 84
Хүснэгт 36: Мэдээ, мэдээлэл голчлон авдаг суваг, нас хүйсээр ................................................ 86
Хүснэгт 37: Мэдээллийн сувгийн хэрэглээ, байршлаар ........................................................... 86
Хүснэгт 38: Голчлон ашигладаг мэдээллийн суваг, улирлаар.................................................... 87
Хүснэгт 39: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг 20 суваг, нас хүйсээр................................ 88
Хүснэгт 40: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг 20 суваг, байршлаар ................................. 89
Хүснэгт 41: Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг, нас хүйсээр................................................ 91
Хүснэгт 42: Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг, байршлаар ................................................ 92
Хүснэгт 43: ФМ радиогоор сонсдог нэвтрүүлэг, байршлаар ..................................................... 93
Хүснэгт 44: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй суваг, нас хүйсээр....................................................................................................... 96
Хүснэгт 45: Судалгаанд оролцогчдын ХАА болон байгаль орчинтой холбоотой мэдээлэл авахыг хүсэж буй суваг, байршлаар.......................................................................................... 97
Хүснэгт 46: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй хэлбэр....................................................................................................................... 98
Хүснэгт 47: Гол оролцогч талуудын хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээ, мэдээлэл авдаг суваг ................................................................................................ 101

**Графикийн жагсаалт**


График 1: Нас хүйсийн суварга ........ 9

График 2: Судалгаанд оролцогчийн өрхийн дундаж орлого........ 10

График 3: Бэлчээрийн доройтлыг илэрхийлэх үзүүлэлтүүд, аймаг тус бүрээр, хувиар ........ 18

График 4: Баянхонгор аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар........ 19

График 5: Архангай аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар ........ 20

График 6: Завхан аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар........ 21

График 7: Говь-Алтай аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар ........ 21

График 8: Бэлчээрийн доройтлыг илэрхийлэх үзүүлэлтүүд, хөдөө, сумын төв болон хувиар........ 22

График 9: Бэлчээрийн доройтол нь тулгамдсан асуудал мөн эсэхийг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар ........ 23

График 10: Бэлчээрийн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор сумын төв, хөдөөгийн малчин өрх болон, хувиар ........ 24

График 11: Бэлчээрийн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар........ 24

График 12: Бэлчээрийн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор хөдөө болон сумын төвийн малчин өрхөөр, хувиар ........ 25

График 13: Бэлчээрийн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар ........ 27

График 14: Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог, хувиар........ 28

График 15: Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог, сум болон хөдөө, хувиар ........ 29

График 16: Архангай аймгийн бэлчээрийн онцлог, хувиар ........ 31

График 17: Архангай аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар........ 31

График 18: Завхан аймгийн бэлчээрийн онцлог, хувиар........ 34

График 19: Завхан аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар ........ 34

График 20: Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог, хувиар ........ 36

График 21: Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар........ 37

График 22: Малын бэлчээрээс хүртэж буй ашиг шим хөдөө болон сумын төвөөр, хувиар........ 39

График 23: Малчдын бэлчээрээс хүртэж буй ашиг шим, аймгаар, хувиар........ 41

График 24: Бэлчээрт тулгамдаж буй асуудал, аймаг болон хувиар ........ 42

График 25: Бэлчээрийн доройтлын шалтгаан аймаг болон хувиар........ 44

График 26: Бэлчээрийн доройтлыг бууруулах арга замууд аймаг болон хувиар ........ 45

График 27: Ойн доройтол нь тулгамдсан асуудал мөн эсэхийг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар ........ 48

График 28: Ойн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар........ 49

График 29: Ойн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар ....................................................50
График 30: Ойн онцлог аймаг болон хувиар....................................................51
График 31: Ойгоос хүртдэг ашиг шим аймаг болон хувиар....................................................52
График 32: Ойн байгаль орчинд үзүүлэх нөлөө аймаг болон хувиар....................................................53
График 33: Ойн доройтлыг бууруулахын тулд хийх ажлууд аймаг болон хувиар....................................................55
График 34: Ойн доройтлыг бууруулахын тулд хийдэг ажлууд аймаг болон хувиар....................................................56
График 35: Хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй, амьтнаар ....................................................64
График 36: Улаангоёо ургадаг эсэх ....................................................73
График 37: Хармаг жимс ургадаг эсэх ....................................................76
График 38: Мэдээ мэдээлэл голчлон авдаг суваг....................................................85
График 39: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг ТОП 10 суваг, олон нийт....................................................88
График 40: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг нэвтрүүлэг ....................................................90
График 41: Телевиз үздэг, фм радио сонсдог цаг....................................................94
График 42: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй суваг ....................................................95

# КАР СУДАЛГААНЫ ТАЙЛАН -2019

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр болон Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам хамтран "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төсөл" (ENSURE) –ийн хүрээнд олон нийт болон гол оролцогч талуудын биологийн олон янз байдал, бэлчээр, ойн доройтлын талаарх "МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГЫН СУДАЛГАА" –г зохион байгуулав. Уг судалгааны ажлыг судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эм Эм Си Жи" (MMCG) ХХК гүйцэтгэж, тайланг боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

"Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл" (ENSURE) –ийн зорилго нь бэлчээр, ойн доройтлыг бууруулах замаар Саян, Хангайн уулс, өмнийн Говийн эко системийн үйлчилгээг сайжруулах ба тогтвортой амьжиргааг дэмжиж биологийн олон янз байдлыг хамгаалахад оршино. Энэхүү төсөл нь Архангай, Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 13 сумыг хамарч байна.

Мэдлэг, хандлага, туршлага (Knowledge Attitude Practice (KAP)) –ын судалгаа нь чадамжийг дээшлүүлэх (мэдлэгийн менежмент), олон нийтийн мэдлэг, мэдээлэл харилцаанд төслийн оролцоог төлөвлөх, сайжруулах, үнэлэх үндэслэлийн суурь нь болох юм. Мэдээлэлтэй, гүн ойлголттой, өргөн хэрэглээний КАР үнэлгээг зөвхөн олон нийтийн мэдлэг, мэдээлэл харилцааны үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглах бус мөн төслийн бусад оролцоог үнэлэхэд ашиглана.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг судалгааны олон улсын ёс зүйн стандарт болох ESOMAR-ын код болон Маркетинг, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа, үйлчилгээний *(ISO 20252:2019)* стандартын дагуу 2019 оны 6 –р сарын 27 –ноос 2019 оны 7 –р сарын 10 хооронд хийж гүйцэтгэлээ.

Тус тайланд дурдагдаж буй судалгааны үр дүн нь судалгаанд хамрагдсан малчид болон гол оролцогч талуудын ойлголт, мэдлэг, хандлага, туршлага дээр шууд үндэслэгдсэн гэдгийг анхаарна уу.

# СУДАЛГААНЫ ҮР ДҮН

## 1. КАР СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Малчин өрхийн бүтцийг авч үзвэл нэг өрх дунджаар 4 хүн амьдарч байгаа ба хамгийн ихдээ 11 хүн амьдарч байна. Малчин өрхийн тэргүүн дунджаар 44 настай *(хамгийн залуу өрхийн тэргүүн 18 настай, хамгийн өндөр настай өрхийн тэргүүн 85 настай)* байна. Эрэгтэй малчин өрхийн тэргүүн дунджаар 42 настай, эмэгтэй малчин өрхийн тэргүүн дунджаар 52 настай.

Малчдын нас, хүйсийн суваргаас харвал малчдын 32.1% буюу 5 малчин тутмын 2 малчин нь 31-35 насныхан, 17.9% нь буюу 10 малчин тутамд нэг 15-20 насны малчин, 11.3% буюу 10 малчин тутмын 1 нь 26-30 насныхан байна.

*График 1: Нас хүйсийн суварга*




18-аас дээш настай малчдын 62.8% буюу 5 малчин тутмын 3 нь суурь болон бүрэн дунд боловсролтой байна. Малчдын боловсролын түвшнийг харвал 31-35 насны малчдын 17.3% нь бага боловсролтой, 19.2% нь суурь боловсролтой байна.

*Хүснэгт 1: Боловсрол*

| Сонгосон үзүүлэлт | Боловсролгүй | Бага | Суурь | Бүрэн дунд | Мэргэжлийн ба техникийн | Дээд | Малчдын насны бүлэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **15-аас дээш насны малчдын боловсролын түвшин** | | | | | | | |
| 15-20 | 1.9 | 3.3 | 64.2 | 30.7 | - | - | 2.6 |
| 21-25 | 0.3 | 0.3 | 21.0 | 72.3 | 4.8 | 1.3 | 15.0 |
| 26-30 | 0.4 | 5.9 | 18.9 | 31.9 | 18.5 | 24.4 | 10.2 |
| 31-35 | 3.4 | 17.3 | 19.2 | 37.8 | 6.4 | 15.9 | 11.1 |
| 36-40 | 9.3 | 22.3 | 39.7 | 23.6 | 2.0 | 3.0 | 31.5 |
| 41-45 | 4.3 | 0.9 | 40.2 | 41.3 | 7.7 | 5.5 | 8.8 |
| 46-50 | - | 12.6 | 36.9 | 22.5 | 18.2 | 0.7 | 7.0 |
| 51-55 | - | 30.5 | 37.3 | 20.4 | 8.8 | - | 5.5 |
| 56-59 | 10.6 | 41.9 | 39.4 | 6.4 | 1.6 | - | 3.2 |
| 60-аас дээш нас | 7.6 | 66.9 | 16.8 | 1.5 | 5.6 | 1.5 | 3.3 |
| **Нийт** | **5.1** | **16.9** | **31.8** | **33.1** | **6.8** | **6.2** | **100.0** |
| **18-аас дээш насны малчдын боловсролын түвшин** | | | | | | | |
| Эрэгтэй | 7.1 | 25.0 | 31.0 | 26.9 | 5.3 | 4.7 | 52.5 |
| Эмэгтэй | 3.9 | 9.5 | 32.1 | 36.1 | 9.1 | 9.4 | 47.5 |
| **Нийт** | **5.6** | **17.6** | **31.5** | **31.3** | **7.1** | **6.9** | **100.0** |

Судалгаанд оролцогчийн өрхийн дундаж орлого 600,000 төгрөгөөс доош орлоготой өрх 60.9 хувь, 600,001 төгрөгөөс дээш орлоготой өрх 36.6 хувийг эзэлж байна.

*График 2: Судалгаанд оролцогчийн өрхийн дундаж орлого*



Нийт өрхийн 81.5 хувь нь  малтай байна. Үүнд, дунджаар 11 үхэр, 4 сарлаг, 14 адуу, 3 тэмээ, 114 хонь, 194 ямаатай байна.

*Хүснэгт 2: Малын зүй бус хорогдол, 2018 оны байдлаар Улсын статистик үзүүлэлт*

| Аймгийн нэр | Сумын нэр | Багийн нэр | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| Завхан | Их-Уул | 6-р баг, Зарт | 0.07 | 0.14 | | 0.32 | 0.33 |
| | Тосонцэнгэл | 2-р баг, Хайрхан | 0.01 | 0.01 | | 0.05 | 0.04 |
| | | 4-р баг, Рашаант | 0.05 | 0.11 | | 0.21 | 0.19 |
| Говь-Алтай | Цогт | 1-р баг, Рашаант | | | | | 0.04 |
| | | 2-р баг, Далан | 0 | 0.01 | | 0.15 | 0.3 |
| | | 3-р баг, Гэгээт | | | | | 0.18 |
| | | 4-р баг, Төгрөг | | | | | 0.23 |
| | | 5-р баг, Баян-Өндөр | | | | 0.07 | 0.09 |
| | | 6-р баг, Баян-Улаан | | | | 0.1 | 0.09 |
| | | 7-р баг, Баян тоорой | | | | | 0.13 |
| | Чандмань | 1-р баг, Чандмань-Уул | 0 | 0.01 | 0 | 0.09 | 0.26 |
| | | 2-р баг, Өлзийбулаг | 0.02 | | | 0.14 | 0.45 |
| | | 3-р баг, Эрдэнэ-Уул | 0 | 0.02 | 0.01 | 0.33 | 0.79 |
| | Эрдэнэ | 1-р баг, Сангийн далай | 0 | 0 | | 0.14 | 1.22 |
| | | 2-р баг, Цэцэг нуур | 0 | 0 | 0 | 0.07 | 3.23 |
| | | 3-р баг, Цагаан-Уул | 0 | 0 | | 0.09 | 0.77 |
| | | 4-р баг, Өлзийт | 0.05 | 0.01 | 0 | 0.13 | 1.67 |
| Баянхонгор | Баацагаан | 5-р баг, Товгор | 0.24 | 0.12 | 0 | 1.22 | 4.22 |
| | Баян-Өндөр | 1-р баг, Улаан үзүүр | 0.11 | 0.28 | | 2.14 | 4.01 |
| | | 2-р баг, Элгэн | 0.05 | 0.03 | 0.04 | 1.27 | 8.3 |
| | | 3-р баг, Булган | 0.04 | 0.02 | 0.01 | 0.31 | 1.74 |
| | Баянцагаан | 2-р баг, Дэлгэрэх | 0.05 | 0.07 | 0.03 | 8.05 | 17.92 |
| | Шинэжинст | 2-р баг, Уртын гол | 0.01 | 0.01 | 0.03 | 0.65 | 4.92 |
| | | 3-р баг, Эрдэнэшанд | 0.04 | 0.01 | 0.01 | 0.12 | 1.3 |
| | | 4-р баг, Эхэн хавцгай | 0.04 | | 0.01 | 0.38 | 1.67 |
| Архангай | Батцэнгэл | 1-р баг, Улаанчулуу | 0.26 | 0.19 | | 0.16 | 0.18 |
| | | 5-р баг, Цац | 1.1 | 0.59 | | 0.99 | 1.02 |
| | Өлзийт | 3-р баг, Байшир | 0.66 | 1.39 | 0 | 3.21 | 2.11 |
| | Хайрхан | 3-р баг, Жарантай | 2.69 | 1.24 | | 1.71 | 1.33 |
| | Эрдэнэмандал | 2-р баг, Идэр-Улаан | | 5.04 | 0 | 20.67 | 8.62 |

## 2. ӨРХИЙН АМЬЖИРГААТАЙ ХОЛБООТОЙ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Улсын хэмжээнд бодлого тодорхойлогчдын үзэж байгаагаар төслийн зорилтот сум орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахын тулд авах арга хэмжээ нь иргэд, сум орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийнхтэй ижил төстэй санал, санаачилгууд дурдагдаж байна. Тухайлбал, малын тоо толгойг бууруулж, чанарт илүү анхааран малын үүлдэр, угсааг чанаржуулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, цаашлаад бүлэг, хоршоодын зохион байгуулалтад оруулах, малчдыг нийгэмшүүлэх, мэдлэгжүүлэх зэрэг соён гэгээрэлтэй холбож байна. Өөрөөр хэлбэл, амьжиргааны түвшин сайжирвал, хүн анхдагч хэрэгцээгээ хангаж чадвал дараагийн мэдлэг, мэдээлэл боловсрол, амьдралын чанарыг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Үүнд, нүүдлийн мал аж, ахуйг сурталчлан аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол орны баялаг байгалиас эмийн ургамлын

үр ашгийн талаар мэдлэгжүүлэх, мод үржүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах зэрэг байна.

**Шигтгээ:** *Хоршооллын хэлбэрт ороод дундаа нэг сантай болоод нэг хэсэг нь ноосоо хурааж аваад, нөгөө хэсэг нь ногоо тарьдаг, бүүр нөгөө хэсэг нь тэр хавийнхаа бэлчээрийг зохион байгуулдаг болох хэрэгтэй. Багаараа нэг жилдээ голынхоо ардаа байгаад дараа жил нь голынхоо урд хэсэг рүү нүүгээд нэг жил бэлчээрээ өнжөөх байдлаар бүлгээрээ хийвэл ач холбогдолтой. Ингэж байж л эдийн засаг нь сайжирна. Мянгат малчдын хувьд мэдээж тийм хоршоололд орох нь хэцүү байж магадгүй гэвч 30-40 малтай айл хоршоололд орсноороо мэдлэг мэдээлэл олж авах бүрэн боломжтой. Амьжиргаа нь муу байгаа учраас л байгаль руу хандаж байгаа. Жишээ нь, хэн нэгэн хүн мөнгийг нь өгөөд тарвага авъя гэхэд л амьжиргааны түвшин доогуур байгаа учраас л тухайн хүн шууд байгаль уруугаа халддаг.*

БОАЖЯ, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Хангай газрын ой модтой хэсэгт амьдардаг малчид сайн дурааараа нөхөрлөл байгуулж байгаа. Эдгээр нөхөрлөлд өөрсдийнх нь амьдарч байгаа газраа 60 жил хүртэлх хугацаагаар гэрээгээр эзэмшиж авдаг. Гэхдээ давтамжтай. Эхлээд 3 жил дараа нь 15 жил түүний дараа 60 жил хүртэлх хугацаатай байдаг. Тухайн нөхөрлөлд өөрсдийнх нь амьдардаг хэсэг газрыг хариуцуулж өгснөөр тухайн хүмүүс тодорхой хэмжээний давуу эрхүүдийг эдэлдэг. Энэ нь хамтын оролцоотой ойн тогтвортой менежмент юм. Өөрөөр хэлбэл иргэдийн хяналтыг сайжруулах замаар тухайн газар нутагт хууль бус мод бэлтгэл явуулахгүй, түймэр гаргахгүй гэх мэт ойд явагдаж буй олон ажилд нутгийн иргэдийг оролцуулж түүнд хяналт тавиулах чиглэлээр хамтарч ажиллаж байгаа. Ой бол төрийн өмч. Өмчөө хамгаалуулсныхаа төлөө тухайн хүмүүст тодорхой хэмжээний урамшуулал өгдөг. Малыг ундалдаг ус, булаг шанд ойн сангаар хамгаалагдаж байдаг. Байгалиа сүйтгэвэл тухайн хүний малаа ундалдаг булгийн эх татрах учраас өөрөө байгалиа хамгаалбал ус болон бэлчээрийн өвс сайжирна. Говь дээр бол өөр байдаг. Тэнд арай өөр менежментээр үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.*

БОАЖЯ, Мэргэжилтэн, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Мал яагаад өөхөн тарга авдаг болчихов, махан тарга өөхөн тарга гэж малчид авахуулдаг байсан. Махан тарга илүү авч байж малын чанар сайжирна. Гэтэл одоо өөх бол холестрин учраас өөх идэхгүй гээд махны жингийн хэдэн хувийг хаяж байна. Харилцаа холбоо уялдаагүй юм гэж байхгүй. Мал нь чанарлаг тавaарлаг болбол малчдын ахуй амьдрал өснө.*

ТББ, Захирал, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малчдын гол орлогын эх үүсвэр нь мал аж ахуй байхад малчид ихэнхдээ ченжүүдэд махаа өгч 100 төгрөг авах байсан бол 60 төгрөг авч орлогоо бууруулдаг. Тиймээс тухайн орон нутгийн иргэдэд ойр мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, эсвэл боловсруулалтад хэрэгтэй дамжлагуудыг ойртуулах хэрэгтэй. Үндсэндээ ложистикыг нь сайн шийдэж өгөх хэрэгтэй.*

Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар, Мэргэжилтэн, Гүнзгийрүүлсэн

**Шигтгээ:** *Нүүдлийн МАА эрхлэх зан үйлтэй холбоотойгоор аялал жуулчлалаас ашиг олох боломжтой. Жишээ нь Баянхонгор аймагт тэмээний баяр гэж хийдэг болсон. Тэр баяраар нь жуулчид очиж байна. Ховдод олон үндэстэн ястны фестиваль гээд хийдэг. Тэр үеэр нь малчдын зан үйл уламжлалыг нь сонирхоод мөнгө төлнө. Малчид бол их ганцаарддаг. Хөдөө хээр 3, 4хөн айл байдаг. Хүн юм чинь нийгмийн нэг хэсэг байхыг хүснэ. Нэг байгууллагын хэсэг байх юм сан гэдэг. Тийм учраас малчдыг нийгэмшүүлэх ажилд аялал жуулчлалыг хэрэглэх нь тохиромжтой. Аялал жуулчлал бол хамгийн зөв арга. Түүнээс гадна дээр үед хоршоод гэж байдаг байсан. Хоршоод анхан шатны үйлдвэрлэл явуулж эсгий гутлаа өөрсдөө хийгээд өмсдөг байсан. Гэр ахуйн хэрэглээг хийдэг байлаа. Мал маллах дургүй сонирхолгүй бол түүнийг хүчээр хийлгэхийн оронд илүү гараад байгаа хүмүүсийг сум орон нутагт нь хоршоолол ч юм уу ЖДҮ-г хөгжүүлэх боломж байгаа. Малаа маллах нь малаа маллаад, малаас гарч байгаа бүтээгдэхүүнийг боловсруулах хэсэг бий болгох хэрэгтэй. Тэгвэл илүү зөв хөгжинө.*

ОУТХ, Менежер, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Хараад байхад сүүлийн үед малчид залхуу болсон байна. Хүлээж байгаад ноолуураа зараад хэдэн төгрөгтэй болдог. Гэтэл малаас гадна сүү цагаан идээ, арьс шир гээд олон төрлийн бүтээгдэхүүн гардаг. Сүүлийн үед малчид малаа саахаа больсон. Нэг талаас малчдыг буруутгахад хэцүү. Сүүг нь авах зах зээл байхгүй. УБ-н эргэн тойронд саалийн фирмүүд авч байна. Сум орон нутагт дээр үед завод гэж байдаг байсан. Малчид заводод сүүгээ тушааж, түүнийг боловсруулж цөцгий хийгээд, цөцгийг нь УБ хотод авч ирээд масло хийдэг байсан. Ийм бүхэл бүтэн МАА-н гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо байсан. Одоо захын жишээг аваад үзэхэд Завхан аймгийн Дөрвөлжин суманд нэг багийн малчин ямаагаа саагаад архи нэрдэг. Мөн жаахан цагаан идээ хийхэд түүнийг нь авах зах зээл байхгүй байгаа. Тэгэхээр эхний ээлжид малчид байгаа нөөц бололцоо, малаас авах ашиг шимээ бүгдийг нь авах хэрэгтэй. Нэг ямаа гэхэд ноолуур, хялгас, сүүг нь авна. Мөн арьс ширийг нь сайхан боловсруулах гээд авч болох бүх л юмаа авах хэрэгтэй. Нөгөө талаас чанарт анхаарах хэрэгтэй. Энэ жил гэхэд ноосны үнэ маш их унасан. 500-хан төгрөгөөр ноос авч яах вэ? Өдөржингөө хар халуунд 3, 4 цаг бөөн ажил болж 500 төгрөг олно. Одоо бол урамшуулал байгаа учраас 2000₮ гээд малчид ноосоо тушааж байна. Авсан ноос гэхэд чанар муутай. Тухайн бүтээгдэхүүний хэмжээнд нь урамшуулал өгөөд байгаа болохоос чанарын ялгаа ерөөсөө байхгүй болсон. Нэг талаас малчид малаас гарах бүх юмыг нь ашиглах хэрэгтэй. Нөгөө талаас төр засаг, хувийн салбарууд чанарт анхаарсан үнийн ч юм уу эдийн засгийн ажил хэрэгжүүлэхгүй бол хэтэрхий тоо уруу анхаарч байна. Ямааны тоо өсөж байгаа шалтгаан бол их хэмжээний ноолуур үйлдвэрлээд байвал ашиг нь нэмэгдээд байгаа. Сайн чанартай, ямааныхаа ноолуурыг өнгөөр ялгаад өгөхөд 2000-3000₮-р үнэтэй авбал хүмүүс тэр рүүгээ илүү хошуурна. Тэгэхгүй бол хуц, ухна бүгдийг нь нийлүүлээд дундаж үнээр нь авдаг. Энэ явуулж байгаа бодлого маань малчдыг чанар уруу анхааруулахгүй байна. Эхний удаад улс төржөөд энэ хэцүү гээд байгаа. Хэцүү ч бид үүнийг даван туулах ёстой. Тэгэхгүй бол бид малын тоог өсгөөд газар нутаг бэлчээр хамаг юмаа сүйтгээд дууслаа. Нэгдүгээрт малын гаралтай бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах, хоёрдугаарт чанар бүтээмжийг сайжруулах хэрэгтэй. Нөгөө талаас энэ зөвхөн малчдын асуудал биш. Малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо байхгүй. Тиймээс ченжүүдийн тоглолтоор л явж байна. Ерөөсөө үүнийг төрөөс ч юм уу хувийн сектор, ноос ноолуурын салбарынхан арьс ширнийхэн нийлж байгаад бэлтгэн нийлүүлэлтийн либерал зөв засаглалтай тогтолцоог бүрдүүлж өгөх хэрэгтэй. Одоогийн байгаа ХАА-н бирж ерөөсөө ажиллахгүй байгаа. Бүтэц нь маш буруу явж байгаа. Бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо бүрдээд түүхий эдээ авахад Монголоос гарч байгаа түүхий эдийг ОУ-н зах зээл дээр өрсөлдөх чадварыг сайжруулах маркетинг сайн хийх хэрэгтэй. Тэгж байж Европт манай бүтээгдэхүүн өндөр үнээр зарагдаж бид малчиддаа өндөр үнэ төлнө. Тэгэхгүй бол Говь чинь бүтээгдэхүүнээ зарж чадахгүй хамаг бэлэн бүтээгдэхүүн нь агуулахад нь хураагдаад байвал малчиндаа үнэ төлж чадахгүй учраас Хятадын ченжүүд орж ирээд бэлэн мөнгөөр цохиж аваад байна. ОУ-н зах зээл дээр бүтээгдэхүүнийг өндөр үнэ хүргэх маркетинг стратегийг төр болон хувийн салбарынхан хамтраад хийх ёстой. Малчдын орлогыг сайжруулах гэдэг бүхэл бүтэн салбарын хэмжээнд энэ бүхэн нэг том салбарыг дэмжиж явж байгаа. Бидний судалгаагаар нэг малчин эмэгтэй өдөрт 11,2 цаг, нөхөр нь 9,2 цаг ажилладаг гэж гарсан. Өдөржингөө борви бохисхийхгүй ажиллаж байгаа хүмүүс яаж тэр олон ажлыг амжуулах вэ? Салбарын хэмжээнд тогтолцоогоор нь авч үзэхгүй бол энэ малчдын орлогыг сайжруулах хэцүү. Энэ бидэнд 25 жилийн сургамж боллоо. Тус тусдаа салангид яваад байж болохгүй. Нэг баг болж ажиллах хэрэгтэй байна гэдгийг төр засгийн бодлогод тусгах л хэрэгтэй болоод байна.*

Швейцарын хөгжлийн агентлаг, Төслийн менежер, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малчдын амьдарлыг мал аж, ахуйгаас гадна дээшлүүлэх бол маш их боломж байгаа. Адаглаад монгол оронд эмийн ургамал багцаагаар 500 гаруй ургамал байгаа. Ховордож байгаа улаан номд орсон ургамлууд байгаа. Ойн нөхөн сэргээлтээр тарьж байгаа моднууд байгаа. Энэ бүгдийг малчид тариалж болно. Жишээлбэл нэг компанид тэдэн га газарт нөхөн сэргээлт хий гээд өгөөд байгаа. Малчдын нөхөрлөл гэж байгаа. Нэг уулын аманд 5-10 айл нөхөрлөл болоод амьдарч байгаа. Түүнд нөхөн сэргээлтийнхээ эрхийг өгчих юм бол тэд МАА-с гадна ажилтай болно. Гэтэл өнөөдөр хаанаас ирсэн нь мэдэгдэхгүй хэдэн хүн юм тариад явчхаар арчилгаа байхгүй учраас нөгөө зүйл нь ургахгүй. Харин тухайн газар нутагт оршин сууж байгаа 10 айлд 10газрыг нөхөн сэргээ. Үрсэлгээгээ өөрсдөө гарга гэхээр тэд хаанаас үрсэлгээ авах вэ гээд эхний 2 жилдээ явна. Дараа жилээс нь өөрсдөө боргоцойгоо түүгээд үрсэлгээгээ гаргаж ирнэ. Түүнээсээ бид 1000ш үр гаргаж аваад 100ш модоо бид тарина гээд бүх хүн орлоготой болоод амьдрал нь дээшилж болно. Мөн эмийн ургамлыг төмс байцаа тарьдаг шиг тариад байвал малчдад илүү орлогын эх үүсвэр болно.*

ТТБ, Инженер, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малчдын амьдарлыг мал аж, ахуйгаас гадна дээшлүүлэх бол маш их боломж байгаа. Адаглаад монгол оронд эмийн ургамал багцаагаар 500 гаруй ургамал байгаа. Ховордож байгаа улаан номд орсон ургамлууд байгаа. Ойн нөхөн сэргээлтээр тарьж байгаа моднууд байгаа. Энэ бүгдийг малчид тариалж болно. Жишээлбэл нэг компанид тэдэн га газарт нөхөн сэргээлт хий гээд өгөөд байгаа. Малчдын нөхөрлөл гэж байгаа. Нэг уулын аманд 5-10 айл нөхөрлөл болоод амьдарч байгаа. Түүнд нөхөн сэргээлтийнхээ эрхийг өгчих юм бол тэд МАА-с гадна ажилтай болно. Гэтэл өнөөдөр хаанаас ирсэн нь мэдэгдэхгүй хэдэн хүн юм тариад явчхаар арчилгаа байхгүй учраас нөгөө зүйл нь ургахгүй. Харин тухайн газар нутагт оршин сууж байгаа 10 айлд 10газрыг нөхөн сэргээ. Үрсэлгээгээ өөрсдөө гарга гэхээр тэд хаанаас үрсэлгээ авах вэ гээд эхний 2 жилдээ явна. Дараа жилээс нь өөрсдөө боргоцойгоо түүгээд үрсэлгээгээ гаргаж ирнэ. Түүнээсээ бид 1000ш үр гаргаж аваад 100ш модоо бид тарина гээд бүх хүн орлоготой болоод амьдрал нь дээшилж болно. Мөн эмийн ургамлыг төмс байцаа тарьдаг шиг тариад байвал малчдад илүү орлогын эх үүсвэр болно.*

ТТБ, Инженер, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Миний бодлоор эдийн засгийн хөшүүрэг байхгүй бол хэцүү. Нэг айлд очоод за та одоо мянган малаа 800 болгож бууруул бэлчээр доройтлоо гэхээр тэр хүн ойлгоод 800болгочиж болно. Гэтэл хажуугийн Дулмаа Долгорынх 800 болголгүй 1200 болголоо. Тэгэхээр нэг хүн, хэсэг хүн үүнийг хүлээж аваад нэмэргүй. Үүнийг зохицуулах менежмент хэрэгтэй. Хүмүүс нэг үеэ бодоход бэлчээр маань даахаа болилоо гээд ойлгосон. Малын хөлийн татвар гарвал бид төлөхөд бэлэн байна гэдэг. Одоо бүр аргаа бараад төсөл хөтөлбөрүүд таны мал эко соргог байгаа бол түүнээс гарах ноос, ноолуур бүгд №1 байх ёстой. Тэгвэл бид таны энэ ноос ноолуурыг бүр өндөр үнээр том баячуудын хэрэглээний Английн компани учраас өндөр үнээр авна. Та малынхаа тоог бууруулж эко ноос гаргана. Тэр алдагдсан мөнгийг бид өндөр үнээр бүтээгдэхүүнийг тань авч нөхнө гэсэн тийм хандлага ялангуяа ноолуур дээр яригдаж байгаа. Тийм зохицуулалт хийхгүй бол шууд чи очоод малаа бууруул гэж хэлж яагаад ч болохгүй. Мал бол тухайн хүний хувийн өмч. Өнөөдрийн мөрдөж байгаа хууль дүрмээр би мянган малтай байх уу хоёр мянган малтай байх уу гэдгээ би өөрөө л мэднэ. Захиргаанаас нэг хүн очоод чи хоёр мянган малаа мянга болго гэж хэлж яагаад ч болохгүй.Тэгэхээр дам аргаар зөөлөн аргаар эдийн засгийн хөшүүргийг ашиглаад, хэдэн мянган малтай хүн бэлчээр талхлаад байвал бэлчээр ашиглалтын татварыг өндөр тавих эсвэл бэлчээрээ сэлгэж ашигласан хүнд илүү урамшуулал олгох тийм зүйлсийг хийх хэрэгтэй.*

УЦУОСМХ, Хэлтсийн дарга, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Оюуны хөрөнгө оруулалтыг бүх түвшинд хийх хэрэгтэй. Малчид болон мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд болон аймаг сумдын засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн гишүүдэд сургалтуудаа чиглүүлэх хэрэгтэй. Ингэснээр тухайн орон нутгийнхаа жилийн төлөвлөгөөг гаргаж, санхүүгээ зохицуулахад шаардлагатай. Малын үржлийн ажилд маш их анхаарал хандуулж ажиллах ёстой. 1991 онд зах зээлд шилжиж мал хувьд гарснаар тооцоололтой хэрэгжиж байсан ажлууд зогссон. Малчид өөрсдөө мал үржлийн ажлаа хариуцаж байна. Ингэснээр буруу бүтэцтэй сүрэгтэй болж байна. Ихэнх айлын сүргийн бүтцийн 50-60 хувийг эр сувай мал эзэлж байна. Тиймээс малчид тухайн орон нутагт ажиллаж буй хөдөө аж ахуйн мэргэжилтэн, мал үржил хариуцсан ажилтан зэргээр сүргийн бүтцээ хянуулж шинжлэх ухааны үндэслэлтэй мал сүргээ өсгөх хэрэгтэй. Малчдаас газар ашигласны төлбөр авч сан бүрдүүлээд тухайн сангаараа мал аж ахуйн эрсдэлийг бууруулах ажилд санхүүжилт хийх ажлыг хийх шаардлагатай. Тухайн аймаг сумд дасан зохицсон малыг сайжруулагчаар ажиллуулах хэрэгтэй. Энэ төсөл маань 7 жил үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд тухайн мал сүргийг бүтэн сайжруулах боломжтой тул анхаарал өгч ажиллахыг хүсэж байна. Мөн мал эмнэлгийн үйл ажиллагааг малчид маань цаг тухайд нь мэргэжлийн байгууллагаас авах шаардлагатай.Бүлэг маань хөдөлмөрөө хоршиж ажиллах ёстой. Ингэснээр хөдөлмөрийн хуваарилалт бүтээмж сайжирна. Тус тусдаа 100 мал хариулж байхаар 2 айл нийлээд 200 мал болгоод 1 айл нь хариулах хооронд нөгөө айл нь хадлан тэжээлээ бэлдэж байх боломжтой. Ингэж байж мал аж ахуйгаас авах үр шимийг бүрэн хүртэх эрхтэй. Нэг хониноос 1,2кг ноос авах боломжтой байхад хөдөлмөрийн үр шимийг нэмэгдүүлэхгүй байснаар 800г орчим ноос авч байх жишээ их байна.*

ХХААХҮЯ, МААБХЗГ дарга, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малчдын амьжиргаа нэг үе их сайжирсан. Хотын бид нараас илүү амьдарч байгаа. Хөргөгчтэй, машинтай. Гэхдээ тэр хүмүүсийн ахуй их дорой байгаа. Нөгөө талаасаа орлогоо жилийн 12 сард хуваагаад ашиглаад, дусаад ирэхээр зээл авдаг. Ингэж л амьдарч байна. Байгаль цаг уурын байдлаас болж нүүж байна. Энэ нь маш их нөлөөлж байна. Шатахуунд их мөнгө үрж байна. Монгол улсын өрхийн эдийн засгийн орлого, зарлага хэрхэн зарцуулах тал дээр мэдлэг мэдээлэл дутуу.*

БЗАХН, Төслийн мененжер, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Мал аж ахуйгаас орж ирэх орлогыг нэмэгдүүлэх бол манай яамны үүрэг. Бид бодлогын бичиг баримтаа гаргаад тавьчихсан байгаа. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, хүнс хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, монгол мал хөтөлбөр, мал эрүүл мэндийн тухай хууль, генетикийн нөөцийн тухай хууль гэх мэт бодлогуудаа бид хангалттай боловсруулсан байгаа. Малчдын орлогыг сайжруулахын тулд бид малаа эрүүлжүүлж байгаа. Малын үржлийг сайжруулаад өгөхөөр нэг малаас 300 гр ноос гардаг байсан бол 350 болно. Тухайн малчин 100,000₮ олдог байсан бол орлого нь 5000₮ өөр нэмэгдэнэ гэх жишээтэй. Нэг хониноос 20кг гулууз гардаг байсан бол бид 22кг болгох гэж байна. Нэг кг ноосонд урамшуулал болгож 2000₮ өгч байгаа. Малчин гэдэг нь төрд ажиллаагүй хувийнхаа ажлыг хийж байгаа гэтэл төрийн зүгээс тэтгэвэр олгодог болж байна. Малчдын орлогыг нэмэгдүүлэхийн тулд төрөөс маш их зүйл хийж байгаа.*

ХХААХҮЯ, МААБХЗГА мэргэжилтэн, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Энэ нь тухайн нутгийн байгаль цаг уурын онцлогоос шалтгаална. МАА-н чиглэл бас хамааралтай. Хонины аж ахуй, тэмээний аж ахуй гэвэл өөр өөр байна. Малын бүтэц, төрөл, эрхэлж байгаа үйл ажиллагаанаасаа шалтгаална. Нэг газарт сүү цагаан идээгээ борлуулаад, нөгөө газарт сүү цагаан идээгээ боловсруулаад орлого олж байна. Говьд бол ингэний хоормогоороо орлого олдог. Эрхэлж буй ажлынхаа үйл ажиллагааны чиглэл, зах зээлийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажиллах хэрэгтэй. Бидний хувьд мөн малчдыг заавал малынхаа тоог 1000 болго гэж зөвлөдөггүй. Малын тоо 1000 болоход малчдын орлого тогтворжиж ирдэг. Тиймээс хүмүүс тэр лүү их тэмүүлж байна. Та 500 малтай байсан ч орлогоо ингэж нэмэгдүүлэх боломж байна гэж зааж өгдөг. Энэ аргуудад нь бэлчээрээ сайжруулах, эсвэл үржлийн малаа сайжруулах зэрэг ордог. Өөр янз бүрийн аргаар 500 малтайгаар ашиг шимээ нэмэгдүүлж чадвал 1000 малтай хүний олж буй орлогыг олох боломжтой арга зам байгаа гэдгийг ойлгуулж зааж өгөхийг хичээдэг. Малын чанартаа анхаарах тухай яригдахад эргээд бэлчээр тэжээлийн асуудал дээрээ очоод зогсчихдог. Энэ бол үнэхээр тэжээсэн тохиолдолд ийм байна, бэлчээрээ сайжруулсан тохиолдолд малын ашиг шим, малын онд оролт ийм сайн байна гэдгийг харуулах хэрэгтэй. Манай малчид орлогоо тооцдоггүй. Би сүүлийн үед малчин айлын бүтэн жилийн орлого зарлагыг нь тооцож, ашиг орлогын тооцоог нь бодож өгвөл зүгээр гэж бодож байна. Өнөөдөр тэдний эрхэлж буй МАА-аасаа олох орлого, ашигтай байна уу, ашиггүй байна уу гэдгийг малчид хэлж мэдэхгүй байна. Малчид зүгээр л малынхаа тоогоор бодож, малын тоо нь нэмэгдэж байвал миний орлого нэмэгдэж байгаа гэсэн байдалтай явж байна. Орлого зарлагын тооцоог нь бүтэн жилийн циклээр нь, болж өгвөл бүр 2-3 жилээр нь бодоод үнэхээр 500 малтай айл ингэж ажиллавал ашигтай байна, 1000 малтай айл ингэж ажиллавал ашигтай байна гэж малчдад зааж хэлж өгөх хэрэгтэй байна. Малчдын боловсрол тодорхой хэмжээгээр ямар байгаа билээ, бодолцож үзээд орлого зарлагаа тооцох аргыг нь зааж өгч ойлгуулвал зүгээр. Хүн л учир аливаа аж ахуйг ашиг олох гэж хийдэг тул мэдээж үүнийг сурах сонирхол бол малчдад байгаа гэж харж байна.*

МААЭШХ, Бэлчээр, тэжээлийн салбарын эрхлэгч, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малчдад зориулж манай яамнаас маш их арга хэмжээ авдаг. Малчдын нийгмийн асуудлыг хардаг. Хот хөдөөгийн ялгааг арилгахын тулд аймаг сумруу засмал зам тавьж байгаа. Хэдэн жилийн өмнө бид малчдыг хэдэн радиотой вэ? хэдэн машинтай вэ? нарны гэрэлтэй юу? гэдэг байсан бол одоо үед машин, зурагт, гар утасгүй малчин гэж байхгүй болсон. Бүх л зүйлийг бидэнтэй адилхан ашигладаг бараг биднээс илүү мэдээлэл авч байгаа. Малчдыг 55 настай тэтгэвэрт гаргадаг болгосон. Ноосны урамшуулал өгдөг. Тэмээ, хонь, сүүнд улсаас урамшуулал өгдөг. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилгоор улсаас тоног төхөөрөмж гаднаас оруулж ирж хөнгөлөлттэй үнээр өгдөг.*

ХХААХҮЯ, МААБХЗГА мэргэжилтэн, Гүнзгийрүүлсэн ярилцлага

## 3. БЭЛЧЭЭР, БЭЛЧЭЭРИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА

Уг бүлгээр төсөл хэрэгжих 4 аймгийн 13 сумын малчин өрхийн бэлчээрийн талаарх ойлголт, бэлчээрт хандах хандлага, бэлчээрийн онцлог, бэлчээрийн ашиг шим, бэлчээрт тулгамдаж буй асуудал, бэлчээрийн доройтлын түвшин, шалтгаан, түүнээс гарах арга зам, хэрхэн хамгаалах цаашид зүй зохистой ашиглах зэрэг асуудалд хандаж буй малчдын хандлага, туршлагыг тодорхойлох зорилготой болно.

Малчин өрхийн хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголт нь сум болон аймгаар харьцуулахад төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна. Говь-Алтай, Завхан, Архангай аймгийн малчин өрхийн хувьд бэлчээрийн даац хэтрэхийг 50-аас дээш хувь нь бэлчээрийн доройтол хэмээн нэрлэж байсан бол Баянхонгор аймгийн малчдын хувьд бэлчээрийн даац хэтрэх гэх тодорхойлолтоос ус ургамалгүй болох гэсэн үзүүлэлтийг 2.3 пунктээр илүү нэрлэсэн байна.

*График 3: Бэлчээрийн доройтлыг илэрхийлэх үзүүлэлтүүд, аймаг тус бүрээр, хувиар*




Баянхонгор аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголтыг сумаар нь ангилан харвал Баацагаан сумын малчдын 62.2 хувь нь, Баянцагаан сумын 58.3 хувь, Шинэжинст сумын

40.8 хувь нь тус, тус ус ургамалгүй болох гэсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байгаа бол Баян-Өндөр сумын малчдын хувьд 48.9 хувь нь бэлчээрийн даац хэтрэх гэж үзэж байна. Доорх графикаас харахад ус ургамалгүй болж (45.6%), бэлчээрийн даац хэтрэн (44.2%), ган/ зудад нэрвэгдэж (32.6%), бэлчээр талхлагдаад ургац эрс багасахыг (28.3%) Баянхонгор аймгийн малчид бэлчээрийн доройтол гэж үздэг байна.

*График 4: Баянхонгор аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар*




Архангай аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголтыг сумаар нь ангилан харвал Батцэнгэл сумын малчдын 51.9 хувь нь, Өлзийт сумын малчдын 65.3 хувь, Хайрхан сумын 53.2 хувь, Эрдэнэмандал сумын малчдын 55.3 хувь нь тус, тус бэлчээрийн даац хэтрэх гэж үзэж байна. Архангай аймгийн 4 сумын хувьд бэлчээрийн доройтлын талаарх ойлголт нэг байгаа нь харагдаж байна.

*График 5: Архангай аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар*




Завхан аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголтыг сумаар нь ангилан харвал Их-Уул сумын малчдын 63.6 хувь нь, Тосонцэнгэл сумын малчдын 49.7 хувь нь тус, тус бэлчээрийн даац хэтрэх гэж үзэж байна. Завхан аймгийн 2 сумын хувьд бэлчээрийн доройтлын талаарх ойлголт нэг байгаа нь харагдаж байна.

*График 6: Завхан аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар*




Говь-Алтай аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголтыг сумаар нь ангилан харвал Чандмань сумын малчдын 50.0 хувь нь, Эрдэнэ сумын малчдын 70.7 хувь нь тус, тус бэлчээрийн даац хэтрэх гэж үзэж байна. Харин Цогт сумын малчдын хувьд 57.7 хувь нь ус ургамалгүй болохыг бэлчээрийн даац хэтрэх гэж үзсэн байна.

*График 7: Говь-Алтай аймгийн малчдын бэлчээрийн доройтлын талаарх ойлголт, сумаар*




Харин тус үзүүлэлтийг сумын төвийн болон хөдөөгийн малчин өрхөөр ангилан харвал сумын төвийн малчид ган, зуд болох гэсэн үзүүлэлтээс бусдыг хөдөөгийн малчин өрхүүдээс илүү

нэрлэсэн байна. Энэ нь сумын төвийнхөн бэлчээрийн доройтлын шалтгааныг илүү олон үзүүлэлтээс олон ургалч байдлаар харж байна гэж болохоор байна.

*График 8: Бэлчээрийн доройтлыг илэрхийлэх үзүүлэлтүүд, хөдөө, сумын төв болон хувиар*




Дээрх үзүүлэлтээс харахад малчин өрхийн хувьд бэлчээрийн доройтол гэж бэлчээрийн даац хэтрэхийг ойлгодог байна. Энэ ойлголт нь сумын төв хөдөөгийн малчин болон амьдарч буй орон нутгаас үл хамаарч байна.

Малчин өрхийн хувьд бэлчээртэй холбоотой үүний дотор бэлчээрийн доройтол тулгамдсан асуудал мөн эсэх, бэлчээрийн доройтлын бий болгож буй шалтгаан, бэлчээрийн доройтлыг бууруулах талаар шийдвэрлэх боломж гэсэн гурван чиглэлээр хандлагыг тодорхойлохыг зорьсон.

Хандлагын эхний хэсэг болох бэлчээрийн доройтлыг малчин өрхийн хувьд тулгамдсан асуудал мөн эсэхийг тодорхойлоход сум болон хөдөөгийн малчин өрх, аймаг сум, орон нутгийн онцлог зэргээс үл хамааран 96.1 хувь нь бэлчээр нь манай өрхийн амьдрал ахуйд чухал ач холбогдолтой гэсэн байна. Мөн сум орон нутгийнхаа хамгийн их тулгамдаж байгаа асуудал мөн хэмээн 91.9 хувь нь үзэж байсан ба бэлчээрийн доройтлыг бууруулахгүй бол байгалийн тэнцвэрт байдал алдагдана гэж 95.4 хувь нь үзэж байна.

Мөн малчид бэлчээрийн доройтол тулгамдсан асуудал мөн бөгөөд бууруулах шаардлагатайг мэдэж байгаа ч юу хийх, ямар арга хэмжээ авахаа 87.0 хувь нь мэдэхгүй байна. Нөгөөтээгүүр өрхөд тулгамдаж буй бусад асуудлаасаа дээгүүрт тавьж энэ тал дээр юу хийх, яаж бэлчээрийн доройтлыг бууруулахад амьдрал ахуйдаа анхаарч ажиллахад бэлэн байна. Өөрөөр хэлбэл бэлчээрийн доройтлыг бууруулах нь малчдын хувьд нэн тэргүүний тулгамдсан асуудал бөгөөд амьдрал ахуй нь бэлчээрээс шууд хамааралтайг мэддэг бөгөөд хэрхэн энэ асуудлаас гарах, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд юу хийх ёстойгоо мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

*График 9: Бэлчээрийн доройтол нь тулгамдсан асуудал мөн эсэхийг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар*




Хандлага тодорхойлох дараагийн хэсэгт бэлчээрийн доройтлын шалтгааныг малчин өрх хүний үйл ажиллагаатай холбон, нөгөө талаас байгалийн жам ёсны хуультай холбон, зэрэгцүүлээд төр засгийн үйл ажиллагаатай холбон тодорхойлсон.

Бэлчээрийн доройтлын шалтгааныг цаг агаарын өөрчлөлт, дэлхийн дулаарал хур тунадас багассантай холбон 92.4 хувь нь буюу хамгийн өндөр хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Үүний дараагаар бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна гэдэгтэй 85.6 хувь нь санал нийлсэн байна. Малчдаас өөрсдөөс нь шалтгаалсан буюу зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж бэлчээр доройтсон гэдэгтэй 70.0 хувь нь санал нийлсэн байна. Дээр дурдсанчлан бэлчээрийн доройтол гэдэг нь бэлчээрийн даац хэтрэх гэж 51.4 хувь нь нэрлэж байсан бол үүний шалтгааныг цаг агаарын өөрчлөлттэй холбон ойлгодог байх нь. Өөрөөр хэлбэл, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан хур тунадас багасан малчид худаг, усаа бараадах болон аймаг, сумын төв үйлчилгээтэй холбоотойгоор нэг дор төвлөрөн нутагладаг болсон нь бэлчээрийн даац хэтрүүлэн бэлчээр доройтоход хүргэж байна гэж харж болохоор байна.

Сумын төв хөдөөгийн малчдын хувьд хамгийн өндөр зөрүүтэй үзүүлэлт нь бэлчээрийн доройтлын шалтгааныг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан гэж хандлага байна. Өөрөөр хэлбэл,

сумын төвийн малчид хөдөөгийн малчдаас даруй 4.0 пунктээр илүү уг хандлагатай санал нийлсэн байна.

*График 10: Бэлчээрийн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор сумын төв, хөдөөгийн малчин өрх болон, хувиар*




Завхан аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтлын шалтгааныг төр засагтай холбон 96.0 хувь нь мөн хүний үйл ажиллагаатай холбон 85.9 хувь нь үзэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Хүний үйл ажиллагаанаас шалтгаалж бэлчээрийн доройтол үүссэн гэж Архангай аймгийн малчин өрхийн 73.9 хувь нь санал нийлж байгаа нь хамгийн бага санал нийлж байгаа үзүүлэлт болж байна.

*График 11: Бэлчээрийн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар*




Бэлчээрийн доройтлыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа шийдвэрлэх боломжийн хандлагыг тодорхойлох зорилгоор 6 төрлийн тодорхойлолтыг ашигласан. Бэлчээрийн доройтлоор бэлчээрийн даац хэтрэхийг нэрлэсэн малчид бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малаас авах ашиг шимээ нэмэгдүүлэн малын тоо толгойг цөөрүүлнэ гэдэгтэй 84.0 хувь нь санал нийлж байгаа бол сум орон нутгийн удирдлагаас бэлчээрийн менежментийн арга хэмжээг бэлчээр ашиглалтын хэсэг байгуулахыг дэмжин зохион байгуулснаар бэлчээрийн доройтлыг бууруулна гэдэгтэй 91.1 хувь нь санал нийлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. Өөрөөр хэлбэл, сум орон нутгийн

удирдлага дор бэлчээр ашиглах зохион байгуулалтад орж бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой ба хуваарилалтад орох нь хамгийн зөв арга зам хэмээн үзэж байна.

Бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой гэж малчдын 83.1 хувь нь үзэж байгаа бол уг хандлагад сумын төвийн малчид хөдөөгийн малчдаас 2.9 пунктээр илүү санал нийлсэн байна.

Малчдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахад хүний нөлөө заавал байх ёстой энэ чиглэлээр малынхаа тоог бууруулах замаар оролцоход бэлэн байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Учир нь бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй (59.5 хувь), бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар нөхөн сэргээгдэнэ, үүнд хүний оролцоо огт хэрэггүй (40.0 хувь) гэх хандлагуудтай хамгийн бага санал нийлсэн үр дүн гарсан байна.

Мөн нөгөөтэзгүүр, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй 79.9 хувь нь санал нийлсэн байна. Тус үзүүлэлт Баянхонгор болон Архангай аймагт 83.8 хувь байгаа бол Завхан, Говь-Алтай аймагт 76.8 хувьтай байгаа юм.

*График 12: Бэлчээрийн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор хөдөө болон сумын төвийн малчин өрхөөр, хувиар*




Баянхонгор аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой гэдэгтэй 82.1 хувь нь санал нийлж байгаа нь бусад аймгийг бодвол хамгийн бага үзүүлэлт ба хамгийн ихээр санал нийлсэн Завхан аймгийн малчидтай харьцуулахад 10.2 пунктээр бага байгаа юм.

Харин Архангай аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй гэдэгтэй 48.2 хувь нь санал нийлж байгаа нь бусад аймгийг бодвол хамгийн бага үзүүлэлт ба хамгийн ихээр санал нийлсэн Говь-Алтай аймгийн малчидтай харьцуулахад 11.2 пунктээр бага байгаа юм. Мөн Архангай аймгийн малчдын хувьд орон

нутгийн удирдлагаас бэлчээрийн менежментийн арга хэмжээг бэлчээр ашиглалтын хэсэг байгуулахыг дэмжин зохион байгуулалтад орж ажиллана (94.6 хувь), бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой (86.0 хувь) зэрэг үзүүлэлтүүдтэй хамгийн их санал нийлж байна. Эсрэгээрээ тус аймгийн малчид бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар нөхөн сэргээгдэнэ, үүнд хүний оролцоо хэрэггүй гэдэгтэй 39.6 хувь нь санал нийлж байгаа нь хамгийн бага үзүүлэлт байгаа юм. Нэг үгээр хэлбэл Архангай аймгийн малчид хамгийн удирдлагын зүгээс ч тэр, өөрсдийн зүгээс ч тэр бэлчээрийн доройтлыг бууруулахад аль, аль талаасаа хамтран ажиллахад бэлэн буюу хамгийн эерэг хандлагатай байгаа юм.

Говь-Алтай аймгийнхны хувьд бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар нөхөн сэргээгдэнэ гэсэн хандлагатай хамгийн их буюу 55.7 хувь нь санал нийлсэн байна. Мөн тус аймгийн малчдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй гэсдэгтэй 74.3 хувь буюу хамгийн ихээр санал нийлсэн байна. Энэ нь тус аймгийн малчид өөрсдөөсөө шалтгаалах зүйлсийг бус байгалийн хуулийн дагуу бэлчээрийн доройтол буурна гэх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

*График 13: Бэлчээрийн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар*




Олон жилийн турш хөгжиж өнөөгийн өнгө төрх нь бүрэлдсэн байгалийн тогтолцоо, амьд биесийн оршин буй нөхцөл бэлчээрийн бүтэц ба орчны нөхцөл байдал, хүчин зүйлсийн нэгдлийг бэлчээрийн онцлог хэмээн ойлгож болно. Амьдарч буй орон нутгийнхаа бэлчээрийн онцлогийг малчид хэрхэн тодорхойлсныг төсөл хэрэгжиж буй 4 аймгийн хүрээнд тус тусад нь гаргасан болно. Үүнд:

### *Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог*

Баянхонгор аймгийн малчдын хувьд говийн бэлчээр гэж 68.8 хувь нь үзсэн байна. Үүний дараагаар уулархаг хээр (38.4 хувь), нарийн өвстэй (35.8 хувь), бут сөөглөг ургамал зонхилсон (19.3 хувь) гэж тус, тус нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, Баянхонгор аймгийн төсөл хэрэгжих 4 сум буюу Баацагаан, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст сумууд говийн уулархаг нарийн ширхэгтэй өвстэй, бут сөөглөг ургамал зонхилсон бэлчээр байгаа юм.

*График 14: Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог, хувиар*




*Зураг 1: Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог*



Сумын төвийн болон хөдөөгийн малчдын хувьд бэлчээрийн онцлогийн талаар зөрүү их байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн 4 сумын хувьд хамгийн том онцлог болох говийн бэлчээр гэх тодорхойлолтыг сумын төвийн малчид хөдөөгийн малчдаас даруй 10.0 пунктээр их нэрлэсэн байна. Бусад бүх онцлогийг хөдөөгийн малчид сумын төвийнхнөөс илүү нэрлэсэн байна.

*График 15: Баянхонгор аймгийн бэлчээрийн онцлог, сум болон хөдөө, хувиар*




Баянхонгор аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд малчдын дурдсан сум орон нутагт тулгамдаж буй асуудал, бэлчээрийн доройтлын шалтгаан зэрэгтэй санал нэг байгаа нь чанарын судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, тэд малчидтай мөн ижлээр сум орон нутагтаа тулгамдаж буй асуудлаа бэлчээрийн доройтлоор нэрлэж, шалтгааныг нь малын тоо толгойн өсөлт, уур амьсгалын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байна.

**Шигтгээ:** *Цаг агаарын нөхцөл байдлаас болж хур тунадас орохгүй байна. Бэлчээрийн доройтолд маш их өртөж байна. Малын тоо бас их өсөж байна. Малын чанарт их анхаарах хэрэгтэй. Бэлчээрийн доройтолд 60% байгаа.*

**Шигтгээ:** *Хур бороо багассан. Бэлчээрийн даацаас хэтэрсэн хэт олон малтай. Хуучин цагт бол Бөөрийн хөндий гээд сайхан өвөлжөөг ганцхан хүн эзэмшдэг эхнээсээ адагтаа хүртэл 4, 5-н өвөлжөөтэй сэлгэж буудаг байсан. Бэлчээрээ доройтуулахгүйн тулд өвсний 20-30% нь байгальдаа үлдэж байх ёстой юм байна шүү дээ тэгж байж дараагийнх нь ургах боломжтой гэсэн судалгаа байдаг юм байна. Тэгэхэд манайд бол одоо тэрийг тартагт нь тултал нь идээд юу ч үгүй болтол идэж байгаа. Бөөрийн хөндийг ганцхан хүн эзэмшиж байсан бол тэрний хүүхэд, хүүхдийн хүүхэд тойруулаад нэг өвөлжөө бариад л нэг айл амьдрахын тулд хамгийн доод тал нь 400, 500-н малтай тэгээд мянган малтай байж хүний дайтай амьдрах гэдэг. Мал хэт өссөнөөс болж л доройтол явагдаад байгаа юм.*

Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Гол шалтгаан нь байгаль цаг уурын эрсдэлд байдал нөлөөлж байна. Хур бороо орохгүй байна. Мөн өвөлдөө дулаахан, зун нь маш сэрүүхэн болоод гардаг ургамлууд гүйцэд гарч чадахгүй байна. Бас малын тоо толгой нэмэгдсэнтэй холбоотой.*

Баянхонгор аймаг, Баянцагаан сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Ер нь сүүлийн үед онц ажиглагдаж эхэлж байна. Говийн энэ цөлөрхөг бүс нутгийн хувьд хур тунадас орох давтамж багасаж хуурайшилт ихсэх асуудал хэзээнээсээ байсан. Энэ давтамж бүр ойртож магадгүй 2-3 жил давтагдах хандлага руу чиглэж байна. Баянхонгор аймгийн өмнө талын хэдхэн сум байна. Манай нутгаар ойрын 2-3 жил гантай байгаа. Бэлчээрийн доройтолд маш их өртөж байна.*

Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

Баянхонгор аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам нь малчдынхтай ижил малын тоо толгойг бууруулах, малын чанар, чанартай цөөн тооны малтай болох, бэлчээрийг хашиж хамгаалах, бэлчээрийг сэлгэж ашиглах зэрэг байна. Үүнээс гадна, ажлын байрыг нэмэгдүүлэх, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах, сумын бүх багийн малчдыг бэлчээр ашиглалтын хэсгийн зохион байгуулалтад оруулах зэрэг ажлуудыг хийх шаардлагатай гэж хэлсэн байна.

**Шигтгээ:** *Бид байгальтай харьцах шинэ хандлага бий болохоос өөр аргагүй болсон байна. ШУ-ы байгууллагаас бэлчээрийг хэвээр нь хадгалах горимыг хэвийн байлгах талаар зайлшгүй арга хэмжээ авах шаардлага бий болж байна. Тухайлбал зориудаар хур тунадас оруулах, булаг шанднуудыг хаших урсац усыг нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ байж болно. Чийгшүүлэх арга хэмжээ бол зайлшгүй шаардлагатай. Тогтоол усаар хөв цөөрөм байгуулах гэх мэтчилэн аль болох ШУ-ы байгууллага талаасаа иймэрхүү юм хийх шаардлагатай юм шиг байна. Нөгөө талд нь энд ажиллаж амьдарч байгаа хүмүүс бодох шаардлагатай. Яагаад вэ гэвэл бэлчээрийн доройтол, хуурайшилтыг бий болгож байгаа зүйлсдээ дүн шинжилгээ хийх шаардлагатай байна. Мянган мал хариулаад бэлчээрийг доройтуулаад талхагдалд оруулаад хуурайшилт бий болгоод хур тунадас орохгүй байх дам нөлөөнд оруулаад байх юм уу эсвэл мянган малаасаа таван зуу болгочход ашиг шимийг нь бас тодорхой хэмжээний ашиг шим аваад байх тэр үйл ажиллагаа руу анхаарлаа хандуулах шаардлагатай. Цаашдаа бол би нанотехнологи гээд янз бүрийн юм ярьж байна. Эдгээрийг хийх хамгийн шаардлагатай гэж бодож байна.*

**Шигтгээ:** *Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд нөхөн сэргээх талын олон ажлуудыг хийхээр төлөвлөөд явж байгаа ч үр дүнд хүрсэн ажил алга байна. Одоо Ногоон Алт гээд бэлчээрийн менежментийг сайжруулах төсөлд санал тавьж байгаа. Манай суманд үндсэндээ хэрэгжиж эхэлж байна, бэлчээрийн менежментийг зохион байгуулалтад оруулж эхэлж байна. Гэхдээ дур зоргоороо явж байсан малчин Ийм зохион байгуулалтад орж ирэхээр газрын хуваарилалт хийхээр чиний, миний болоод зөрүүд зангууд их байна. Тиймээс малчид, ард иргэдийн сэтгэлийг хамгийн гол нь хандлагыг өөрчлөх хэрэгтэй, ухамсарт суулгаж өгөх хэрэгтэй.*

Баянхонгор аймаг, Баянцагаан сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Ажлын байрыг нэмэгдүүлж малыг эдийн засгийн эргэлтэд оруулах хэрэгтэй байгаа. Манай энд эдийн засгийн эргэлтэд орж байгаа цорын ганц юм бол ямаа, ямааны ноолуур байгаа юм. Хаварт нь ноолуур намарт нь арьсыг нь өгдөг. Хонины нэхий, хонины ноос ямар үнэтэй билээ. Тиймээс хонь өсгөсөн юм байхгүй, хэт ганц ашигтай мал буюу ямаагаа өсгөснөөс болоод ямаа чинь өөрөө цэцгийг нь түүгээд идчихдэг мал шүү дээ. Өөр бусад малыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой болгох хэрэгтэй байгаа юм.*

Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малыг эдийн засагт оруулах хэрэгтэй ч малчид малын тоог бууруулах дургүй. Учир нь амьжиргаатай холбоотой. Бэлчээрийг хариуцлагын журмын дагуу ашиглах хэрэгтэй. Бэлчээрийн төлбөртэй болгож, эргээд тэр мөнгийг нөхөн сэргэлтэд ашиглах шаардлагатай байна.*

Баянхонгор аймаг, Баацагаан сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

## *Архангай аймгийн бэлчээрийн онцлог*

Архангай аймгийн малчдын хувьд уулархаг хээрийн бэлчээр гэж 65.3 хувь нь үзсэн байна. Үүний дараагаар ойт хээр (22.1 хувь), хээр (12.6 хувь) гэж тус, тус нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, Архангай аймгийн төсөл хэрэгжих 4 сум буюу Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал сумдын бэлчээрийн онцлог нь уулархаг, ойт хээр байгаа юм.

*График 16: Архангай аймгийн бэлчээрийн онцлог, хувиар*




*Зураг 2: Архангай аймгийн бэлчээрийн онцлог*



Сумын төвийн болон хөдөөгийн малчдын хувьд бэлчээрийн онцлогийн талаар зөрүү хээрийн бүс гэсэн үзүүлэлт дээр их байна. Өөрөөр хэлбэл, тухайн үзүүлэлтийг сумын төвийнхөн хөдөөгийнхнөөс 17.3 пунктээр илүү нэрлэсэн байна. Мөн хээрийн бүс гэж сумын төвийнхөн, хөдөөгийнхнөөс 7.3 пунктээр илүү нэрлэсэн байгаа юм. Энэ нь сумын төвүүд нь уул, модоор хүрээлэгдээгүй байгааг харуулж байна. Бусад бүх онцлогийн хувьд төдийлөн зөрүүтэй ойлголт харагдахгүй байна.

*График 17: Архангай аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар*



Архангай аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд малчдын дурдсан сум орон нутагт тулгамдаж буй асуудал, бэлчээрийн доройтлын шалтгаан зэрэгтэй санал нэг байгаа нь чанарын судалгааны үр дүнгээс харагдаж байна. Бэлчээрийн доройтлын шалтгааныг нь малын тоо толгойн өсөлт, малчид иргэдийн ухамсар, хандлага, дадалтай холбон тайлбарлаж холбон тайлбарлаж байна. Мөн Баянхонгор аймгийн удирдлагуудын нэрлэснээс өөр шалтгаанууд байгаа юм. Үүнд, бэлчээрийн доройтлын шалтгааныг малчдын ухамсартай холбон тайлбарлах, цаг уурын өөрчлөлтийг их дурдаж байгаа ч энэ нь эсрэгээрээ хур тунадас их байгааг, түүнчлэн үлийн цагаан оготны ихсэлттэй холбон харж байгаа юм.

**Шигтгээ:** *Манай сум 400 гаруй сая толгой малтай. Малын тоо толгой маш их болсон. Малын чанар их алдагдаж байна. Бэлчээрийн даац их хэтэрсэн. Бэлчээрийн доройтолд 2-5 дахин хэтэрсэн байгаа.*

Архангай аймаг, Батцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Миний судалснаар бэлчээрийн хувиарлалтад улирал хамаарахаа больсон. Сумдын засаг зарга нар зохицуулж чадахгүй байна, хууль эрхзүйн мэдлэг мэдээлэл маш муу, иргэдийн хэлснээр л явдаг. Үлийн цагаан оготно ихсэж байна. Бэлчээрийн даац ихтэй байна. Мал их хэмжээгээр өсөж байна. Иргэдийн ухамсар их дорой, байгальтай хандах хандлага маш муу байна.*

Архангай аймаг, Эрдэнэмандал сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Сум орон нутагт олон асуудал байгаа. 1. Манай сум 4464000га ойн сантай байсан. 2008 оны ойн зохион байгуулалтаар судлаад үзэхэд 2199000га болж ойн талбай буурсан байгаа. 2.Бэлчээрийн асуудал байгаа. Манайд судалгаагаар бэлчээрийн доройтол 5-7 дахин ихэссэн байна. Хуучин судалгаагаар манай суманд 75000 толгой малтай байх ёстой гэж гарсан харин одоо малын тоо толгой 300000 гарч байна. Тэгэхээр 3-5 дахин ихэссэн гэж үзэж болно. Байгалийн гамшиг, хүмүүсийн байгальтай зүй бусаар харьцах байдал, хортон шавьж, цаг уур, ган бас нөлөөлж байна. Байгаль цаг уур нөлөөлнө. Малчдын бэлчээрийг зөв зохистой ашиглах, бэлчээртэй холбоотой мэдлэг дутмаг байна. Сургалт явуулах хэрэгтэй.*

Архангай аймаг, Өлзийт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийн доройтол сумын хувьд 11 хувиар ихэссэн. Энэ жилийн хувьд бороо хур ихтэй харьцангүй гайгүй байгаа боловч 11 хувь гэдэг нь нэг малын өвс тэжээлээр 11 мал амь зогоож байна гэсэн үг юм. Бэлчээр маш их доройтсон. Байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдсан, дэлхийн дулааралтай их холбоотой гэж үзэж байна. Малын тоо толгой хэт их өссөнөөс мөн хамааралтай. 30 орчим жилийн өмнө 40,000 орчим малтай байсан буюу 30 орчим жилийн дотор 10 дахин малын тоо толгойг өсгөсөн. Ган зудын давтамж мөн ойртож байгаа нь бэлчээрийн доройтолд орох гол шалтгаан болж байгаа.*

Архангай аймаг, Хайрхан сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

Архангай аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам нь малчдынхтай ижил малын тоо толгойг бууруулах, малын чанар, чанартай цөөн тооны малтай болох, бэлчээрийг хашиж хамгаалах, бэлчээрийг сэлгэж ашиглах зэрэг байна. Үүнээс гадна, иргэдийн ухамсар, мэдлэг, туршлагад анхаарч ажиллах шаардлагатайг бараг бүх ярилцлагад оролцогчид дурдаж байгаа нь маш том давуу тал юм. Мөн бэлчээрийн чанар бүх хүний амьдралд нөлөөлдөг тул тодорхой хэмжээний хууль эрх зүйн үндэстэй, төрийн бодлоготой уялдаа холбоотойгоор бүсчлэн татвар авах, авсан татвараа бэлчээрийн доройтлыг бууруулахад зориулж байх гэсэн санаа олон давтагдаж байгаа нь Архангай аймгийн удирдлага болон мэргэжилтнүүд татварын асуудал болон хуулийн зохицуулалт зэрэгт сэтгэл зүйн бэлтгэлтэй байгаа нь харагдаж байна.

**Шигтгээ:** *Хүн болгонд бэлчээрийн доройтол сөрөг нөлөөлдөг. Малын тоо толгой их байгаа боловч иргэдэд өгөх ашиг их буурч байна. Бэлчээрээ сэлгэх, уламжлалт аргаа сэргээх, бэлчээрээ хувиартай ашиглах хэрэгтэй. Иргэдэд сургалт сурталчилгаа хийх хэрэгтэй гэж боддог. Миний хувьд хууль, хүний эрхийг нэгдүгээрт тавиад байгаа болохоор, өсгөж байгаа мал нь тавaарлаг байдалтай байх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, хүн, хүний амьдрах орчин чухал учраас цөөн чанартай малтай болж байж бэлчээр дээрдэнэ.*

Архангай аймаг, Батцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Багуудад бэлчээрийн хуваарилалт, бэлчээр усжуулалт сайн хийх хэрэгтэй. Малын тоо толгойд хяналт тавих ёстой. Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх ёстой.*

Архангай аймаг, Эрдэнэмандал сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Малын тоо толгойг бууруулах, бэлчээрийг ээлж сэлгээтэй ашиглах, хамгаалах. Төрийн хэмжээнд малын хуулийн татварыг шатлалтай тогтоох хэрэгтэй. Энийг холбогдох газруудад би уулзах болгондоо санал тавьдаг. Доройтлыг бууруулах зорилгоор аймаг, сумын зүгээс тодорхой хэмжээний арга хэмжээ авч байгаа. Бэлчээрийг чөлөөлөх талаар малчдыг бүлэглэл, баг болгож байна.Зун 2,3 сар чөлөөлъе мөн байгаль орчиноо сэргээе гээд их зүйл ярьж байна. Саяхан аймгийн бэлчээрийн мэргэжилтэн ирээд баг болгон дээр сургалт хийсэн. Малчдын хэлж байгаа зүйл юу вэ? гэхээр бид нар одоо хаашаа нүүх вэ? гэдэг асуудал байна.*

Архангай аймаг, Өлзийт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийн нөхөн сэргээх ажлууд шаардлагатай. Мөн бусад аймаг сумдын сайн туршлагуудыг танилцуулах, хэрэгжилтэд туслах зэрэг арга хэмжээнүүд хэрэгтэй байна. Малын тоо толгойг бууруулж чанаржуулах хэрэгтэй. Төр засгийн бодлого тодорхой болох хэрэгтэй. Малчдыг малын тоо толгойгоор дүгнэхээ болих хэрэгтэй. Хэтэрхий малын тоо толгойн хойноос хөөцөлдөж болохгүй. Мөн малын тоо толгойг бууруулахын тулд малын хөлийн татварыг авч бэлчээрийг сайжруулахад ашиглах хэрэгтэй.*

Архангай аймаг, Хайрхан, Гүнзгийрүүлсэн ярилцлага

### *Завхан аймгийн бэлчээрийн онцлог*

Завхан аймгийн малчдын хувьд уулархаг хээрийн бэлчээр гэж 88.3 хувь нь үзсэн байна. Үүний дараагаар ойт хээр гэж 29.0 хувь нь нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, Завхан аймгийн төсөл хэрэгжих 2 сум буюу Их-Уул, Тосонцэнгэл сумдын бэлчээрийн онцлог нь уулархаг, ойт хээр байгаа юм.

*График 18: Завхан аймгийн бэлчээрийн онцлог, хувиар*




*Зураг 3: Завхан аймгийн бэлчээрийн онцлог*









Сумын төвийн болон хөдөөгийн малчдын хувьд бэлчээрийн онцлогийн талаар зөрүү ойт хээрийн бүс гэсэн үзүүлэлт дээр их байна. Өөрөөр хэлбэл, тухайн үзүүлэлтийг сумын төвийнхөн хөдөөгийнхнөөс 8.7 пунктээр илүү нэрлэсэн байна. Энэ нь сумын төвүүд нь модондоо ойр болохыг харуулж байна. Бусад бүх онцлогийн хувьд төдийлөн зөрүүтэй үзүүлэлт харагдахгүй байна.

*График 19: Завхан аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар*



Завхан аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлын шалтгааныг малын тоо толгойн хэт өсөлт болон үлийн цагаан оготнотой хамааруулан үзэж байна. Үлийн цагаан оготно Их-Уул сумаас илүү тоогоор Тосонцэнгэл сумын бэлчээрт сөрөг нөлөө үзүүлж байгааг бараг бүх оролцогчид дурдаж байна. Энэ нь тэдний мэдлэг дутуу байгаагийн илрэл байж болох юм. Учир нь үлийн цагаан оготно бэлчээрийн шинэчлэл хийж байдаг амьтан юм. Мөн цаг уурын өөрчлөлт, хуурайшилт бэлчээрийн доройтолд нөлөөлж байгааг дурдаад, малчид өмнөхөөсөө залхуу болж отор нүүдэл хийж бэлчээрээ сэлгэдэггүй болох нь тэдний ярианаас анзаарагдлаа.

Завхан аймгийн 2 сумын удирдлагуудын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малын тоо толгойг бууруулж, чанаржуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, бүх оролцогчдоос бэлчээр сэлгэх нүүдлийг хийх шаардлагатай гэсэн санаа гарч байсан юм.

**Шигтгээ:** *Бэлчээрийн даац 3-4 дахин хэтэрсэн. Оготно ихээр нэмэгдсэн болон цөлжилт ихэссэнээс болоод бэлчээрийн доройтолд ихээр өртөж байна. Мөн гол шалтгаан бол цаг уурын өөрчлөлт. Мөн энэ өөрчлөгдөж буй цаг уурт малчид малын тоо толгойгоо тааруулж зөв бэлчээх мэдлэг дутмаг байна. Малчдын отор нүүдлийн ажил багассан.*

Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Ой газрын гүний усыг дээшээ татаж байдаг. Манайд ой эрс багассанаас болж бэлчээрийн даац хэтэрсэн. Цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор хуурайшилт ихэсч, мал сүрэг их өссөн нь ч мөн адил нөлөөлсөн. Үүнээс гадна, цөлжилт, хүний буруутай үйл ажиллагаа, цаг агаарын хуурайшилт зэргээс болж ургамлын ургах чадвар муудаж байна. Үлийн цагаан оготноос бас болж байна.*

Завхан аймаг, Их-Уул сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрээ зохистой ашиглах нөхөн сэргээх ямар арга байгааг судлах орон нутгаас дэмжих, экологийн боловсролыг ЕБС-д оруулах, байгалтай зөв зохистой харьцах хандлагыг иргэдэд төлөвшүүлэх шаардлагатай. Ингэж байж бэлчээрийн доройтол буурна.*

Завхан аймаг, Их-Уул сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийг өнжөөж амраах нь бэлчээрийн доройтлоос хамгаалах хамгийн зөв арга. Малын тоо тогойг зохистой хэмжээнд улсаас бодлогоор барих шаардлагатай байна. Эрчимжсэн мал аж ахуйг сайжруулах шаардлагатай. Малынхаа тоог цөөрүүлж үйлдэр угсааг сайжруулах хэрэгтэй байна.*

Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийн тухай хуулийг яаралтай батлах хэрэгтэй. 1997 оноос хойш хууль өөрчлөгдөөгүй. Хуулийн хэлэлцүүлэгт орсон. Гэхдээ эцэслэгдэж гараагүй байна. Тэгэхээр төрөөс хуулиа хурдан батлах хэрэгтэй байна.*

Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Эхний ээлжид малчдыг мал маллах тал дээр мэдлэг мэдээлэлтэй болгох, чанарлаг таварлаг мал өсгөх шаардлагатай.*

Завхан аймаг, Их-Уул сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

### *Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог*

Говь-Алтай аймгийн малчдын хувьд уулархаг хээрийн бэлчээр гэж 62.2 хувь нь үзсэн байна. Үүний дараагаар говийн бэлчээр гэж 58.2 хувь нь, хээр гэж 25.3 хувь нь, нарийн өвстэй гэж 23.6 хувь нь, бут сөөглөг ургамал зонхилсон гэж 20.5 хувь нь, бүдүүн өвстэй гэж 15.2 хувь нь тус, тус нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, Говь-Алтай аймгийн төсөл хэрэгжих 3 сум буюу Цогт, Чандмань, Эрдэнэ сумдын бэлчээрийн онцлог нь бусад гурван аймгаа бодвол биологийн олон янз байдал хосолсон, уулархаг, говийн, бут сөөглөг ургамалтай, өвс ургамал нь нарийн, бүдүүн ширхэгтэй ургадаг бэлчээрийн онцлог байдал ихтэй байгаа юм.

*График 20: Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог, хувиар*




*Зураг 4: Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог*



Сумын төвийн болон хөдөөгийн малчдын хувьд бэлчээрийн онцлогийн талаар төдийлөн зөрүүтэй үзүүлэлт харагдахгүй байна. Харин сумын төвийн бэлчээрийн өвс бүдүүн ширхэгтэй, хөдөөгүүр нарийн ширхэгтэй байх шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, сумын төвийнхний хувьд бэлчээрт бүдүүн өвстэй гэх үзүүлэлт хөдөөгийнхнөөс 1.9 пунктээр илүү байгаа бол, эсрэгээрээ хөдөөгийнхөн бэлчээрээ нарийн ширхэгтэй өвстэй гэж 6.2 пунктээр илүү нэрлэсэн байна.

*График 21: Говь-Алтай аймгийн бэлчээрийн онцлог, сумын төв болон хөдөөгөөр, хувиар*




Говь-Алтай аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлын шалтгааныг малын тоо толгойн хэт өсөлт болон байгаль цаг уурын өөрчлөлттэй холбон үзэж байна. Мөн ундны усны хомсдол, хуурайшилттай тул малчид отор нүүдэл, бэлчээр сэлгэх боломжгүйгээс бэлчээрийн доройтолд хүрсэн байна. Мөн бэлчээрийн доройтлын шалтгааныг үлийн цагаан оготнотой холбон ойлгож байна.

Говь-Алтай аймгийн сумдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд  малын тоо толгойг бууруулж, нөгөө 3 аймгаасаа харьцангуй их бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд бэлчээрийн зүй зохистой хуваарлалтыг хийхийг хичээдэг болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд бүх сумдад бэлчээрийн сэлгэлтийг хийхийг шаардаж ажилладаг байна.

**Шигтгээ:** *Бэлчээрийн доройтол, цөлжилт их явагдаж байна. Хамгийн гол нь усны хангамж дутмаг байгаа, хур бороо их орохгүй байгаа. Тодорхой хэмжээний бэлчээр ашиглаж чадахгүй, усны хомстолд орж байна. Нэг газарт мал маллаж бэлчээрийн доройтолд маш их ордог. Бэлчээрийн доройтолд 40-50 хувьд хүрсэн байна гэж бодож байна.*

Говь-Алтай аймаг, Цогт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Үлийн цагаан оготно их бэлчээрийн асуудалд оруулж байна. Нэлээн их бэлчээр доройтсон. Манай сум 7 багтай түүний 6 багт нь үлийн цагаан оготно байгаа.*

Говь-Алтай аймаг, Цогт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Манай сум бол улсын нийслэлээс алслагдсан 1000 гаруй км зайтай, хүн амын тоо, малын тоо толгойгоороо бол аймагтаа тэргүүлдэг. Манай сум баруун талаараа Алтай сум зүүн талаараа Эрдэнэ Чандмань сумуудтай, хойд талаараа дэлгэр, урд талаараа БНХАУ-тай хиллэдэг. Манай сумын гол хөгжлийн тулгуур нь мал аж ахуй, газар тариалан юм. Манай сумд тулгамдсан гол асуудал бэлчээрийн доройтол. Ган зуд, хуурайшилт их байгаагаас болоод байна.*

Говь-Алтай аймаг, Цогт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Манай сумын бэлчээрийн доройтол сум орон нутгийнхаа хэмжээнд 25 хувь нь өртчихөөд байна. Ганц малын тооноос биш үлийн цагаан оготноос болж байна. Манай сум орон нутгийн бэлчээрийг хэн ч ашиглах боломжтой. Худаг усны асуудлыг шийдэж хэрэглэж, тэлж нутаглаж чадахгүй байна. Орон нутгийн тусгай хамгаалалтад бэлчээрийн 80 хувь нь байдаг түүнээс отрын бүс нутаг гэж 50 км газрыг хамгаалалтад авсан. Цаг байдал хүндэрсэн үед манай сумын малчид өвөлждөг.*

Говь-Алтай аймаг, Чандмань сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Ерөөсөө л үлийн цагаан оготнод идэгдээд, ер нь бэлчээр доройтохоор үлийн цагаан оготно идчихдэг. Доройтсон бэлчээрээ сэргээж чадахгүй байна. Газартаа хэсэгчилсэн өнжөөлт оруулвал сайн. Тэгэхгүй л бол манай сумын бэлчээр доройтож байна. Ерөнхийдөө ойрын жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай холбоотойгоор бэлчээргүйдэл үүсч байна.*

Говь-Алтай аймаг, Чандмань сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийн доройтолд чанаргүй олон тоо толгой мал болон ган зуд, үлийн цагаан оготно зэрэг байгалийн шалтгаанууд мөн нөлөөлж байна. Нийт 4 багт бүгдэд үлийн цагаан оготнотой. Хэдийгээр хортон шавьж устгах арга хэмжээ авдаг боловч нүүдэллэдэг тул устгалд оруулах бол боломжгүй байдаг.*

Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Бэлчээрийн доройтолд өртсөн. Ерөнхийдөө 75% нь өртчихсөн. Маш өргөн уудам нутагтай тул малчид хол газар явдаггүй. Ялангуяа зуслангийн газар маш их доройтсон. 3 дахин илүү доройтсон гэж судалгаагаар гарсан. Бид жил бүрийн 8 сарын 5-10 ны хооронд сумынхаа газрын даамал, цаг уурын мэргэжилтэн, бэлчээрийн бусад мэргэжилтнүүдийнхээ хамтаар фото мониторинг хийдэг. Энэ жил сайхан харагдаж байсан. Сайхан харагдаж байгаа газар нь яваад очихоор тухайн газарт нь голдуу хогийн ургамал, шарилж, ихэвчлэн ургасан байдаг. Малд хэрэгтэй ургамал ер нь их ховордож байгаа. Жил бүр газрын даамал фото мониторинг хийдэг. Манайд "Ногоон Алт" бага зэрэг санхүүгийн туслалцаа үзүүлж хамтарч хийдэг. Бид бэлчээрээ сайжруулахын тулд бэлчээр ашиглагчдынхаа хэсэг дээр 2015 онд гэрээ байгуулсан. Сумын засаг даргатай малчид гурвалсан гэрээ байгуулсан. Газар зохион байгуулалт буюу landshap гэдэг программ дээр бүртгүүлээд аймгийн хэмжээд 97 бэлчээр ашиглагчдын гэрээ байгуулсан.*

Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Манай төслийн зүгээс бэлчээр ашиглагчдын гэрээ хийе гээд хамгийн түрүүнд гэрээ хийчихсэн байж байгаа. Малчин гэрээ хийснээр тухайн газар нутагтаа өөриймсөг хандаж бэлчээрээ хайрлаж хамгаалж, сайжруулах тал дээр элгэмсэг хандана. Бэлчээр ашиглагчдын гэрээнд 60-70% нь гарын үсэг зураад гэрээ байгуулчихсан байгаа. Бэлчээр ашиглагчдын журам гэж хийгээд малчдад сургалт мэдээлэл өгч байгаа. Түрүү жил аймгийн иргэдийн хурлаар баталбал сумууд нь батална гэсэн боловч аймагтаа батлуулж чадаагүй. Аймгийн сумуудаас Баян–Уул баталчихсан. Орон нутгийн ажилчидтай танай байгууллага нэг зорилготой нэг төсөлд хамтарч ажиллавал их зүгээр санагдаж байна. Сургалт мэдээллээ хамтарч хийвэл төрийн байгууллагууд болон хувийн байгууллагууд дэмжлэг туслалцаа үзүүлээд бүгдээрээ явбал ямар ч саад бэрхшээл байсан даваад гарах байх гэж бодож байна. Сумын хэмжээнд 4 багаа 4 бэлчээр ашиглагчдын холбоо болгочихсон. Бүгдтэй нь гэрээ байгуулчихсан.*

Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Нийт багаар нь хуваарилалт хийдэг. Хэдэн толгой малд хэдэн метр кв бэлчээр ногдох, малын тоо толгойн хэтрэлт буюу бэлчээрийн доройтлын хэмжээг тогтоож эрчимжүүлсэн мал аж ахуйд анхаардаг. Малын тоо толгойг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна.*

Говь-Алтай аймаг, Чандмань сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

*Малчин өрхийн бэлчээрээс хүртэж буй ашиг шимийн талаарх хандлага*

Эх газрын эрс тэс, байгалийн нөхцөлд мал маллагааны олон зууныг дамжиж ирсэн Монгол мал нь жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаанд байж, өсөн үржиж ашиг шимээ өгсөөр ирсэн уламжлалтай билээ. Малчид бэлчээр хэмээх энэхүү байгалийн баялгаар дамжуулан амьдрал ахуйгаа залгуулж, орлогын эх үүсвэрээ болгон аж төрдөг. Энэ үүднээс малчин өрхийн бэлчээрийг харах мэдлэг, хандлагыг тодорхойлох зорилгоор бэлчээрээс хүртэж буй ашиг шимийг тодруулсан болно.

Тус үзүүлэлтийг сумын төв болон хөдөөгийн малчин өрхөөр ангилан харвал амьдарч буй орон нутгаас үл хамааран хандлагад тэдийлөн ялгаа ажиглагдахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл аль аймгийн сумын төв, хөдөө гэх ялгаа ажиглагдаагүй тул нийт 4 аймгийн сумын төв, хөдөөгийн өрхөөр ангилан үр дүнг гаргасан болно. Ингэхэд, байршлаас хамааран бүх үзүүлэлтүүд өндөр зөрүүтэй байна. Хөдөөгийн малчдын хувьд сумын төвийнхнөөс малаа бэлчээдэг гэж 13.0 пунктээр, амьжиргаагаа залгуулдаг гэж 6.6 пунктээр, орлогын эх үүсвэр болдог гэж 11.8 пунктээр, хадлан тэжээлээ бэлтгэдэг гэж 13.0 пунктээр тус, тус нэрлэсэн байна. Энэ нь хөдөөгийн малчид сумын төвийнхөнтэй харьцуулахад бэлчээрээс шууд хамааран амьдрал ахуйгаа залгуулан амьдардагтай холбоотой юм. Нөгөөтээгүүр, хөдөөгийн малчид бэлчээрийг илүү өргөн утгаар харж илүү их ач холбогдол өгөх хандлагатайг илэрхийлж байна.

*График 22: Малын бэлчээрээс хүртэж буй ашиг шим хөдөө болон сумын төвөөр, хувиар*




Харин дээрх үзүүлэлтийг аймаг тус бүрээр харвал, Баянхонгор аймгийн малчдын хувьд бэлчээрийн ашиг шимийг малаа бэлчээх байдлаар хүртэж байгаа гэж 72.7 хувь нь үзсэн нь бусад 3 аймгийн дунджаас 19.2 пунктээр илүү байна. Эсрэгээрээ, хадлан тэжээлээ бэлтгэж ашиг шим хүртдэг гэх үзүүлэлтэд хамгийн бага буюу бусад 3 аймгийн дунджаас 23.9 пунктээр бага байна. Энэ нь Баянхонгор аймгийнхан бэлчээрээсээ хадлан тэжээлээ бусад 3 аймгийнхантайгаа харьцуулахад

хамгийн багаар бэлтгэж, малаа бэлчээх байдлаар бэлчээрийн ашиг шимийг хүртдэг гэх хандлагатайг илэрхийлж байна.

Архангай аймгийн хувьд амьжиргаагаа залгуулах байдлаар ашиг шим хүртэж байгаа гэж 27.5 хувь нь үзсэн нь бусад 3 аймгийн дунджаас 21.9 пунктээр бага, мөн орлогын эх үүсвэрээ болгох байдлаар ашиг шим хүртэж байгаа гэж 16.7 хувь нь үзсэн нь бусад 3 аймгийн дунджаас 20.2 пунктээр бага байна. Энэ нь тус аймгийнхан мал аж, ахуйгаас гадна өөр орлогын эх үүсвэртэй байж болох тал ажиглагдаж байна.

Завхан аймгийн хувьд бусад 3 аймгаас төдийлөн зөрүүтэй үр дүн харагдсангүй.

Говь-Алтай аймгийн хувьд орлогын эх үүсвэр болдог (46.6 хувь), сэтгэлийн баяр баясал мэдэрдэг (23.4 хувь), эмийн ургамал болон ховор ургамал авч ашигладаг (15.4 хувь), түлш түүдэг (44.5 хувь), хадлан тэжээл бэлтгэдэг (35.9 хувь), малынхаа хужрыг авч ашигладаг (41.8 хувь) нь тус, тус нэрлэсэн нь бусад 3 аймгаас илүү үзүүлэлтүүд байгаа юм. Өөрөөр хэлбэл, Говь-Алтай аймгийн малчид бэлчээрийг олон байдлаар ашиглан, ашиг шимийг нь хүртдэг гэдгээ мэддэг хандлагатай байна.

Мөн Баянхонгор болон Говь-Алтай аймгийн малчдын хувьд бэлчээрээсээ аргал, хомоол, хамхуул зэргийг бэлтгэн түлшиндээ хэрэглэдэг байна. Харин Завхан, Архангай аймгийнхан эдгээрээс илүү мод түлшиндээ хэрэглэдэг байна.

*График 23: Малчдын бэлчээрээс хүртэж буй ашиг шим, аймгаар, хувиар*




### *Малчин өрхийн амьдарч буй сум орон нутгийн бэлчээрт хамгийн их тулгамдаж байгаа асуудал*

Эхний үр дүнд малчдын хувьд бэлчээрийн доройтол гэх ойлголтын тодорхойлолтоор нэрлэгдсэн бэлчээрийн даац хэтрэлт гэх ойлголт нь бэлчээрт тулгамдаж буй асуудлаар 4 аймгийн хувьд 60.0 хувиас дээш нэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, төсөл хэрэгжиж буй 4 аймгийн хувьд бэлчээрт хамгийн их тулгамдаж буй асуудлаар 62.4 хувь нь нэрлэсэн байна.

Баянхонгор аймгийнхны бэлчээрт тулгамдаж буй асуудлаар хамгийн өндөр буюу 68.8 хувиар хур тунадас багасах гэсэн үзүүлэлт нэрлэгдсэн нь дээрх үзүүлэлтээс 3.7 пунктээр илүү байна. Уг үзүүлэлтийн дараагаар усны нөөц багасах гэж 52.3 хувь нь, малын сүргийн бүтэц өөрчлөгдсөн гэж 35.5 хувь нь, хуурайшилт нэмэгдсэн гэж 29.5 хувь нь, цөлжилтөд нэрвэгдсэн гэж 25.0 хувь нь, элсний нүүдэл нэмэгдсэн гэж 18.2 хувь нь тус, тус хариулсан нь бусад 3 аймгийн бэлчээрт тулгамдсан асуудлуудыг илэрхийлэх хувиас бүх үзүүлэлтээр өндөр байгаа юм. Энэ нь Баянхонгор аймгийн бэлчээр хур тунадас багассан болон сүргийн бүтэц (ямааны тоо нэмэгдсэн) өөрчлөгдсөнөөс үүдэн хуурайшиж, цөлжин, элсний нүүдэл явагдаж усны хомсдолд орсон болохыг илэрхийлж байна.

Завхан болон Говь-Алтай аймгийн бэлчээрийн тулгамдсан асуудлын хувьд зэрлэг амьтадтай бэлчээрээ булаалцалдах (2.6 хувь) болон хортон шавж ихсэх (5.3 хувь), үлийн цагаан оготно (41.1 хувь) зэрэг нь нөгөө 2 аймгаасаа илүү байна.

Архангай аймгийн бэлчээрт тулгамдсан асуудлууд бусад 3 аймгийн бэлчээрийн асуудалтай харьцуулахад төдийлөн өндөр биш байна.

*График 24: Бэлчээрт тулгамдаж буй асуудал, аймаг болон хувиар*




## *Сум орон нутгийн бэлчээрийн доройтлын түвшин, шалтгаан*

Баянхонгор аймгийн хувьд бэлчээрийн доройтолд хамгийн их өртсөн сум нь Баацагаан (55.6 хувь) байгаа бол хамгийн бага бэлчээрийн доройтолтойгоор Шинэжинст сум (40.8 хувь) нэрлэгдсэн байна.

Архангай аймгийн хувьд бэлчээрийн доройтолд хамгийн их өртсөн сум нь Батцэнгэл (62.0 хувь) байгаа бол хамгийн бага бэлчээрийн доройтолтойгоор Хайрхан сум (44.7 хувь) нэрлэгдсэн байна.

Завхан аймгийн 2 сумын хувьд бэлчээрийн доройтолд хамгийн их өртсөн сум нь Их-Уул (49.4 хувь) байгаа бол хамгийн бага бэлчээрийн доройтолтойгоор Тосонцэнгэл сум (44.4 хувь) нэрлэгдсэн байна.

Говь-Алтай аймгийн хувьд бэлчээрийн доройтолд хамгийн их өртсөн сум нь Цогт (55.9 хувь) байгаа бол хамгийн бага бэлчээрийн доройтолтойгоор Эрдэнэ сум (45.7 хувь) нэрлэгдсэн байна.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 13 сумын хувьд бэлчээрийн доройтолд бүх сумд өртсөн гэж үзэж байгааг харж болохоор байна. Үүний дотор маш их өртсөн гэх үзүүлэлтэд хамгийн ихээр Архангай аймгийн Өлзийт сум 44.9 хувьтай байгаа бол хамгийн багаар буюу дунд зэрэг өртсөнөөр тус аймгийн Батцэнгэл сум 62.0 хувьтайгаар нэрлэгдсэн байна. Энэ нь аймаг дотроо бэлчээрийн доройтлын түвшин сум, сумаараа харилцан адилгүй байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 3: Сумдын бэлчээрийн доройтолд өртсөн хувь*

| Аймгийн нэр | Сумын нэр | Огт өртөөгүй (0%) | Бага зэрэг өртсөн (25%) | Дунд зэрэг (50%) | Ерөнхийдөө өртсөн (75%) | Маш их өртсөн (100%) |
|---|---|---|---|---|---|---|
| Баянхонгор | Баацагаан | 0.0% | 2.2% | 26.7% | **55.6%** | 15.6% |
| | Баян-Өндөр | 0.0% | 4.3% | 29.5% | 42.4% | 23.7% |
| | Баянцагаан | 2.1% | 12.5% | 41.7% | 37.5% | 6.3% |
| | Шинэжинст | .8% | 5.8% | 40.8% | 40.8% | 11.7% |
| Архангай | Батцэнгэл | 1.3% | 7.6% | **62.0%** | 22.8% | 6.3% |
| | Өлзийт | 0.0% | 6.1% | 20.4% | 28.6% | 44.9% |
| | Хайрхан | 2.1% | 12.8% | 44.7% | 36.2% | 4.3% |
| Завхан | Эрдэнэмандал | 0.0% | 19.1% | 55.3% | 21.3% | 4.3% |
| | Их-Уул | 0.0% | 11.7% | **49.4%** | 26.0% | 13.0% |
| | Тосонцэнгэл | 1.2% | 8.8% | 44.4% | 37.4% | 8.2% |
| Говь-Алтай | Цогт | 0.0% | 5.3% | 27.3% | **55.9%** | 11.5% |
| | Чандмань | 1.8% | 3.6% | 40.2% | 43.8% | 10.7% |
| | Эрдэнэ | 1.4% | 9.3% | 45.7% | 28.6% | 15.0% |
| **Нийт** | | .8% | 7.5% | 39.4% | 39.2% | 13.1% |

Бэлчээрийн доройтлын шалтгааныг өмнө нь График1, График2-т дурдсанчлан бэлчээрийн даац хэтрэх гэж тодорхойлсон бол бэлчээрийн даац малын тоо толгойн өсөлттэй холбоотойгоор ихэссэн болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн шууд буруутай үйл ажиллагаа буюу дэд бүтцийн хөгжил, ахуйн хог хаягдал, мэдлэг дутмаг, хандлаг буруу, уул уурхай, эрх зүйн зохицуулалт, хотжилт зэргээс үл хамаарсан бэлчээрийн доройтлын шалтгаануудыг дурдах хандлагатай байна.

Баянхонгор аймгийн малчдын хувьд ган/зудын гамшгаас шалтгаалж гэж 51.4 хувь нь (Бусад 3 аймгаас 13.8 пунктээр илүү), байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан гэж 46.0 хувь нь (Бусад 3 аймгаас 23.5 пунктээр илүү), усны хомтол гэж 43.8 хувь нь (Бусад 3 аймгаас 28.0 пунктээр илүү), цөлжилт гэж 36.9 хувь нь (Бусад 3 аймгаас 18.3 пунктээр илүү) тус, тус бэлчээр доройтсон шалтгааныг нэрлэсэн байна. Энэ нь дээр дурдсан Баянхонгор аймгийн бэлчээрт тулгамдаж байгаа асуудал нь бэлчээрийн доройтол үүсэх шалтгааныг нөхцөлдүүлж байна гэж бататган харж болохоор байна. Мөн уул, уурхайгаас шалтгаалж бэлчээр доройтсон гэж зөвхөн Баянхонгор аймгийнхны хувьд 15.1 хувь нь хариулсан байгаа юм.

Бусад 3 аймгийн хувьд бэлчээрийн доройтлын шалтгаанаар малын тоо толгойн өсөлт дунджаар 56.1 хувьтайгаар нэрлэгдсэн байна.

Говь-Алтай, Завхан аймгийн бэлчээрийн доройтлын шалтгаанаар үлийн цагаан оготно 34.0 хувьтайгаар нэрлэгдсэн нь бусад 2 аймгийнхаас 30.3 пунктээр илүү байна. Энэ нь тус 2 аймгийн хувьд жижиг мэрэгч амьтан тэр дундаа үлийн цагаан оготно их байгаа нь харагдаж байна.

*График 25: Бэлчээрийн доройтлын шалтгаан аймаг болон хувиар*




Бэлчээрийн доройтол гэж бэлчээрийн даац хэтрэх хэмээн тодорхойлж байсан малчид даац хэтэрсэн шалтгаанаар малын тоо, толгойн өсөлтийг нэрлэн үүнээс гарах, шийдвэрлэх арга замыг 50.8 хувь нь малын тоо толгойд хяналт тавих гэж харж байна. Бэлчээрийн зүй зохистой хуваарилалт хийх 21.6 хувь нь, худаг ус гаргах гэж 22.9 хувь нь, малын үүлдэр угсааг сайжруулж чанарт илүү анхаарах гэж 18.1 хувь нь малын ашиг шимд нарийвчилсан тооцоо хийн сүргийн бүтцийг тодорхойлох гэж 16.3 хувь нь тус, тус хариулсан байна. Нэг үгээр хэлбэл, малчид бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малын тоо толгойг үүлдэр угсаа, сүргийн бүтцийг сайжруулан хийх боломжтой гэж харж байна. Нөгөө талаас бэлчээрийн зүй зохистой хуваарилалт хийж, худаг ус гарган /худаг усаа бараадан төвлөрөн амьдарч байгаа нь бэлчээрийн доройтлын шалтгаан болж байгаа/ шийдвэрлэх боломж ч байгаа гэж харж байна.

Харин сум орон нутагт хэрэгждэг эрсдэлийн сан болон дундын сан бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж мөрдөж ажиллах зэргийг бэлчээрийн доройтлыг бууруулах ажил гэж малчид харахгүй байна.

*График 26: Бэлчээрийн доройтлыг бууруулах арга замууд аймаг болон хувиар*




Малчдын 50.8 хувь нь малын тоо толгойд хяналт тавьдаг ба уг ажлыг өдөр тутамдаа хэрэгжүүлж ажилладаг гэж 32.7 хувь нь хариулсан байна. Энэ нь малчид бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд хамгийн чухал нөлөөтэй ажиллагааг хэрэгжүүлээд эхэлсэн нь харагдаж байна. Завхан аймгийн малчид байнга малын тоо толгойд хяналт тавьж өдөр тутмынхаа амьдралд хэвшүүлж ажиллаж байгаа үзүүлэлт хамгийн өндөр буюу 55.6 хувьтай байна.

*Хүснэгт 4: Малын тоо, толгойг бууруулахад анхаарч ажилладаг өрхийн давтамж аймаг болон хувиар*

| | Баянхонгор аймаг | Архангай аймаг | Завхан аймаг | Говь-Алтай аймаг |
|---|---|---|---|---|
| 3 жилд нэг удаа/Оролцож үзсэн | 31.3% | 42.9% | 22.2% | 16.2% |
| 2 жилд нэг удаа/1 удаа хийгээд орхисон | 2.1% | | 11.1% | 8.1% |
| Жилд нэг удаа/Тух ховор | 25.0% | 14.3% | 11.1% | 27.0% |
| Хагас жилд нэг удаа/Ховор | | | | 2.7% |
| Улиралд нэг удаа/Үе үе | | 14.3% | | 8.1% |
| Сард нэг удаа/Хааяа | 4.2% | | | 5.4% |
| Хоёр долоо хоногт нэг удаа/Ихэвчлэн | | | | 2.7% |
| Долоо хоногт нэг удаа/Тогтмол | 4.2% | | | 2.7% |
| Өдөр тутам/Байнга | 33.3% | 28.6% | 55.6% | 27.0% |

## 4. ОЙ, ОЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА

Уг бүлгээр төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 13 сумын малчин өрхийн ойн талаарх ойлголт, ойд хандах хандлага, ойн онцлог, ойн ашиг шим, ойд тулгамдаж буй асуудал, ойн доройтлын түвшин, шалтгаан, түүнээс гарах арга зам, хэрхэн хамгаалах цаашид зүй зохистой ашиглах зэрэг асуудалд хандаж буй малчдын хандлага, туршлагыг тодорхойлох зорилготой болно.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 13 сумын 30 багийн хувьд 11 сумын 25 баг нь тодорхой хэмжээгээр ойтой байна.

*Хүснэгт 5: Ойтой сум болон багийн эзлэх хувь*

| Аймаг | Сум | | Багийн нэр | |
|---|---|---|---|---|
| **Завхан** | Их-Уул | 100.0% | Зарт | 100.0% |
| | Тосонцэнгэл | 94.2% | Рашаант | 93.2% |
| | | | Хайрхан | 94.8% |
| **Говь-Алтай** | Цогт | 63.9% | Рашаант | 76.5% |
| | | | Далан | 50.0% |
| | | | Гэгээт | 63.2% |
| | | | Төгрөг | 62.5% |
| | | | Баян-Өндөр | 61.0% |
| | | | Баян-Улаан | 70.0% |
| | | | Баянтоорой | 66.1% |
| | Эрдэнэ | 85.7% | Сангийн далай | 96.8% |
| | | | Цэцэгнуур | 94.4% |
| | | | Цагаан-Уул | 74.3% |
| | | | Өлзийт | 78.9% |
| **Баянхонгор** | Баацагаан | 93.3% | Товгор | 93.3% |
| | Баян-Өндөр | 89.2% | Булган | 100.0% |
| | | | Элгэн | 84.4% |
| | | | Улаан-үзүүр | 86.0% |
| | Шинэжинст | 32.5% | Уртын гол | 27.1% |
| | | | Эхэн хавцгай | 70.6% |
| **Архангай** | Батцэнгэл | 97.5% | Улаанчулуу | 100.0% |
| | | | Цац | 95.8% |
| | Өлзийт | 91.8% | Байшир | 91.8% |
| | Хайрхан | 97.9% | Жарантай | 97.9% |
| | Эрдэнэмандал | 100.0% | Идэр-Улаан | 100.0% |

Хандлагын эхний хэсэг болох ойн доройтлыг малчин өрхийн хувьд тулгамдсан асуудал мөн эсэхийг тодорхойлсон. Тус үзүүлэлт Завхан, Архангай аймгийн хувьд 98.2 хувьтай санал нийлэх хандлагатай байгаа бол Баянхонгор, Говь-Алтай аймгийн хувьд 87.5 хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Дунджаар нийт аймгуудын малчин өрхийн 92.9 хувь нь ойг өрхийн амьдрал ахуйд ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн сум орон нутгийнхаа хамгийн их тулгамдаж байгаа асуудал мөн хэмээн 91.5 хувь нь үзэж байсан ба ойн доройтлыг бууруулахгүй бол байгалийн тэнцвэрт байдал алдагдана гэж 95.7 хувь нь үзэж байна.

Мөн малчид ойн доройтол тулгамдсан асуудал мөн бөгөөд бууруулах шаардлагатайг мэдэж байгаа ч юу хийх, ямар арга хэмжээ авахаа 88.3 хувь нь мэдэхгүй байна. Нөгөөтээгүүр ойн доройтлыг бууруулахад амьдрал ахуйдаа анхаарч ажиллахад бэлэн байгаа хандлага 67.8 хувьд нь байна. Өөрөөр хэлбэл ойн доройтлыг бууруулах нь малчдын хувьд нэн тэргүүний тулгамдсан асуудал бөгөөд амьдрал ахуй нь ойтой хамааралтайг мэддэг бөгөөд хэрхэн энэ асуудлаас гарах, ойн доройтлыг бууруулахын тулд юу хийх ёстойгоо мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

*График 27: Ойн доройтол нь тулгамдсан асуудал мөн эсэхийг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар*




Хандлага тодорхойлох дараагийн хэсэгт ойн доройтлын шалтгааныг малчин өрх хүний үйл ажиллагаатай холбон, нөгөө талаас байгалийн жам ёсны хуультай холбон, зэрэгцүүлээд төр засгийн үйл ажиллагаатай холбон тодорхойлсон.

Ойн доройтлын шалтгааныг дэлхийн дулаарал хуурайшилт ихэссэнтэй холбон 93.0 хувь нь буюу хамгийн өндөр хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Малчдаас өөрсдөөс нь шалтгаалсан буюу зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж ой доройтсон гэдэгтэй 90.2 хувь нь санал нийлсэн байна. Үүний дараагаар ойн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна гэдэгтэй 89.7 хувь нь санал нийлсэн байна.

**Шигтгээ:** *Манай аймагт ой мод их байхгүй, заган ой байдаг. Ард иргэдэд заган ойг түлшиндээ их хэрэглэдэг. Газрын ногооны гарц муу учраас дахин сэргэхгүй.*

Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Манай аймагт бол ерөнхийдөө хортон шавж байна. Мөн хүний хүчин зүйл байна. Хууль бусаар мод бэлтгэх, ойд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн бага байна. Түймэр мөн нөлөөлж байна. Самар жимс ургахаар хүмүүс модруу авирч мөчир хугалж байна. Хүний буруутай үйл ажиллагаа их нөлөөлж байгаа.*

Архангай аймаг, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Түймрээс гадна ойн мэргэжлийн байгууллагуудын зохисгүй хэрэглээ ойн доройтлын шалтгаан болж байгаа.*

Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

*График 28: Ойн доройтлын шалтгааныг тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон хувиар*




Ойн доройтлыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа шийдвэрлэх боломжийн хандлагыг тодорхойлох зорилгоор 5 төрлийн тодорхойлолтыг ашигласан.

Ойн доройтлыг бууруулахын тулд малчид болон сум орон нутгийн удирдлагууд хамтран ажиллах ёстой гэдэгтэй 93.3 хувиар санал нийлсэн нь ойн доройтлыг бууруулах боломжийн хувьд хамгийн өндөр санал нийлсэн тодорхойлолт байгаа юм.

**Шигтгээ:** *Аймгийн удирдлагууд хамтын ажиллагаа явуулж менежмент зөв төлөвлөх хэрэгтэй.*

Говь-Алтай аймаг, Гүнзгийрүүлсэн ярилцлага

Дэлхийн дулаарал, хуурайшилтаас болж ой доройтож байгаа гэдэгтэй хамгийн өндөр санал нийлсэн малчид ойн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ ч юу ч өөрчлөгдөхгүй гэсэн хандлагатай 61.9 хувь нь санал нийлсэн байна.

Архангай аймгийнхны хувьд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй хамгийн өндөр буюу 93.0 хувиар санал нийлсэн байна.

**Шигтгээ:** *Ойн нөхөрлөлүүд байгуулах болон тусгай хамгаалалтад авах зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй.*

Архангай аймаг, Хайрхан сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

*График 29: Ойн доройтлыг бууруулах, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар тодруулах хандлагын тодорхойлолтоор аймаг болон, хувиар*




Баянхонгор аймгийн ойн онцлог нь заг (57.7 хувь) бүхий хармагийн бут бүхий ой (9.9 хувь), сухай жигд (8.8 хувь), тооройн төгөл (5.4 хувь) бүрэлдсэн ойтой байна.

Говь-Алтай аймгийн ойн онцлог нь заг (53.0 хувь) бүхий сухай жигд (28.4 хувь) ургасан тооройн төгөл (21.1 хувь), хармагийн бут (14.8 хувь) бүрэлдсэн ойтой байна.

Архангай аймгийн ойн онцлог нь шинэс бүхий хусан ой (49.1 хувь) зонхилсон шилмүүст ой (35.1 хувь), хуш мод (11.7 хувь) шинэсэн ой байна.

Завхан аймгийн ойн онцлог нь шинэс бүхий хушин ой (73.4 хувь) зонхилсон шилмүүст ой (20.2 хувь), хус мод (6.9 хувь) шинэсэн ой байна. Мөн Завхан аймгийн түймэрт өртсөн буюу шатсан ой 6.5 хувийг эзэлсэн нь энэ үзүүлэлт дундаа хамгийн өндөр нь байна.

*График 30: Ойн онцлог аймаг болон хувиар*




Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн иргэдийн хувьд ойгоо түлшний зориулалтаар хамгийн өндөр буюу 45.6 хувь нь ашигладаг байна.

Баянхонгор аймгийнхны хувьд 16.2 хувь нь ашиг шим хүртдэггүй буюу ойгоо ашигладаггүй гэх хандлагатай байна.

Архангай аймгийнхан хашаа барих (29.3 хувь), жимс түүх (23.4 хувь) байдлаар ашиглаж байна.

Завхан аймгийнхны хувьд хамгийн ихээр буюу 71.8 хувь нь жимс, жимсгэнэ түүж ашиглаж байна.

*График 31: Ойгоос хүртдэг ашиг шим аймаг болон хувиар*




Ойн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг агаар цэвэршүүлдэг гэж 37.0 хувь нь, булаг шандыг усаар тэтгэдэг гэж 34.2 хувь нь, хүчил төрөгч ялгаруулдаг гэж 26.2 хувь нь, элсний нүүдлийг зогсоодог гэж 22.3 хувь нь, зэрлэг амьтдын амьдрах орчин болдог гэж 20.8 хувь нь, дэлхийн дулаарлыг бууруулдаг гэж 14.2 хувь нь, хүлэмжийн хийг шингээдэг гэж 11.4 хувь нь тус, тус мэддэг байна.

Ойгоос хамгийн их жимс түүж ашиг шим хүртдэг Завхан аймгийнхны 14.9 хувь нь мөнх цэвдгийг тогтоон барьдгийг мэддэг байна. Тэдний түүж ашигладаг жимс, жимсгэнэ нь мөнх цэвдэгт хөрсөнд ургадгийг ерөнхийдөө мэддэг хүмүүс байдаг байна.

Говийн бүсийн аймгууд болох Баянхонгор (34.4 хувь), Говь-Алтай (33.8 хувь), аймгийнхны хувьд элсний нүүдлийг зогсоодгийг мөн ерөнхийдөө мэддэг байна.

*График 32: Ойн байгаль орчинд үзүүлэх нөлөө аймаг болон хувиар*




Баянхонгор аймгийн хувьд ойн доройтолд хамгийн их өртсөн сум нь Шинэжинст (48.7 хувь) байгаа бол хамгийн бага ойн доройтолтойгоор Баян-Өндөр сум (34.7 хувь) нэрлэгдсэн байна.

Архангай аймгийн хувьд ойн доройтолд хамгийн их өртсөн сум нь Өлзийт (40.0 хувь) байгаа бол хамгийн бага ойн доройтолтойгоор Эрдэнэмандал сум (61.7 хувь) нэрлэгдсэн байна.

Завхан аймгийн 2 сумын хувьд ойн доройтолд хамгийн их өртсөн сум нь Их-Уул (40.3 хувь) байгаа бол хамгийн бага ойн доройтолтойгоор Тосонцэнгэл сум (41.6 хувь) нэрлэгдсэн байна.

Говь-Алтай аймгийн хувьд ойн доройтолд хамгийн их өртсөн сум нь Цогт (49.7 хувь) байгаа бол хамгийн бага ойн доройтолтойгоор Эрдэнэ сум (45.0 хувь) нэрлэгдсэн байна.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 13 сумын хувьд ойн доройтолд бүх сумд өртсөн гэж үзэж байгааг харж болохоор байна. Үүний дотор маш их өртсөн гэх үзүүлэлтэд хамгийн ихээр Архангай аймгийн Өлзийт сум 40.0 хувьтай байгаа бол хамгийн багаар буюу дунд зэрэг өртсөнөөр тус аймгийн Эрдэнэмандал сум 61.7 хувьтайгаар нэрлэгдсэн байна. Энэ нь аймаг дотроо ойн доройтлын түвшин сум, сумаараа харилцан адилгүй байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 6: Ойн доройтлын түвшин сум болон хувиар*

| Аймгийн нэр | Сумын нэр | Огт өртөөгүй (0%) | Бага зэрэг өртсөн (25%) | Дунд зэрэг (50%) | Ерөнхийдөө өртсөн (75%) | Маш их өртсөн (100%) |
|---|---|---|---|---|---|---|
| **Баянхонгор** | Баацагаан | 0.0% | 7.1% | 47.6% | 33.3% | 11.9% |
| | Баян-Өндөр | 0.0% | 5.6% | 34.7% | 31.5% | 28.2% |
| | Баянцагаан | 0.0% | 0.0% | 100.0% | 0.0% | 0.0% |
| | Шинэжинст | 0.0% | 5.1% | 43.6% | **48.7%** | 2.6% |
| **Архангай** | Батцэнгэл | 5.2% | 10.4% | 51.9% | 29.9% | 2.6% |
| | Өлзийт | 2.2% | 4.4% | 15.6% | 37.8% | **40.0%** |
| | Хайрхан | 2.2% | 17.4% | 47.8% | 21.7% | 10.9% |
| | Эрдэнэмандал | 0.0% | 21.3% | 61.7% | 17.0% | 0.0% |
| **Завхан** | Их-Уул | 0.0% | 11.7% | 29.9% | **40.3%** | 18.2% |
| | Тосонцэнгэл | 0.0% | 4.3% | 41.6% | 32.9% | 21.1% |
| **Говь-Алтай** | Цогт | 0.0% | 9.0% | **49.7%** | 34.5% | 6.9% |
| | Чандмань | 0.0% | 0.0% | 0.0% | 100.0% | 0.0% |
| | Эрдэнэ | 2.5% | 15.0% | 45.0% | 23.3% | 14.2% |
| **Нийт** | | 1.0% | 9.4% | 42.7% | 31.7% | 15.2% |

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн ойн доройтлыг бууруулахын тулд мод тарих гэсэн үзүүлэлт хамгийн өндөр буюу 34.1 хувьтай нэрлэгдсэн байна. Үүний дараагаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох гэсэн үзүүлэлт 21.5 хувь, тарьсан модоо арчилж хамгаалах гэж 17.7 хувь, иргэд олон нийтийг эерэг хандлагатай болгох гэж 14.7 хувь нь үзэж байна.

**Шигтгээ:** *Мод тарьж сэргээлт хийх, үржүүлэлт хийх*

Завхан аймаг, Их-уул сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Түлшний хэрэглээ багасгах, сайжруулсан түлш хэрэглэх, хүмүүсийн ухамсарт ухуулга хийх.*

Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Тухайн нутаг дэвсгэрийн иргэд малчдын түлээ түлшний хэрэглээг зохицуулах , мэдлэг мэдээллээр сайн хангах , хандлагыг өөрчлөх хэрэгтэй байна. Мөнх заган ойг тариалах сэргээх тал дээр идэвхжүүлэх хэрэгтэй.*

Говь-Алтай аймаг, Гүнзгийрүүлсэн ярилцлага

**Шигтгээ:** *Ойн нөхөн сэргээлт, ойжуулалт, ойн менежмент хийж байнгын урамшуулалтай харуул ажиллуулах гэх мэтээр хамгаалах хэрэгтэй.*

Архангай аймаг, Өлзийт сум, Гүнзгийрүүлсэн ярилцлага

*График 33: Ойн доройтлыг бууруулахын тулд хийх ажлууд аймаг болон хувиар*




Ойгоос хүртдэг хамгийн олон төрлийн ашиг шим хүртдэг Завхан аймгийнхны хувьд ойн доройтлыг бууруулахын тулд юу ч хийдэггүй гэж 56.5 хувь нь хариулсан байна. Архангай аймгийнхны 32.0 хувь нь, Говь-Алтай аймгийнхны 25.7 хувь нь, Баянхонгор аймгийнхны 9.1 хувь нь тус, тус юу ч хийдэггүй гэж хариулсан байна. Ойдоо ахуйн хог хаягдал хаяхгүй байх нь малчдын ойн доройтлыг бууруулахын тулд хийж байгаа хамгийн том ажил байна. Энэ нь дунджаар 18.5 хувьтай байна.

*График 34: Ойн доройтлыг бууруулахын тулд хийдэг ажлууд аймаг болон хувиар*



# 5. ХОВОР АН АМЬТАН, УРГАМАЛ

## 5.1. Олон нийтийн ховор ан амьтанд хандах хандлага

Судалгаанд оролцогчдоос ховор ан амьтантай холбоотой хандлагыг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 94 хувь нь Ховор ан амьтныг хамгаалахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана гэдэгтэй санал нийлсэн байна. Аймгаар харвал Баянхонгор аймгийн иргэд тус асуудалтай маш их санал нийлж байна. Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна гэдэгтэй 87 хувь нь санал нийлсэн байна. Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн гэдэгтэй Архангай аймгийн иргэд хамгийн их санал нийлж байна. Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой гэдэгтэй санал нийлэх байдал бэлчээр, ойн доройтолтой харьцуулахад бага байна.

Ховор ан амьтан устаж буй шалтгааныг хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүйтэй холбоотой гэж нийт судалгаанд оролцогчдын 78 хувь нь үзэж байна. Зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж байна гэдэгтэй 77 хувь нь санал нийлсэн байна.

Ховор ан амьтныг хамгаалах боломжтой эсэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 93 хувь нь санал нийлсэн байна. Ховор ан амьтныг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй 86 хувь нь санал нийлсэн байна. Ховор ан амьтныг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй, ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй гэдэгтэй 2 хүн тутмын нэг нь санал нийлж байна.

*Хүснэгт 7: Ховор ан амьтны талаарх хандлага*

| ХАНДЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | Баянхонгор | | | | | Архангай | | | | | Завхан | | | Говь-Алтай | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Баацагаан | Баян-Өндөр | Баянцагаан | Шинэжинст | Нийт | Батцэнгэл | Өлзийт | Хайрхан | Эрдэнэмандал | Нийт | Их-Уул | Тосонцэнгэл | Нийт | Цогт | Чандмань | Эрдэнэ | Нийт | |
| **Тулгамдсан асуудал мөн эсэх** | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 95% | 96% | 86% | 93% | 94% | 78% | 100 % | 100 % | 96% | 91% | 92% | 97% | 96% | 96% | 93% | 91% | 94% | **94%** |
| Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 86% | 89% | 90% | 89% | 89% | 69% | 90% | 85% | 93% | 83% | 86% | 87% | 87% | 88% | 91% | 83% | 87% | **87%** |
| Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн | 55% | 85% | 83% | 83% | 80% | 66% | 85% | 95% | 91% | 82% | 39% | 71% | 60% | 79% | 85% | 72% | 78% | **76%** |
| Ховор ан амьтны устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 63% | 68% | 74% | 78% | 71% | 41% | 61% | 76% | 78% | 61% | 65% | 67% | 66% | 65% | 82% | 69% | 70% | **68%** |
| Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 52% | 57% | 75% | 57% | 59% | 39% | 59% | 76% | 65% | 57% | 49% | 62% | 58% | 64% | 81% | 56% | 65% | **61%** |
| **Шалтгаан** | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 93% | 82% | 79% | 69% | 79% | 68% | 88% | 95% | 91% | 84% | 79% | 81% | 80% | 76% | 83% | 64% | 74% | **78%** |
| Ховор ан амьтны устал нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж байна | 81% | 70% | 72% | 67% | 71% | 72% | 98% | 88% | 95% | 86% | 74% | 88% | 84% | 76% | 78% | 66% | 74% | **77%** |
| **Шийдвэрлэх боломж** | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалах бүрэн боломжтой | 98% | 93% | 91% | 85% | 91% | 76% | 93% | 98% | 96% | 89% | 91% | 96% | 94% | 96% | 98% | 91% | 95% | **93%** |
| Ховор ан амьтныг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 98% | 87% | 81% | 83% | 86% | 75% | 90% | 93% | 98% | 87% | 76% | 85% | 82% | 91% | 90% | 79% | 87% | **86%** |
| Ховор ан амьтныг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 52% | 53% | 62% | 73% | 60% | 30% | 39% | 48% | 65% | 45% | 59% | 53% | 55% | 58% | 59% | 50% | 56% | **55%** |
| Ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй | 45% | 50% | 64% | 60% | 54% | 39% | 29% | 48% | 30% | 36% | 57% | 51% | 53% | 52% | 69% | 48% | 55% | **51%** |

*Маш их санал нийлж байна, Санал нийлж байна гэж хариулсан хувийн нийлбэр*

Ховор ан амьтантай холбоотой хандлагын үзүүлэлтүүдийг орлогын түвшнээр харьцуулан харвал өрхийн орлого нь 600,000 төгрөгөөс доош орлоготой иргэдийн хувьд "Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна", "Ховор ан амьтны устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал", гэдэгтэй санал нийлэх байдал илүү байна. "Ховор ан амьтныг хамгаалах бүрэн боломжтой" гэдэгтэй санал нийлэх байдал 600,000 төгрөгөөс дээш өрхийн орлоготой иргэдийн хувьд илүү өндөр байна.

Ховор ан амьтантай холбоотой асуудалд хандах хандлагыг хүйсээр харьцуулан харахад гол ялгаатай үр дүн нь "Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн", "Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой", "Ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй" гэдэгтэй эрэгтэйчүүд илүү их санал нийлж байна.

Ховор ан амьтанд хандах хандлагыг насаар харьцуулахад 40 -өөс дээш насны иргэд ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн гэдэгтэй санал нийлэх байдал илүү өндөр байна. Мөн шийдвэрлэх арга замын хувьд хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй, хүний оролцоо хэрэггүй гэдэгтэй илүү санал нийлж байна.

*Хүснэгт 8: Ховор ан амьтантай холбоотой хандлагын үзүүлэлтүүд, нас хүйс, орлогоор*

| ХАНДЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | Өрхийн орлого | | Хүйс | | Насны бүлэг | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 600,000 төгрөгөөс бага орлоготой | 600,001 төгрөгөөс их орлоготой | Эрэгтэй | Эмэгтэй | 40 -өөс доош нас | 40 -өөс дээш нас | |
| **Тулгамдсан асуудал мөн эсэх** | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 94% | 94% | 94% | 94% | 93% | 95% | **94%** |
| Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 89% | 84% | 86% | 87% | 85% | 89% | **87%** |
| Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн | 75% | 76% | 78% | 74% | 73% | 79% | **76%** |
| Ховор ан амьтны устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 70% | 65% | 69% | 68% | 67% | 70% | **68%** |
| Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 61% | 60% | 63% | 59% | 59% | 64% | **61%** |
| **Шалтгаан** | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 79% | 76% | 78% | 79% | 76% | 80% | **78%** |
| Ховор ан амьтны устал нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж байна | 76% | 77% | 77% | 77% | 76% | 77% | **77%** |
| **Шийдвэрлэх арга зам** | | | | | | | |
| Ховор ан амьтныг хамгаалах бүрэн боломжтой | 92% | 95% | 93% | 92% | 93% | 92% | **93%** |
| Ховор ан амьтныг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 86% | 86% | 85% | 87% | 85% | 87% | **86%** |
| Ховор ан амьтныг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 57% | 51% | 55% | 55% | 50% | 61% | **55%** |
| Ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй | 53% | 48% | 53% | 49% | 48% | 54% | **51%** |

*Маш их санал нийлж байна, Санал нийлж байна гэж хариулсан хувийн нийлбэр*

## *Сум орон нутагт нь нутагладаг ховор ан амьтны талаарх ойлголт*

Судалгаанд оролцсон иргэдээс тухайн сум орон нутагт нь ямар ховор ан амьтан нутагладаг талаар тодруулахад Архангай, Завхан аймагт тарвага, халиун буга, баданга хүдэр; Баянхонгор, Говь-Алтай аймагт хар сүүлтий, аргаль хонь, ирвэс, халиун буга, баданга хүдэр, янгир байдаг гэж хариулсан байна. Нийт судалгаанд оролцогчдын хувьд тарвагыг хамгийн ихээр нэрлэжээ.

*Хүснэгт 9: Сум орон нутагт нь нутагладаг ховор ан амьтан, байршлаар*

| | Байршил | | Аймгийн нэр | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| Тарвага | 45% | 53% | 18% | 94% | 83% | 37% | 50% |
| Аргаль хонь | 55% | 43% | 78% | 1% | 4% | 67% | 47% |
| Хар сүүлтий | 54% | 43% | 74% | 0% | 0% | 73% | 47% |
| Ирвэс | 53% | 43% | 68% | 7% | 4% | 70% | 46% |
| Халиун буга | 49% | 44% | 39% | 54% | 46% | 47% | 45% |
| Янгир | 29% | 25% | 45% | 1% | 11% | 32% | 27% |
| Баданга хүдэр | 6% | 6% | 0% | 11% | 20% | 0% | 6% |
| Аль нь ч биш | 1% | 1% | 1% | 0% | 1% | 1% | 1% |
| Хэлж мэдэхгүй | 6% | 5% | 4% | 0% | 2% | 9% | 5% |

## *Сум орон нутагт нь ховордсон ан амьтны ач тусын талаарх ойлголт*

Сум орон нутагт нь амьдардаг ховор ан амьтны ач тусыг тодруулахад хэлж мэдэхгүй гэсэн хариулт давамгайлж байв. Аргаль хонины ач тусыг тодруулахад "Гадаадын улс орнуудад Монгол зэрлэг хонь нэрээр, гоё сайхан эврээрээ Монголын нэрийг алдаршуулдаг", "Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг" гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байна. Ямар ч ач тусгүй гэж 3 хувь нь үзсэн.

*Хүснэгт 10: Аргаль хонины ач тус*

| АРГАЛЬ ХОНЬ | Тоо | Хувь |
|---|---|---|
| Гадаадын улс орнуудад Монгол зэрлэг хонь нэрээр, гоё сайхан эврээрээ Монголын нэрийг алдаршуулдаг | 219 | 36% |
| Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг | 209 | 34% |
| Хэлж мэдэхгүй | 206 | 34% |
| Ашигт ургамлын тархцыг нэмэгдүүлдэг | 97 | 16% |
| Мах идэшт амьтны идэш тэжээл болдог | 50 | 8% |
| Ангаж махыг хүнсэнд хэрэглэдэг | 26 | 4% |
| Ямар ч ач тусгүй | 19 | 3% |
| Үзэмжтэй | 1 | 0.3% |
| Байгальдаа хэрэгтэй | 1 | 0.2% |
| Эмчилгээний ач тустай | 1 | 0.2% |

Янгирын ач тусыг тодруулахад "Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг" гэсэн хувилбар хамгийн өндөр хувьтай байна. Мөн хэлж мэдэхгүй гэж 34 хувь нь үзсэн байна.

*Хүснэгт 11: Янгирын ач тус*

| **ЯНГИР** | **Тоо** | **Хувь** |
|---|---|---|
| Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг | 119 | 34% |
| Хэлж мэдэхгүй | 118 | 34% |
| Гадаадын улс орнуудад Монгол зэрлэг хонь нэрээр, гоё сайхан эврээрээ Монголын нэрийг алдаршуулдаг | 103 | 30% |
| Ашигт ургамлын тархцыг нэмэгдүүлдэг | 53 | 15% |
| Мах идэшт амьтны идэш тэжээл болдог | 36 | 10% |
| Ямар ч ач тусгүй | 10 | 3% |
| Ангаж махыг хүнсэнд хэрэглэдэг | 8 | 2% |

Тарваганы ач тусыг тодруулахад "Хэлж мэдэхгүй", "Хөрсийг сийрэгжүүлж, чийг агаарын солилцоог сайжруулдаг" гэсэн хариулт хамгийн өндөр байна. Мөн агнуурын зорилгоор ашигладаг гэж хариулжээ. Үүнд, эрүүл мэндэд ач тустай, агнаж хүнсэнд хэрэглэдэг, арьсыг ашигладаг зэрэг хариултыг дурдсан байна.

*Хүснэгт 12: Тарваганы ач тус*

| **ТАРВАГА** | **Тоо** | **Хувь** |
|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 293 | 45% |
| Хөрсийг сийрэгжүүлж, чийг агаарын солилцоог сайжруулдаг | 142 | 22% |
| Газрын давхаргыг хольж ургамлын ургалтыг нэмэгдүүлдэг | 100 | 15% |
| Ангаж махыг хүнсэнд хэрэглэдэг | 100 | 15% |
| Ургамалд асар их эерэг нөлөө үзүүлдэг | 64 | 10% |
| Мах идэшт амьтдад идэш тэжээл болдог | 53 | 8% |
| Мал зэрлэг амьтны бэлчээрийн өвс ургамлыг булаах, хороох сөрөг нөлөөгүй | 43 | 7% |
| Ямар ч ач тусгүй | 32 | 5% |
| Эрүүл мэндэд ач тустай | 12 | 2% |
| Ялгадас, сэг зэм нь задарч хөрсийг борддог | 5 | 1% |
| Арьсаар нь юм хийдэг | 3 | 0.5% |

Халиун бугын ач тусын талаар тодруулахад "Хэлж мэдэхгүй", "Өвс ургамал идсэнээрээ ургамлын зүйлийн олон янз байдал баяжихад тустай" гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байна. Мөн халиун бугыг агнаж махыг нь хүнсэнд хэрэглэдэг (8%) байна.

*Хүснэгт 13: Халиун бугын ач тус*

| **ХАЛИУН БУГА** | **Тоо** | **Хувь** |
|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 240 | 41% |
| Өвс ургамал идсэнээрээ ургамлын зүйлийн олон янз байдал баяжихад тустай | 107 | 18% |
| Туурайгаараа газар гишгэлснээр хөрсийг ил гаргаж зарим төрлийн ургамлын үр соёолох нөхцөл бүрдүүлдэг | 96 | 16% |
| Эврийг ашигладаг | 94 | 16% |
| Агнаж махыг нь хүнсэнд хэрэглэдэг | 47 | 8% |
| Ямар ч ач тусгүй | 29 | 5% |
| Мах идэшт амьтдад идэш тэжээл болдог | 26 | 4% |
| Унасан цусан эвэр нь жижиг хөхтөн амьтдын хоол болдог | 25 | 4% |
| Ялгадас нь олон зүйлийн мөөг ургах тэжээллэг орчин үүсгэдэг | 19 | 3% |
| Байгалийг чимдэг | 5 | 1% |
| Эрүүл мэндэд ач тустай | 1 | 0.2% |
| Усны гаралтыг сайжруулдаг | 1 | 0.2% |

Ирвэсийн ач тусын талаар тодруулахад "Хэлж мэдэхгүй", "Амьдарч буй уулынхаа экосистемийн эрүүл онгон байдлыг хадгалдаг" зэрэг хариулт хамгийн өндөр хувьтай байна. Ямар ч ач тусгүй амьтан гэж 6 хувь нь үзсэн байна.

*Хүснэгт 14: Ирвэсийн ач тус*

| ИРВЭС | Тоо | Хувь |
|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 348 | 58% |
| Амьдарч буй уулынхаа экосистемийн эрүүл онгон байдлыг хадгалдаг | 150 | 25% |
| Аргаль янгир, зээр гэх мэт туурайтан амьтдын сүргээс хөгшин, доройг нь барьж идэн цэвэрлэгээ хийдэг | 103 | 17% |
| Ирвэс байгаа газар аргаль янгир элбэг байдаг | 60 | 10% |
| Ямар ч ач тусгүй | 37 | 6% |

Хар сүүлтийн ач тусыг тодруулахад "Хэлж мэдэхгүй", "Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг" зэрэг хариулт хамгийн өндөр хувьтай байна.

*Хүснэгт 15: Хар сүүлтийн ач тус*

| ХАР СҮҮЛТИЙ | Тоо | Хувь |
|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 271 | 43% |
| Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг | 252 | 40% |
| Ашигт ургамлын тархцыг нэмэгдүүлдэг | 75 | 12% |
| Ямар ч ач тусгүй | 54 | 9% |
| Агнаж махыг нь хүнсэнд хэрэглэдэг | 25 | 4% |
| Байгалийн чимэг | 4 | 1% |
| Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ач тустай | 4 | 1% |
| Байгалийн цэвэрлэгээ хийдэг | 2 | 0.3% |
| Улаан номд орсон | 1 | 0.2% |

Баданга хүдрийн ач тусыг тодруулахад "Хэлж мэдэхгүй", "Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг" гэж хамгийн өндөр хувьтай хариулжээ.

*Хүснэгт 16: Баданга хүдрийн ач тус*

| БАДАНГА ХҮДЭР | Тоо | Хувь |
|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 197 | 45% |
| Биологийн тэнцвэрт байдлыг хангадаг | 154 | 35% |
| Ашигт ургамлын тархцыг нэмэгдүүлдэг | 65 | 15% |
| Мах идэшт амьтдад идэш тэжээл болдог | 29 | 7% |
| Хүдрийн заарыг ашиглах | 28 | 6% |
| Ямар ч ашиг тусгүй | 20 | 5% |
| Байгалийн чимэг | 1 | 0.2% |
| Ач тусгүй | 1 | 0.2% |
| Сэг зэм устгана | 1 | 0.2% |

Сүүлийн жилүүдэд эдгээр ан амьтан хэр зэрэг ховордож байгааг тодруулахад аргаль хонь, тарвагыг хамгийн их ховордож байна гэж үзжээ. Аргаль хонь, тарвага, янгир зэргийг Архангай аймгийн иргэд хамгийн их ховордож байна гэж үзсэн байна. Ирвэс, баданга хүдэр зэрэг амьтныг Завхан аймгийн иргэд хамгийн их ховордож байна гэж үзжээ. Халиун бугыг Говь-Алтай аймгийн иргэд хамгийн их ховордож байна гэж хариулсан байна.

*Хүснэгт 17: Ан амьтны ховордож буй байдал, аймгаар*

| | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Аргаль хонь | 3.81 | 5.00 | 4.44 | 4.13 | **4.00** |
| Тарвага | 3.38 | 4.42 | 3.99 | 3.20 | **3.85** |
| Янгир | 3.60 | 4.00 | 3.81 | 3.63 | **3.63** |
| Ирвэс | 3.75 | 3.93 | 4.50 | 3.44 | **3.59** |
| Хар сүүлтий | 3.85 | - | - | 3.34 | **3.55** |
| Халиун буга | 3.75 | 3.68 | 2.67 | 3.97 | **3.43** |
| Баданга хүдэр | - | 2.58 | 3.81 | - | **3.40** |

/1-Огт ховордоогүй, 5-Маш их ховордож байна/

## *Ховордож буй шалтгаан*

Эдгээр амьтны ховордож буй шалтгааныг тодруулахад хамгийн том шалтгаан нь "хууль бус ан" гэж үзсэн байна. Мөн яагаад ховордоод байгаа шалтгааныг нь мэдэхгүй гэсэн хариулт өндөр байна.

Аргаль хонины ховордож буй гол шалтгаан нь "махчин амьтанд идүүлэх"; янгирын ховордож буй гол шалтгаан нь "малтай бэлчээрийн давхцалд орж дайжих, зориудаар үргээх"; тарваганы ховордож буй гол шалтгаан нь "хууль бус ан"; халиун буга, ирвэс, баданга хүдрийн ховордож буй шалтгааныг "мэдэхгүй" гэж хариулсан хувь хамгийн өндөр байна.

*Хүснэгт 18: Ан амьтны ховордож буй шалтгаан*

| | Аргаль хонь | Янгир | Тарвага | Халиун буга | Ирвэс | Хар сүүлтий | Баданга хүдэр | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хууль бус ан | 19% | 33% | 64% | 28% | 21% | 7% | 13% | 26% |
| Мэдэхгүй | 5% | 16% | 11% | 47% | 31% | 20% | 9% | 20% |
| Малтай бэлчээрийн давхцалд орж дайжих, зориудаар үргээх | 21% | 38% | 15% | 10% | 21% | 2% | 17% | 18% |
| Нуур, цөөрөм, голын усны түвшин багасах, ширгэх | 18% | 31% | 7% | 6% | 21% | 2% | 14% | 14% |
| Махчин амьтанд идүүлэх | 22% | 29% | 8% | 7% | 14% | 1% | 16% | 14% |
| Зам тавих, дэд бүтэц хөгжих | 10% | 14% | 6% | 5% | 6% | 0% | 7% | 7% |
| Ган зуд үерт өртөх | 8% | 10% | 0% | 1% | 4% | 1% | 7% | 4% |
| Эд эрхтнийг нь хил дамнуулан наймаалах | 4% | 6% | 5% | 4% | 5% | 2% | 2% | 4% |
| Түймэрт өртөх | 4% | 7% | 2% | 2% | 1% | 0% | 2% | 3% |
| Халдварт өвчин тусах | 1% | 3% | 3% | 5% | 4% | 0% | 1% | 2% |
| Байгаль цаг уурын өөрчлөлт | 2% | 2% | 8% | 1% | 1% | 1% | 1% | 2% |
| Мал руу дайрснаас үүдэлтэй намнах | 1% | 1% | 0% | 2% | 7% | 2% | 1% | 2% |
| Бэлчээрийн даац хэтэрснээс болж өвс тэжээлийн дутагдалд орж дайжих | 3% | 1% | 0% | 2% | 3% | 0% | 2% | 2% |
| Сүргийн бүтцийг алдагдуулсан | 1% | 2% | 1% | 5% | 0% | 1% | 1% | 2% |
| Хөөж, шахан зайлуулсан | 2% | 1% | 0% | 1% | 3% | 1% | 1% | 1% |
| Идэш тэжээл хомстох | 1% | 1% | 3% | 1% | 1% | 0% | 1% | 1% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Амьжиргааны эсхүл арилжааны зорилгоор агнах | 1% | 1% | 2% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Спорт, хоббины зорилгоор агнах | 2% | 1% | 0% | 1% | 1% | 0% | 0% | 1% |

Эдгээр ан амьтдыг хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй эсэхийг тодруулахад янгирыг хамгаалах хэрэгтэй гэж 97 хувь буюу хамгийн өндөр хувьтай дэмжиж байна. Хамгийн бага нь халиун буга бөгөөд 88 хувь нь хамгаалах хэрэгтэй гэж дэмжсэн байна.

*График 35: Хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй, амьтнаар*




*Маш их санал нийлж байна, Санал нийлж байна гэж хариулсан хувийн нийлбэр*

## *Сум орон нутагтаа ховордсон амьтныг хамгаалах зохистой арга*

Эдгээр амьтдыг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй талаар тодруулахад нийт оролцогчдын 15 хувь нь "тархац нутгийг тусгай хамгаалалтад авах", 15 хувь нь "тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг илүү сайжруулах", 13 хувь нь "хууль бус агналтыг таслан зогсоох" гэж хариулсан байна.

*Хүснэгт 19: Ховордсон ан амьтныг хамгаалахын тулд авах арга хэмжээ*

| | Аргаль хонь | Янгир | Тарвага | Халиун буга | Ирвэс | Хар сүүлтий | Баданга хүдэр | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тархац нутгийг тусгай хамгаалалтад авах | 20% | 18% | 15% | 11% | 16% | 17% | 8% | **15%** |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг илүү сайжруулах | 17% | 17% | 18% | 11% | 15% | 16% | 8% | **15%** |
| Хууль бус агналтыг таслан зогсоох | 13% | 13% | 32% | 11% | 9% | 12% | 3% | **13%** |
| Ус тэжээлээр хангах | 16% | 14% | 6% | 3% | 7% | 12% | 2% | **9%** |
| *Хэлж мэдэхгүй* | *5%* | *4%* | *6%* | *12%* | *7%* | *5%* | *11%* | ***7%*** |
| Зориудаар өсгөж үржүүлэх | 8% | 9% | 9% | 8% | 5% | 7% | 4% | **7%** |

| | Аргаль хонь | Янгир | Тарвага | Халиун буга | Ирвэс | Хар сүүлтий | Бадан га хүдэр | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах | 9% | 10% | 8% | 3% | 6% | 7% | 1% | **6%** |
| Хууль бус худалдааг таслан зогсоох | 7% | 6% | 11% | 3% | 5% | 5% | 1% | **5%** |
| Хяналтын камер тавьж тоо толгой, тархцыг хянах | 8% | 7% | 3% | 2% | 6% | 5% | 1% | **5%** |
| Тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах | 5% | 6% | 4% | 3% | 5% | 5% | 1% | **4%** |
| Амьтны тухай хуулийн талаарх сургалтыг иргэдэд орох | 6% | 5% | 4% | 2% | 5% | 4% | 2% | **4%** |
| Тухайн амьтанд хүзүүвч зүүж тоо толгой, тархцыг нь хянах | 6% | 6% | 3% | 1% | 6% | 4% | 1% | **4%** |
| Бэлчээрийн зүй зохистой хуваарилалт хийх | 6% | 6% | 3% | 1% | 4% | 6% | 1% | **4%** |
| Өвчин эмгэгээс сэргийлэх | 5% | 3% | 6% | 1% | 3% | 4% | 1% | **3%** |
| Тоо толгой, тархцыг нь хянах судалгааг тогтмол хийх | 4% | 4% | 2% | 2% | 4% | 4% | 1% | **3%** |
| Агнуурын бүс нутгийг байгуулах | 4% | 3% | 4% | 1% | 3% | 4% | 1% | **3%** |
| Хууль бус экспортыг таслан зогсоох | 4% | 4% | 4% | 1% | 3% | 3% | 1% | **3%** |
| Ангийн дээд тоо хэмжээг тогтоон төлбөртэйгөөр боломжит хэмжээгээр агналтыг зөвшөөрөх | 2% | 2% | 3% | 1% | 2% | 2% | 2% | **2%** |

## *Ховордож буй ан амьтныг хамгаалдаг хэлбэр*

Судалгаанд оролцсон иргэдээс ховордсон ан амьтныг ямар хэлбэрээр хамгаалдгийг тодруулахад юу ч хийдэггүй гэсэн хувь хамгийн өндөр байна. Нийт судалгаанд оролцогчдын 28 хувь нь "бусдад ховор ан амьтныг хамгаалах талаар ойлгуулж хэлдэг", 10 хувь нь "хууль бус ан агнуурыг холбогдох хууль шүүхийн газар мэдээлэлдэг" гэж хариулсан.

*Хүснэгт 20: Ховордож буй ан амьтныг хамгаалдаг хэлбэр*

| | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Юу ч хийдэггүй | 49% | 56% | 76% | 30% | 48% |
| Бусдад ховор ан амьтныг хамгаалах талаар ойлгуулж хэлдэг | 16% | 29% | 14% | 43% | 28% |
| Хууль бус ан агнуурыг холбогдох хууль шүүхийн газар мэдээлэлдэг | 13% | 5% | 2% | 13% | 10% |
| Ховор амьтны амьдрах орчныг хамгаалах зорилгоор малын тоо толгойндоо хяналт тавьдаг | 14% | 2% | 3% | 8% | 8% |
| Ус, өвс тэжээл тавьж өгдөг | 7% | 2% | 4% | 9% | 7% |
| Амьтны хамгааллын талаарх сургалтад хамрагддаг | 7% | 2% | 2% | 6% | 5% |
| Ховор ан амьтдыг хамгаалах нөхөрлөлд нэгдсэн | 4% | 5% | 2% | 3% | 4% |

### *Цаашид орон нутагтаа ховордож буй ан амьтныг хамгаалах хэлбэр*

Цаашид орон нутагтаа ховордож буй ан амьтныг хамгаалах хэлбэрийг тодруулахад 25 хувь нь "сум орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллах" 23 хувь нь "бусдад ховор ан амьтныг хамгаалах талаар ойлгуулж хэлэх", 23 хувь нь "ховор ан амьтныг хамгаалах нөхөрлөлд нэгдэнэ", 18 хувь нь "ан амьтныг хамгаалах чиглэлээр сургалтад сууна" гэж хариулсан байна.

*Хүснэгт 21: Цаашид орон нутагтаа ховордсон ан амьтныг хамгаалах хэлбэр*

| | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Сум орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллах | 26% | 14% | 24% | 30% | 25% |
| Бусдад ховор ан амьтныг хамгаалах талаар ойлгуулж хэлэх | 14% | 14% | 9% | 42% | 23% |
| Ховор ан амьтныг хамгаалах нөхөрлөлд нэгдэнэ | 29% | 16% | 19% | 24% | 23% |
| Ан амьтныг хамгаалах чиглэлээр сургалтад сууна | 16% | 9% | 15% | 27% | 18% |
| Хэлж мэдэхгүй | 27% | 21% | 19% | 8% | 17% |
| Хууль бус үйл ажиллагаар холбогдох байгууллагад мэдэгдэнэ | 14% | 6% | 11% | 22% | 15% |
| Бэлчээрийн зүй зохистой хуваарилалт хийнэ | 14% | 7% | 5% | 21% | 14% |
| Мэдээллийг олон сувгаар авах | 8% | 16% | 15% | 15% | 13% |
| Ховор амьтны амьдрах орчныг хамгаалах зорилгоор малын тоо толгойд хяналт тавина | 8% | 4% | 3% | 15% | 9% |
| Ховордсон ан амьтанд ус, өвс тэжээл өгөх | 8% | 2% | 4% | 13% | 8% |
| Амьтдыг ажиглах мониторинг судалгаанд идэвхтэй оролцох сонирхолтой | 2% | 7% | 4% | 1% | 3% |

## 5.2. Гол оролцогч талуудын ховор ан амьтанд хандах хандлага

### *Архангай аймаг*

Архангай аймгийн Батцэнгэл, Эрдэнэмандал, Өлзийт, Хайрхан зэрэг сумын гол оролцогчид судалгаанд хамрагдсан. Эдгээр сумуудад ховор ан амьтантай холбоотой үүсэж буй асуудлыг тодруулахад дараах асуудлуудыг дурдав.

Архангай аймгийн сумын түвшний гол оролцогчдын үзэж байгаагаар тарвага, эдлэг шонхор, баданга хүдэр зэрэг амьтад ихээр ховордож байна. Мөн ойн түймэр, нуур цөөрөм ширгэснээс нүүдлийн шувууд багассан гэв. Харин халиун буга ховордож байсан ч хамгаалалтад авсан учир эргээд тоо толгой нь өсөж байна гэдгийг дурдав. Зэрлэг ан амьтан ховордож буй шалтгаан нь:

- Хууль бус ан /Хүдрийн цусыг нь уух гэж их хэмжээгээр агнах гэх мэт/
- Бэлчээр доройтсоноос мал ой руу орж шилмүүс идэх, улмаар зэрлэг амьтад дайжих
- Малчид ой руу нүүж орох
- Өвс тэжээлийн хомсдол
- Ойн түймэр
- Ган, зуд, байгалийн гамшиг
- Нуур цөөрөм ширгэх зэрэг асуудал хамгийн их нөлөөлсөн гэж үзэж байна.

Ховор ан амьтныг хамгаалахын тулд:

- ✓ Нөхөн төлжүүлэх
- ✓ Нутагшуулах
- ✓ Ойн хамгаалалтын орон тоог нэмэгдүүлэх
- ✓ Төрөөс тусгай хамгаалалтад авах
- ✓ Хууль бус антай холбоотой хуулийн заалтуудыг чангалах, хатуу мөрдөх
- ✓ Ам амьтныг хамгаалах нөхөрлөлүүд хамтран ажиллах зэрэг арга хэмжээ авч болно гэв.

Ховор ан амьтны ач тусын талаар тодруулахад:

- ✓ Байгалийн тэнцвэрт байдлыг хангана
- ✓ Аялал жуулчлалыг хөгжүүлэх
- ✓ Байгалын унаган төрхийг алдагдахаас сэргийлэх зэрэг ач тустай гэж үзжээ.

***Шигтгээ:*** Саарал чоно байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж байдаг ховор амьтан. Ялангуяа өвчтэй, амьдрах чадваргүй амьтадыг барьж идэн байгаль экологийг цэвэрлэж байдаг.

*Архангай аймаг, Өлзийт сумын гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Тарвага хөрсийг сайн сийрэгжүүлдэг, тарвага байгаа газар үлийн цагаан оготно гэх мэт янз бүрийн хортон мэрэгч амьтад байдаггүй.

*Архангай аймаг, Өлзийт сумын гүнзгийрүүлсэн ярилцлага*

### *Завхан аймаг*

Завхан аймгаас Тосонцэнгэл, Их-Уул зэрэг сумын гол оролцогчид судалгаанд хамрагдсан. Тус аймгийн сум, орон нутагт ховор ан амьтантай холбоотой ямар асуудал үүсэж буйг тодруулахад сүүлийн жилүүдэд хяналт сайн хийгдэж байгаа учраас хууль бус ан маш цөөрсөн, харин хар галууны сөрөг нөлөө их байгааг дурдав. Хар галуу нь загасыг ихээр иддэг тул байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзсэн байна. Ховордож буй ан амьтанд хүдэр, хэрэм, буга, тарвага зэрэг амьтан орж байна гэж үзжээ.

*Ховордож буй шалтгаан нь:*

- Байгаль цаг уурын өөрчлөлт
- Өвлийн улиралд биотехнологийн арга хэмжээ аваагүйгээс турж эцэх
- Хүмүүс байгаль орчинтойгоо зөв харьцаагүй
- Түймэр
- Малын тоо толгой өсөх
- Хууль бус ан
- Усан цахилгаан станц загасны амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх зэрэг багтаж байна.

*Ховор ан амьтныг хамгаалахын тулд:*

- ✓ хүмүүс байгаль орчинтойгоо зөв харьцах
- ✓ ховордсон амьтныг нутагшуулах
- ✓ Эр хүдэр нутагшуулах

- ✓ Усан цахилгаан станцыг цэвэрлэх, гарц хоолойг байгальд сөрөг нөлөөгүй болгох талаас нь янзлах хэрэгтэй гэж үзжээ.

*Ховор ан амьтны ач тус нь:*

- ✓ Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах
- ✓ Байгалийг нөхөн сэргээх
- ✓ Байгалийн чимэг зэрэг ач тустай гэв.

***Шигтгээ:*** Байгалийн бүх зүйл хоорондоо уялдаа холбоотой учраас цогцоороо байвал байгаль тэнцвэртээ оршино.

*Завхан аймаг, Их-Уул сумын гүнзгийрүүлсэн ярилцлага*

## *Баянхонгор аймаг*

Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст зэрэг сумын гол оролцогчид судалгаанд хамрагдсан. Баянхонгор аймагт ан амьтантай холбоотой үүсэж буй асуудал нь зээр, аргаль, янгир, баданга хүдэр, ирвэс, хавтгай, мазаалай зэрэг ховор амьтны тоо толгой цөөрч буй хэрэг юм.

Говийн дархан цаазат газрын хамгаалалттай учир хулгайн ан агнуурын асуудал бараг гардаггүй. Зэрлэг ан амьтан ховордож буй шалтгаан нь:

- Бэлчээрийн даац хэтрэлтээс болж зэрлэг амьтан дайжих
- Малын тоо толгой өсөх
- Хоол тэжээлийн хомсдолд орох
- Цаг агаар, уур амьсгалын өөрчлөлт
- Усны нөөцийн асуудал хамгийн их тулгамдаж байна гэж үзжээ.

***Шигтгээ:*** Малын тоо толгой өссөнөөс ашигладаггүй байсан зэрлэг ан амьтны бэлчээр лүү орсон байдаг. Үүнээс холбоотой зэрлэг ан амьтан хоол тэжээлгүй болох, тухайн орон нутгаас дайжих, тоо толгой нь улмаар цөөрөх асуудал гарч байна.

*Баянхонгор аймаг, Баацагаан сумын гүнзгийрүүлсэн ярилцлага*

Ховор ан амьтныг хамгаалахын тулд Баянхонгор аймгийнхан мөс, өвс тавьж өгдөг байна. Үүнээс гадна:

- ✓ Камер суурилуулах
- ✓ Бэлчээрийн зүй зохистой менежмент хэрэгжүүлэх
- ✓ Усны асуудлыг нь шийдэх зэрэг арга хэмжээ авах (Булаг шандыг тохижуулах, ширгэсэн нуур цөөрмийг задгайлж, хөв цөөрөм байгуулах)
- ✓ Бэлчээрийн даацад тохируулж мал маллах
- ✓ Иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулж, байгаль хамгаалагчийн эрх олгох
- ✓ Ховордсон ан амьтны **байгаль орчинд үзүүлэх ач тус**-ыг таниулах сургалт, сурталчилгааг иргэдэд хүргэх хэрэгтэй гэж үзэж байна.

Ховор ан амьтны ач тус нь:

- ✓ Сум орон нутгийг сурталчлах
- ✓ Ховор ан амьтнаа харж баясах, омогших
- ✓ Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах

- ✓ Аялал жуулчлалыг хөгжүүлэх
- ✓ Үр хойчдоо үлдээх зэрэг ач тустай гэж үзсэн байна.

### *Говь-Алтай аймаг*

Говь-Алтай аймгийн Цогт, Эрдэнэ, Чандмань зэрэг сумын гол оролцогчид судалгаанд хамрагдсан байна. Говь-Алтай аймагт ховор ан амьтан, шувуутай холбоотой ямар асуудал үүсэж буйг тодруулахад "Говийн гайхамшигт 6" болох хавтгай, мазаалай, тахь, хулан, монгол бөхөн, хар сүүлт, мөн ирвэс, аргаль, янгир, хойлог, бүргэд зэрэг амьтдын тоо толгойн хомсдох асуудал үүссэн гэж байв.

Эдгээр амьтдын цөөрч буй гол шалтгаан нь:

- Өвс тэжээлийн хомсдол
- Бэлчих газаргүй болсноос дайжих
- Усны нөөцийн асуудал
- Цаг уурын өөрчлөлт
- Хууль бус ан (бага) зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзжээ.

Ховордсон ан амьтдыг хамгаалахын тулд:

- ✓ Худаг гаргах
- ✓ Хоол тэжээл бэлдэх
- ✓ Тусгай хамгаалалтын газруудтай хамтран ажиллах
- ✓ Олон улсын байгууллага төсөл хөтөлбөртэй хамтарч ажиллах гэх мэт арга хэмжээ авч ажиллаж байна.

**Ерөнхий үр дүн**

Гол оролцогч талууд ховор ан амьтантай холбоотой үүсэж буй асуудлыг хүний хүчин зүйл болон байгалийн хүчин зүйлтэй холбоотой гэж үзэж байна. Хүний хүчин зүйлд хулгайн ан агнуур, малын тоо толгойн хэт өсөлт, хотжилт, бэлчээрийн буруу ашиглалт зэргийг багтаан ойлгож байна. Байгалийн хүчин зүйлд цаг уурын өөрчлөлт, бороо хур орохгүй байх зэргээс үүдэн хоол тэжээл, усны хомсдолд орж байгаа гэж үзжээ.

Халиун буга, мазаалай, хулан зэрэг амьтныг хамгаалах арга хэмжээг төрөөс болон олон улсын байгууллагууд идэвхтэй хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд тоо толгой нь өсөж байгаа хэдий ч цаашид хийх ажил олон байгааг дурдав. Үүнд: хулгайн ан агнуурын хяналтыг чангатгах, байгаль хамгаалагчийн тоог нэмэгдүүлэх, усны асуудлыг шийдвэрлэх, булаг шандыг хамгаалах, өвөл мөс тавьж өгөх, биотехнологийн арга ашиглах, малын тоо толгойн хяналт тавьж, бэлчээрийг зүй зохистой ашиглах гэх мэт олон ажлыг нэрлэж болно. Сум орон нутгийн иргэд, амьтан хамгаалах нөхөрлөл, хоршоо, төрийн байгууллагууд хамтран ховор ан амьтанд мөс, өвс тавьж өгөх, нутагшуулах, тоолох, нэн ховордсон амьтдыг тусгай хамгаалалтад авах арга хэмжээг голчлон авч байна.

*Хүснэгт 22: Гол оролцогч талуудын ан амьтантай холбоотой асуудалд хандах хандлага*

| | Архангай | Завхан | Баянхонгор | Говь-Алтай |
|---|---|---|---|---|
| Ан амьтантай холбоотой үүсэж буй асуудал | • Тэрхийн цагаан нууранд **хар галуу** нуурын усыг бохирдуулж, загасыг цөөрүүлэх асуудал гарч байна<br>• Зэрлэг гахай, бор гөрөөс, буга согоо зарим газар өсөж, зарим газар устсан<br>• Тарвага ихэнх газар устаж байна<br>• Шонхорын хамгаалалтын хараа хяналт сул байгаа | • Амьтдаас нүүдлийн шувуу, тарвага, эр хүдэр, цоохор ирвэс, ангир, буга, аргал, ургамлаас хонин харц, вансэмбэрүү зэрэг багассан<br>• Ирвэс мал руу дайрах<br>• Ирвэс мал руу дайрснаас болж малчидтай зөрчилдөх<br>• Хар сүүлт, бөхөн өвчтэй орж ирэн малд өвчин тараах<br>• Тусгай ангаас орсон орлогыг амьтан хамгаалах чиглэлд зарцуулахгүй байх | • Тарвага, шонхрын хулгайн ан их<br>• Мазаалай, хулан, хавтгай, хар сүүлт, бөхөн зэрэг амьтад ховордож байна<br>• Шонхор шувуу ховордсоноор бэлчээрийн хортон мэрэгчид нэмэгдэж, түүнийг устгах ажилд их мөнгө зарцуулж байна<br>• Хойлгийн мах эмийн чанартай учраас ан ав ихээр хийж ховордож байгаа | • Говийн гайхамшигт 6 болох хавтгай, мазаалай, тахь, хулан, монгол бөхөн, хар сүүлт ховордож байна<br>• Бэлчээрийн даац хэтэрснээс өвс ургамал нь ховордож байна<br>• Хоол тэжээлийн хомсдол<br>• Усны хомсдол<br>• Бэлчээр булаацалдах, малчид нутагт нь түрж орж ирснээс болж дайжих<br>• Ирвэс мал руу дайрснаас болж малчид дургүйцэх |
| Шалтгаан | • Хулгайн ан их<br>• Хар галуу Тэрхийн цагаан нуур, Өгийн нуурын загасыг барьж идэх<br>• Тарвага агнах асуудал их<br>• Бэлчээр муудсанаас болоод зэрлэг ан амьтны тархцыг багасгах, үргээх зэрэг асуудлууд үүсэж байна<br>• Ангын зах зээлийн ханш өндөр<br>• Цаг уурын өөрчлөлт | • Байгаль цаг уурын нөхцөл (Булаг шанд, ус ширгэх, өвс ургамал багасах, ургахаа болих, ган зуд болох)<br>• Хулгайн ан<br>• Түймэр<br>• Бэлчээрийн даац хэтэрсэн тул амьдрах орчин нөхцөл байхгүй байна<br>• Эмчилгээний зориулалтаар хүмүүс их агнаж байна<br>• Байгаль хамгаалагчийн хүрэлцээ муу<br>• Төрийн бодлого муу<br>• Иргэдийн амьжиргаа муу | • Хоол тэжээлийн хомсдол<br>• Усан хангамж муу<br>• Хулгайн ан<br>• Том ачааны машин явж зам талхлах<br>• Уул уурхай, зам тавих зэрэг асуудлаас болж зэрлэг амьтад дайжих<br>• Бороо хур муутайгаас зэрлэг амьтдын иддэг ургамал ховор ургах<br>• Хүний үйл ажиллагаа, хотжилт, техникийн хөгжил нь зэрлэг амьтны амьдрах орчныг үгүй хийж байна | • Хууль бус ан агнуур<br>• Малын хэт өсөлт<br>• Хүнс тэжээл, усны хомсдол<br>• Машин<br>• Байгалийн эрс тэс уур амьсгалаас болж идэж тэжээл хомсдож байна<br>• Төсөв мөнгө бага учраас хамгаалал бага<br>• Малын халдварт өвчин (мялзан) -өөс болж хар сүүлтий, бөхөн цөөрөх<br>• Бэлчээрийн доройтол, бэлчээрийн давхцал их |
| Одоогийн байдлаар авч буй арга хэмжээ | • Тарвага суурьшуулах ажил хийгдэж байгаа<br>• Өгийн нуур дээр Японы хөрөнгө оруулалттай “Шувуу ажиглах төв” гэж мэдээлэл цуглуулах, аялал | • Био технологийн арга хэмжээ авдаг<br>• Нэн ховордсон амьтны тоог гарган зөвшөөрлөөр агнах боломжит тоог гаргадаг. Түүнээс орсон орлогыг буцаан байгаль хамгаалах ажилд хөрөнгө оруулдаг | • Мазаалайг хамгаалах зорилгоор “Мазаалай” сан, төрөөс тодорхой хэмжээний өвс хүнс (хорголжин), усаар хангах бодлогын ажил хийгдэж байгаа<br>• Мазаалайг хамгаалах зорилгоор тэжээл тавьж | • Нутгийн иргэд ховордсон ан амьтдаа хайрлаж хамгаалдаг<br>• Өвс тавьж өгдөг<br>• Тусгай хамгаалалтад авсан |

| | Архангай | Завхан | Баянхонгор | Говь-Алтай |
|---|---|---|---|---|
| | журулчлал татах төв байгуулагдсан<br>• Цас зуд болсон үед зэрлэг амьтад идэш тэжээлээр их дутагддаг. Тиймээс байгаль орчны газрынхан нутагладаг газарт нь идэш тавьж өгсөн | • Ард иргэд сайн дураараа ховордсон амьтдыг тоолох ажил хийдэг. Тэдгээр хүмүүсийг урамшуулах хэрэгтэй | өгдөг, хүзүүнд нь хүзүүвч зүүж хаана явж байгааг нь тодорхойлдог<br>• Усан хангамжийг сайжруулах зорилгоор өвлийн улиралд мөс тавьж өгдөг | |
| Цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ | • Агнуурын бүсээ зөв зохион байгуулалттай хийн сум орон нутагтайгаа хамтран байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд орлого олох боломж байна гэж үзэж байна<br>• Ганцхан байгаль хамгаалагч ан амьтныг хамгаалж дийлэхгүй учир нутгийн иргэдтэй хамтрах хэрэгтэй<br>• Хууль хяналтын байгууллага хууль бус ангийн бодлогоо чангатгах хэрэгтэй<br>• Иргэдийн амьжиргааг сайжруулж хулгайн ан хийхгүйгээр амьдрах чадвартай болгох<br>• Ховор ан амьтны тоо толгой цөөрч байгааг, ач тусыг хүмүүст мэдээлэх | • Өвөл зуд болохоор зэрлэг амьтад өвс тэжээлгүй болдог. Тэгэхээр бага зэрэг хөрөнгө санхүү гаргаад тэжээл, хужрыг нь бэлдээд өгөх хэрэгтэй<br>• Залгаа аймаг, сумууд хамтран тухайн сум орон нутагтаа ховордсон амьтдыг хамгаалж ажиллавал илүү үр дүнтэй<br>• Ган зудтай үед зэрлэг амьтад хүмүүс дээр ирдэг. Тэр үед нь хоол тэжээл тавьж өгөх хэрэгтэй<br>• Ховор ан амьтны хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах нь чухал | • Сургалт сурталчилгаа сайн хийх<br>• Хортон шавжаас урьдчилан сэргийлэх<br>• Мазаалайг хамгаалахын тулд зоо паркт үржүүлээд буцаад байгальд нь тавих арга хэмжээг авах хэрэгтэй<br>• Мазаалайн үснээс генийг нь авч үржүүлэх (Хятадууд Панда баавгайн үсийг нь ашиглан генийг нь авч үржүүлсэн туршлагаас суралцах )<br>• Хууль бусаар шонхор барьж байгаа хүмүүсийг буурууулах<br>• Бүгд хуулийн хүрээнд ажиллах<br>• Хяналт шалгалтыг иргэд болон эрх бүхий хүмүүст аль алинд нь сайн хийх<br>• Хамгаалалтын арга хэмжээг сайжруулах<br>• Зэрлэг ан амьтныг хамгаалах нөхөрлөлүүдийг дэмжиж ажиллах<br>• Иргэдийг оролцоог хангаж ажиллах | • Усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх<br>• Хулгайн ангийн хяналтыг сайжруулах<br>• Байгаль хамгаалагчдын тоог, хариуцлагыг нэмэгдүүлэх<br>• Бөхөн нутаглаж буй газрыг улсын тусгай хамгаалалтад авах<br>• Малын тоо толгойг тодорхой хэмжээгээр цөөлөх<br>• Хууль бус агнуурыг таслан зогсоох<br>• Ан агнуурын хууль дүрмийг иргэдэд танилцуулах<br>• Сайн дурын нөхөрлөлийг нэмэгдүүлж ажиллуулах<br>• Хүмүүсийн хандлагыг өөрчлөх<br>• Бэлчээрийг тусгаарлаж зохицуулах<br>• Бэлчээр сэлгэх<br>• Ховор ан амьтдын амьдарч буй газрыг тусгай хамгаалалтад авах ёстой<br>• |

| | Архангай | Завхан | Баянхонгор | Говь-Алтай |
|---|---|---|---|---|
| Ан амьтныг хамгаалахын ач тус | ✓ Байгалийн тэнцвэрт байдлыг хадгална<br>✓ Биологийн олон янз байдлын тогтвортой байдалд чухал<br>✓ Аялал жуулчлал хөгжинө<br>✓ Хойч үедээ үлдээнэ | ✓ Байгалийн тэнцвэрт байдлыг хадгална<br>✓ | ✓ Тоо толгой нь нэмэгдэх<br>✓ Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгална<br>✓ Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн тустай<br>✓ Дэлхийд ганцхан мазаалайг хамгаалж үлдэнэ гэдэг бахархал<br>✓ Үр хойчдоо байгалийн амьтдыг үлдээх<br>✓ Улсын өв соёл, улс оршин тогтнох гол тулгуур болно | ✓ Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах<br>✓ Монголын баялаг бахархал<br>✓ Бусад ан амьтны оршин тогтнох үндэс болно<br>✓ Аялал жуулчлалд өндөр ач холбогдолтой<br>✓ |

## 5.3. Ховор ургамал

### *Улаангоёод хандах хандлага*

Говь-Алтай, Баянхонгор аймгийн судалгаанд хамрагдсан иргэдээс тухайн орон нутагт нь Улаангоёо ургадаг эсэхийг тодруулахад Баянхонгор аймгийн оролцогчдын 42 хувь нь ургадаг, 5 хувь нь өмнө нь ургадаг байсан ч одоо огт ургахаа больсон, 53 хувь нь ургадаггүй гэж хариулжээ. Говь-Алтай аймгийн оролцогчдын 29 хувь нь ургадаг, 2 хувь нь өмнө нь ургадаг байсан ч одоо огт ургахаа больсон, 69 хувь нь ургадаггүй гэж хариулсан байна.

*График 36: Улаангоёо ургадаг эсэх*




*Хүснэгт 23: Улаангоёо ургадаг эсэх*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Тийм | 42% | 29% | 35% |
| Өмнө нь ургадаг байсан. Одоо огт ургахаа больсон | 5% | 2% | 3% |
| Үгүй | 53% | 69% | 62% |

Улаангоёо ургадаг болон өмнө нь ургадаг байсан ч одоо огт ургахаа больсон гэж хариулсан оролцогчдоос дараах хандлагын асуултуудыг тодруулсан юм. Судалгаанд оролцогчид *Улаангоёо устах нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна* гэдэгтэй 83 хувь санал нийлж байна. *Улаангоёо устахаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна, энэ бол дараагийн асуудал* гэдэгтэй 71 хувь нь санал нийлжээ.Улаангоёо ургамал нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой гэдэгтэй хоёр хүн тутмын нэг нь санал нийлж байна.

*Улаангоёо устах нь бэлчээрийн нөлөөгөөр хамраг багассанаас болж байна* гэдэгтэй 82 хувь нь санал нийлсэн байна. *Улаангоёог түүж хэрэглэснээс тархац нөөц нь багасаж байна* гэдэгтэй 74 хувь нь санал нийлсэн байна.

*Улаангоёог хамгаалах бүрэн боломжтой, Улаангоёо ургамлыг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй* гэж нийт судалгаанд оролцогчдын 89 хувь үзсэн байна. *Улаангоёо ургамал нь байгалийн жамаараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж*

*чадна* гэж 82 хувь нь үзжээ. *Улаангоёог хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой* гэдэгтэй 58 хувь нь, *Улаангоёог зөв түүж бэлтгэвэл нөөц нь нэмэгдэх боломжтой* гэдэгтэй 46 хувь нь санал нийлж байна.

*Хүснэгт 24: Улаангоёоны талаарх хандлага*

| ХАНДЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | Орлого | | Хүйс | | Нас | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 600,000 төгрөгөөс бага | 600,001 төгрөгөөс их | Эрэгтэй | Эмэгтэй | 40-өөс доош настай | 40-өөс дээш настай | |
| **Тулгамдсан асуудал мөн эсэх** | | | | | | | |
| Улаангоёо ургамлын устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 81 % | 86% | 78% | 88% | 81% | 85% | **83%** |
| Улаангоёо ургамлын устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 77 % | 65% | 74% | 68% | 67% | 75% | **71%** |
| Улаангоёо ургамал нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 59 % | 47% | 52% | 55% | 44% | 62% | **53%** |
| **Шалтгаан** | | | | | | | |
| Улаангоёо ургамлын устал нь бэлчээрийн нөлөөгөөр хамраг багассантай холбоотой | 83 % | 81% | 86% | 79% | 75% | 89% | **82%** |
| Улаангоёог түүж хэрэглэснээс тархац нөөц нь багасаж байна | 73 % | 74% | 75% | 73% | 73% | 75% | **74%** |
| **Шийдвэрлэх арга зам** | | | | | | | |
| Улаангоёо ургамлыг хамгаалах бүрэн боломжтой | 92 % | 86% | 92% | 86% | 84% | 94% | **89%** |
| Улаангоёо ургамлыг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 85 % | 93% | 88% | 91% | 89% | 89% | **89%** |
| Улаангоёо ургамал нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. | 83 % | 81% | 78% | 87% | 82% | 83% | **82%** |
| Улаангоёо ургамлыг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 64 % | 52% | 61% | 54% | 57% | 59% | **58%** |
| Улаангоёог зөв түүж бэлтгэвэл нөөц нь нэмэгдэх боломжтой | 44 % | 48% | 48% | 44% | 41% | 52% | **46%** |

*Маш их санал нийлж байна, Санал нийлж байна гэж хариулсан хувийн нийлбэр*

## *Улаангоёоны ач тусын талаарх ойлголт*

Улаангоёоны ач тусын талаар иргэдээс тодруулахад 36 хувь нь хэлж мэдэхгүй, 21 хувь нь эмчилгээний ач тустай, 5 хувь нь говийн экосистемийн тэнцвэрийг хадгалдаг гэж хариулсан байна. Аймгаар нь харвал Говь-Алтай аймгийн иргэд улаангоёоны ач тусын талаар мэдэхгүй гэж хариулсан хувь өндөр байна.

*Хүснэгт 25: Улаангоёоны ач тус*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 20% | 48% | 36% |
| Эмчилгээний ач тустай | 28% | 16% | 21% |
| Говийн экосистемийн тэнцвэрийг хадгалах | 7% | 4% | 5% |
| Бусад ургамлын амьдрах таатай орчныг бүрдүүлдэг | 5% | 2% | 3% |
| Ач тусгүй | 1% | 0% | 1% |
| Малд тустай | 0.6% | - | 0.2% |
| Иддэг | 0.3% | - | 0.1% |

## *Улаангоёоны ховордох болсон шалтгаан*

Улаангоёо ховордож буй шалтгааныг тодруулахад 69 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна. Гол ховордож буй шалтгааныг харвал 7 хувь нь хүмүүс арилжааны зорилгоор түүдэг, 6 хувь нь ган зудын гамшиг, 6 хувь нь хүмүүс эмчилгээний зорилгоор түүдэг гэж хариулсан байна.

*Хүснэгт 26: Улаангоёо ховордох болсон шалтгаан*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 56% | 79% | 69% |
| Хүмүүс арилжааны зорилгоор түүдэг | 14% | 2% | 7% |
| Ган / Зудын гамшиг | 5% | 6% | 6% |
| Хүмүүс эмчилгээний зорилгоор түүдэг | 9% | 3% | 6% |
| Цөлжилт | 7% | 4% | 5% |
| Усны хомсдол | 5% | 4% | 4% |
| Малын тоо толгойн өсөлт | 1% | 1% | 1% |
| Хүмүүсийн мэдлэг дутмаг | 1% | 1% | 1% |
| Жижиг мэрэгч амьтад | 0.3% | 0.6% | 0.5% |
| Уул уурхайн сөрөг нөлөө | 1.1% | 0.0% | 0.5% |
| Хотжилтын сөрөг нөлөө | 0.0% | 0.4% | 0.2% |
| Ахуйн хог хаягдал | 0.3% | 0.0% | 0.1% |

## *Улаангоёог хамгаалах арга зам*

Улаангоёог хэрхэн хамгаалж болох талаар тодруулахад 71 хувь нь мэдэхгүй, 14 хувь нь тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, 10 хувь нь нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах, 9 хувь нь зориудаар тарьж ургуулах гэж дурдсан байна.

*Хүснэгт 27: Улаангоёог хамгаалах арга зам*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 59% | 81% | 71% |
| Тархац нутгийг тусгай хамгаалалтад авах | 18% | 10% | 14% |
| Нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах | 14% | 6% | 10% |
| Зориудаар тарьж ургуулах | 15% | 5% | 9% |
| Хууль бус арилжааг таслан зогсоох | 11% | 4% | 7% |
| Тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах | 5% | 5% | 5% |
| Хамгаалах шаардлагагүй | 1% | 1% | 1% |

***Шигтгээ:*** Улаангоёо, хармагийг хамгаалж байгаа. Хармаг нь өнжиж ургадаг ургамал учраас бид хамгаалах гэж хичээж байна. Сургалт мэдээллүүдээ сайн өгч байна. Иргэдэд мэдээлэл илүү сайн өгөх хэрэгтэй.

*Баянхонгор аймаг, Баацагаан сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Улаангоёо их ургадаг, хүнсэнд хэрэглэдэггүй , мал л иддэг. Гоёог хамгаалахын тулд голыг чөлөөлөх хэрэгтэй. Яагаад гэвэл тэр гол дагаад чийгтэй, элсэрхэг газар ургадаг ургамал. Манай сум 6/1-9/1 хүртэл голоо чөлөөлдөг.

*Баянхонгор аймаг, Баянцагаан сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

## *Хармаг жимс ургадаг эсэх*

Говь-Алтай, Баянхонгор аймгийн оролцогчдоос сум орон нутагт нь хамраг жимс ургадаг эсэхийг тодруулахад 58 хувь нь ургадаг, 3 хувь нь өмнө нь ургадаг байсан ч одоо огт ургахгүй

байгаа, 39 хувь нь огт ургадаггүй гэж хариулсан байна. Говь-Алтай аймгийн иргэдийн 59 хувь нь ургадаг, Баянхонгор аймгийн иргэдийн 56 хувь нь ургадаг гэж тус тус хариулсан байна.

*График 37: Хармаг жимс ургадаг эсэх*




*Хүснэгт 28: Хармаг жимс ургадаг эсэх*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Тийм | 56% | 59% | 58% |
| Өмнө ургадаг байсан. Одоо огт ургахгүй байгаа | 4% | 2% | 3% |
| Огт ургадаггүй | 40% | 39% | 39% |

## *Хармаг жимсний ач тусын талаарх ойлголт*

Хамраг жимсний ач тусын талаарх ойлголтыг тодруулахад нийт оролцогчдын 25 хувь нь мэдэхгүй, 18 хувь нь чанамал, ундаа, амтат дарс хийх, 17 хувь нь эмчилгээний ач тустай, 10 хувь нь С витаминаар баялаг гэж хариулсан байна.

*Хүснэгт 29: Хамраг жимсний ач тус*

| | Баянхонгор | Говь-Алтай | Нийт |
|---|---|---|---|
| Хэлж мэдэхгүй | 23% | 27% | 25% |
| Чанамал, ундаа, амтат дарс хийх | 21% | 16% | 18% |
| Эмчилгээний ач тустай | 13% | 19% | 17% |
| С витаминаар баялаг | 11% | 9% | 10% |
| Органик хүчлээр баялаг | 5% | 8% | 7% |
| Малын тэжээл болдог | 2.0% | 0.0% | 0.8% |
| *Ач тусгүй* | *0.6%* | *0.0%* | *0.2%* |
| Усны нөөц болдог | 0.0% | 0.4% | 0.2% |
| Байгальд цөлжилтөөс, элсний нүүдлээс хамгаалдаг, зэрлэг амьтдын ундаа болдог | 0.3% | 0.0% | 0.1% |
| Байгальдаа ач тустай | 0.3% | 0.0% | 0.1% |

***Шигтгээ:*** Заган ойг хамгаалахад түүнийг орлуулах түлш бэлдэх хэрэгтэй улаан гоёо дээр хамгаалах ханалтын сайжруулах.

*Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Заг бол тариад ургадаг ургамал, маш хурдан ургадаг. Үүнийг тариалах усжуулах арга хэмжээ, мөн хамгаалалтын зурвас татаж хулгайн заг мод бэлтгэхээс хамгаалах, мэдрэгчтэй камер суулгах гэх мэт хяналт тавьж үүнийхээ дагуу арга хэмжээ авах хэрэгтэй. Дархан газрын ганц байгаль хамгаалагчтай, сумын нэг байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч энэ гурван хүн талбайг хамгаална гэвэл хүн хүч хүрэлцээ байхгүй. Бас бензин шатахууны улсаас өгч байгаа хангамж юу билээ гэхээр үнэхээр боломж бололцоогүй.

*Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Хармаг нь хоёр янз, хоёулаа маш ховор, улаан гоёо бас ховор. Ган болоод байдаг учраас бут байгаач цэцэглэж чадахгүй байна. Зуухаар хангах юм бол сайн байгаа. Улаан гоёо ганц хоёр газар ургадаг яаж хамгаалах талаар сайн мэдэхгүй байна. Ургадаг газар жижиг учраас хашаа татаж хамгаалж болох юм.

*Баянхонгор аймаг, Шинэжинст сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Заган ой, хармаг, улаан гоёог хамгаалахын тулд байгаль хамгаалагчдыг олшруулаад түлшинд хэрэглэдэггүй болгох.

*Говь-Алтай аймаг, Цогт сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Мэдэхгүй одоо торлоод хамгаалагч хэцүү, яаж хамгаалмаар юм бэ? Дээ. Ургамал нь асар удам нутгийн бэлчээрийг эзэлсэн байгаа. Хармагийг хятадууд цай хийж байгаа гэж түүсэн, түүхдээ үндсээр нь түүсэн байсан. Улаан гоёог бас түүж устгасан. Эмийн ургамал гэх үндэслэлээр. Үнийг хамгаалах аргын мэдэхгүй байна.

*Говь-Алтай аймаг, Цогт сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Ерөнхийдөө тариалах, тодорхой ургадаг газрыг нь хашаалж л хамгаалах байх. Манай суманд улаан гоёо ховор ургадаг. Сумынхан эмийн журмаар л ганц нэг хэрэглэдэг.

*Говь-Алтай аймаг, Чандмань сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Улаан шалын хоолойд энэ ургамлууд ургадаг, эднийг хамгаалж, тоог нь нэмэгдүүлэхийн тулд төсөл хэрэгжүүлэх гэж байгаа.

*Говь-Алтай аймаг, Чандмань сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Төсөл хэрэгжүүлэх, хамгаалалтад авах. Хармагийг хамгаалалтад авах боломжтой хэсэг газар талбай байна. Улаангоёо нь тархаж ургадаг тул хамгаалалтад оруулах нь бага зэрэг хүндрэлтэй, тарьж ургуулах боломжийг судлах хэрэгтэй

*Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

***Шигтгээ:*** Заган ойг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Улаангоёо -оор Гоёоны архи хийдэг үүнээс болж хүмүүс түүж гоёоны архи хийе гэсэн хүсэл эрмэлзэл байдаг. Үүнийг нь хууль эрх зүйн үүднээс хязгаарлахгүй бол арчилж хамгаалаад нэмэргүй.

*Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, гүнзгийрүүлсэн ярилцлага*

## 6. МЭДЭЭЛЛИЙН СУВГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 6.1. Иргэдийн оролцоо

Тайлангийн энэ хэсэгт иргэд олон нийтийн байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал, байгаль орчныг хамгаалах идэвх санаачилга, багийн иргэдийн хуралд оролцох байдал зэргийг тодруулсан.

*Байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал*

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн хувьд 7 хувь нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байна. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдлыг аймгаар харьцуулан харвал Архангай аймаг 11 хувьтай буюу хамгийн өндөр байна. Сумаар харвал Эрдэнэмандал, Баянцагаан, Шинэжинст зэрэг сумууд нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал хамгийн хувьтай байна. Багийн харвал Идэр-Улаан, Дэлгэрэх, Цац зэрэг гурван баг хамгийн өндөр хувьтай байна.

Иргэдийн өөрийн нэгдсэн нөхөрлөл, хоршооныхоо үйл ажиллагааг үнэлсэн байдал 3.71, нөхөрлөл, хоршоонд өөрийн зүгээс оролцох оролцоогоо үнэлсэн байдал нь 4.02 байна. Өөрөөр хэлбэл, өөрийн оролцоогоо илүү өндрөөр үнэлж байна.

Иргэд өөрсдийн БИНХ –д оролцох идэвхийг дунджаар 3.45 гэж үнэлсэн байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд БИНХ –д дунджаар 2 удаа оролцсон байна. Аймгаар харьцуулан харвал Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймгийн иргэд БИНХ –д илүү идэвхтэй оролцдог гэж хариулсан байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Говь-Алтай аймгийн иргэдийн БИНХ –д оролцсон тоо бусад аймгуудтай харьцуулахад хамгийн их буюу 3 байна. Сумын хэмжээнд БИНХ –д хамгийн идэвхтэй оролцдог гэж үнэлсэн нь Эрдэнэмандал, Баян-Өндөр, Шинэжинст сумын иргэд байна. БИНХ –д оролцсон тоогоор Цогт, Баянцагаан, Эрдэнэ зэрэг сум хамгийн өндөр байна. Багийн хэмжээнд БИНХ –д оролцох байдлаа хамгийн өндөр үнэлсэн нь Цэцэгнуур, Далан, Булган зэрэг багийн иргэд байна. БИНХ –д оролцсон тоогоор Далан, Баян-Улаан, Гэгээт зэрэг баг хамгийн өндөр байна.

Сумын төв болон хөдөө орон нутгийн иргэдийн оролцоонд бага зэргийн ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Сумын төвийн иргэд байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал 7 хувь, хөдөө орон нутгийн иргэд 8 хувь байна. Сумын төвийн иргэд өөрийн нэгдсэн нөхөрлөл хоршоогоо үнэлсэн байдал нь хөдөө орон нутгийн иргэдтэй харьцуулахад бага боловч өөрийн идэвх, оролцоог үнэлсэн байдал нь өндөр байна. Багийн иргэдийн нийтийн хуралд оролцсон тоогоор сумын төвийн иргэд өндөр гарсан байна. Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд БИНХ –д оролцоход хэд хэдэн саад бэрхшээл тулгардаг байна. Үүнд:

- Хүн хүч дутмаг учраас гэрийн ажил, мал зэргээ эзэнгүй орхих боломжгүй байдаг
- Сумын төвөөс хол учир очихоос цааргалдаг
- БИНХ –д оролцоод саналаа хэлсэн ч тэр нь хэрэгждэггүй, хүлээж авдаггүй тул оролцох идэвх багассан

Байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал эрэгтэй хүмүүсийн хувьд илүү өндөр хувьтай, насны хувьд 45-54 насны бүлэг хамгийн өндөр хувьтай байна. Багийн иргэдийн нийтийн хуралд оролцох идэвхийн хувьд мөн адил эрэгтэй, 45-54 насны бүлэг хамгийн өндөр, 18-24 насны бүлэг БИНХ –д оролцох байдал хамгийн бага байна.

*Хүснэгт 30: Иргэдийн оролцоо, байршлаар*

| Аймаг, сум, багийн нэр | Байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал | | | | Нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг үнэлсэн байдал | Нөхөрлөл, хоршооны үйл ажиллагаанд иргэд өөрийн оролцоогоо үнэлсэн байдал | БИНХ –д оролцох идэвх | Өнгөрсөн нэг жилийн хугацаанд БИНХ –д оролцсон тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Дундаж үнэлгээ | Дундаж үнэлгээ | Дундаж үнэлгээ | Дундаж үнэлгээ |
| | Тоо | Тоо | Хувь | Хувь | | | | |
| **Аймгаар** | | | | | | | | |
| Баянхонгор | 32 | 320 | 9% | 91% | 4.00 | 4.34 | 3.65 | 2 |
| Архангай | 24 | 198 | 11% | 89% | 3.17 | 3.58 | 3.53 | 2 |
| Завхан | 18 | 230 | 7% | 93% | 3.81 | 4.00 | 2.95 | 1 |
| Говь-Алтай | 22 | 457 | 5% | 95% | 3.82 | 4.05 | 3.51 | 3 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |
| **Сумаар** | | | | | | | | |
| Баацагаан | 2 | 43 | 4% | 96% | 4.00 | 3.00 | 3.44 | 2 |
| Баян-Өндөр | 6 | 133 | 4% | 96% | 3.83 | 4.50 | 3.73 | 2 |
| Баянцагаан | 8 | 40 | 17% | 83% | 4.00 | 4.50 | 3.60 | 3 |
| Шинэжинст | 16 | 104 | 13% | 87% | 4.06 | 4.38 | 3.67 | 3 |
| Батцэнгэл | 8 | 71 | 10% | 90% | 3.75 | 4.25 | 3.42 | 2 |
| Өлзийт | 1 | 48 | 2% | 98% | 4.00 | 5.00 | 3.46 | 1 |
| Хайрхан | 5 | 42 | 11% | 89% | 3.40 | 3.80 | 3.57 | 2 |
| Эрдэнэмандал | 10 | 37 | 21% | 79% | 2.50 | 2.80 | 3.74 | 2 |
| Их-Уул | 4 | 73 | 5% | 95% | 4.25 | 4.00 | 3.32 | 2 |
| Тосонцэнгэл | 14 | 157 | 8% | 92% | 3.67 | 4.00 | 2.78 | 1 |
| Цогт | 10 | 217 | 4% | 96% | 3.40 | 4.10 | 3.46 | 3 |
| Чандмань | 6 | 106 | 5% | 95% | 4.33 | 4.00 | 3.45 | 2 |
| Эрдэнэ | 6 | 134 | 4% | 96% | 4.00 | 4.00 | 3.65 | 3 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |
| **Багаар** | | | | | | | | |
| Товгор | 2 | 43 | 4% | 96% | 4.00 | 3.00 | 3.44 | 2 |
| Улаан үзүүр | 1 | 56 | 2% | 98% | 2.00 | 4.00 | 3.77 | 2 |
| Элгэн | 1 | 44 | 2% | 98% | 5.00 | 5.00 | 3.58 | 2 |
| Булган | 4 | 33 | 11% | 89% | 4.00 | 4.50 | 3.84 | 3 |
| Дэлгэрэх | 8 | 40 | 17% | 83% | 4.00 | 4.50 | 3.60 | 3 |
| Уртын гол | 9 | 50 | 15% | 85% | 4.22 | 4.56 | 3.76 | 2 |
| Эрдэнэшанд | 5 | 39 | 11% | 89% | 4.00 | 4.20 | 3.50 | 3 |
| Эхэн хавцгай | 2 | 15 | 12% | 88% | 3.50 | 4.00 | 3.76 | 3 |
| Улаанчулуу | 1 | 30 | 3% | 97% | 5.00 | 5.00 | 3.58 | 2 |
| Цац | 7 | 41 | 15% | 85% | 3.57 | 4.14 | 3.31 | 2 |
| Байшир | 1 | 48 | 2% | 98% | 4.00 | 5.00 | 3.46 | 1 |
| Жарантай | 5 | 42 | 11% | 89% | 3.40 | 3.80 | 3.57 | 2 |
| Идэр-Улаан | 10 | 37 | 21% | 79% | 2.50 | 2.80 | 3.74 | 2 |
| Зарт | 4 | 73 | 5% | 95% | 4.25 | 4.00 | 3.32 | 2 |
| Хайрхан | 7 | 90 | 7% | 93% | 3.83 | 4.20 | 2.61 | 1 |
| Рашаант, Тосонцэнгэл | 7 | 67 | 9% | 91% | 3.50 | 3.83 | 3.00 | 1 |
| Рашаант, Цогт | 0 | 17 | 0% | 100% | - | - | 3.06 | 2 |
| Далан | 1 | 19 | 5% | 95% | 4.00 | 5.00 | 3.85 | 5 |
| Гэгээт | 2 | 17 | 11% | 89% | 3.50 | 4.00 | 3.39 | 3 |
| Төгрөг | 2 | 46 | 4% | 96% | 2.00 | 3.50 | 3.56 | 3 |
| Баян-Өндөр | 2 | 39 | 5% | 95% | 3.50 | 4.00 | 3.51 | 2 |
| Баян-Улаан | 1 | 19 | 5% | 95% | 4.00 | 5.00 | 2.95 | 3 |
| Баян тоорой | 2 | 60 | 3% | 97% | 4.00 | 4.00 | 3.50 | 3 |
| Чандмань-Уул | 0 | 31 | 0% | 100% | - | - | 3.50 | 2 |
| Өлзийбулаг | 5 | 35 | 13% | 88% | 4.40 | 4.00 | 3.55 | 3 |
| Эрдэнэ-Уул | 1 | 40 | 2% | 98% | 4.00 | 4.00 | 3.30 | 2 |
| Сангийн далай | 2 | 29 | 6% | 94% | 3.50 | 4.00 | 3.35 | 2 |
| Цэцэг нуур | 1 | 35 | 3% | 97% | 5.00 | 4.00 | 3.89 | 3 |
| Цагаан-Уул | 1 | 34 | 3% | 97% | 4.00 | 3.00 | 3.57 | 3 |
| Өлзийт | 2 | 36 | 5% | 95% | 4.00 | 4.50 | 3.74 | 2 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Байршлаар** | | | | | | | | |
| Сумын төв | 28 | 402 | 7% | 93% | 3.70 | 4.23 | 3.28 | 2 |
| Хөдөө | 68 | 803 | 8% | 92% | 3.72 | 3.94 | 3.53 | 2 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |
| **Хүйсээр** | | | | | | | | |
| Эрэгтэй | 59 | 576 | 9% | 91% | 3.67 | 4.10 | 3.57 | 2 |
| Эмэгтэй | 37 | 629 | 6% | 94% | 3.78 | 3.89 | 3.33 | 2 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |
| **Насны бүлгээр** | | | | | | | | |
| 18-24 нас | 10 | 217 | 4% | 96% | 4.00 | 4.10 | 2.69 | 1 |
| 25-34 нас | 23 | 308 | 7% | 93% | 3.91 | 3.83 | 3.49 | 2 |
| 35-44 нас | 19 | 292 | 6% | 94% | 3.58 | 3.74 | 3.58 | 2 |
| 45-54 нас | 34 | 219 | 13% | 87% | 3.52 | 4.28 | 3.80 | 3 |
| 55-аас дээш | 10 | 169 | 6% | 94% | 3.89 | 4.11 | 3.57 | 2 |
| **Нийт** | **96** | **1205** | **7%** | **93%** | **3.71** | **4.02** | **3.45** | **2** |

Байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдлыг төрлөөр нь дараах хүснэгтэд харьцуулан харуулав. Үүнд, Баянхонгор, Говь-Алтай аймгийн иргэд малчдын бүлэгт, Архангай, Завхан аймгийн иргэд ойн нөхөрлөлд түлхүү хамрагдсан байна. Нийтээр нь харвал ойн нөхөрлөлд хамрагдах байдал хамгийн өндөр буюу дунджаар 43 хувьтай байна.

*Хүснэгт 31: Иргэдийн нэгдсэн нөхөрлөл, хоршооны төрөл, аймгаар*

| Аймаг | Малчдын бүлэг | | Бэлчээр ашиглагчдын холбоо | | Ойн нөхөрлөл | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Баянхонгор | 13 | 41% | 9 | 28% | 7 | 22% | 8 | 25% |
| Архангай | 2 | 8% | 0 | 0% | 18 | 75% | 4 | 17% |
| Завхан | 0 | 0% | 3 | 17% | 15 | 83% | 0 | 0% |
| Говь-Алтай | 13 | 59% | 4 | 18% | 1 | 5% | 5 | 23% |
| Нийт | 28 | 29% | 16 | 17% | 41 | 43% | 17 | 18% |

Байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалахад иргэдийн оролцоо хамгийн чухал. Малчин иргэд байгаль орчиндоо хамгийн ойр амьдарч байгаа, тус орон нутгийн эзэн нь гэж хэлж болох юм. Нэгдсэн бодлогоор төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд иргэдийг татан оролцуулах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх, оролцоог хангах нь тухайн төсөл хөтөлбөр үр дүнтэй, бодитой хэрэгжих гол үндэс болох юм. Хөдөө орон нутгийн хувьд байгаль орчныг хамгаалахтай холбоотой нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдал ENSURE төслийн зорилтот бүс нутагт амьдарч буй иргэдийн арав хүрэхгүй хувийг эзэлж байна. Байгаль орчныг хамгаалан ажиллахын тулд нөхөрлөл, хоршоогоор дамжуулан, иргэдийг нэгдсэн байдлаар идэвхжүүлж ажиллуулбал үр дүнтэй. Учир нь дээд албан тушаалтны хүмүүст байгаль орчин, биологийн олон янз байдлаас гадна анхаарал хандуулах олон асуудал байдаг байна. Иймд иргэдийн оролцоогоор дамжуулан, нөхөрлөл хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажиллавал сайн үр дүнд хүрэх юм. Гэтэл бодит байдал дээр үүнийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн бэрхшээлтэй тулгарч байна.

*Хүснэгт 32: Иргэдийн оролцооны давуу тал, тулгарч буй асуудал бэрхшээл, анхаарах зүйлс*

| ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ | | |
|---|---|---|
| **Давуу тал** | **Асуудал бэрхшээл** | **Анхаарах зүйлс** |
| • Байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалахад хамгийн чухал үүрэгтэй<br>• Нутгийн иргэд гадны хүнээс илүү өөриймсөг хандана<br>• Байгаль орчиндоо хамгийн ойр<br>• Мэдлэгийг олгоод, чиглүүлээд өгвөл байгаль орчноо хамгаалах хүсэлтэй<br>• Байгаль орчны нөхцөл байдал муудах нь иргэдэд хамгийн хүнд тусах учраас иргэд санаа зовниж байгаа<br>• Малчид мал маллах, бэлчээр сонгох тал дээр хамгийн их туршлагатай<br>• Сайн туршлагатай, үлгэр жишээ ажиллаж буй нөхөрлөлүүд цөөнгүй бий | • Иргэдийн оролцоо хангалттай хэмжээнд биш байна.<br>• Иргэд ганц нэгээрээ ажиллах нь үр дүн багатай тул нөхөрлөл, хоршоонд нэгдэх хэрэгтэй<br>• Иргэд яг юу хийхээ мэддэггүй<br>• Нөхөрлөл хоршоонд санхүүжилт байдаггүй<br>• Менежмент, багийн зохион байгуулалт муу<br>• Ашиг харж ажиллаж байна. Өөрт нь санхүүгийн хувьд ашиггүй бол оролцох идэвхгүй байдаг<br>• Сум орон нутаг, аймаг, нийслэлээс уялдаа холбоотойгоор дэмжиж ажиллах байдал сул<br>• Нөхөрлөл хоршоон үйл ажиллагаанд оролцох гэхэд ар гэрийн ажил орхигдох, зав муутай байх, эсвэл бүр оролцох хүсэлгүй иргэд цөөнгүй<br>• Иргэд бэлчээрээ үнэгүй ашиглаж, модоо үнэгүй түлж, өвсөө үнэгүй хадаж байна. Гэтэл хамгаалах тал дээр анхаарал хандуулах байдал сул байна.<br>• Өөрийн мэдлийн юмандаа өөриймсөг хандаж, олны гэсэн юманд хүнийрхүү хандах хандлага байна.<br>• Ашиг хонжоо олох зорилгоор ан амьтан, ховор ургамлыг сүйдэлж байна.<br>• Иргэд өөрсдөд нь ашигтай учраас л ойн нөхөрлөлд түлхүү орж байна<br>• Бэлчээр өнжөөх хэрэгтэй гэдгийг малчид ойлгодоггүй, дэмждэггүй. Дийлэнх нь бэлчээрийг хамгаалах нь ямар ач тустай талаар ойлголтгүй учраас эсэргүүцдэг.<br>• Бүлэг, нөхөрлөл, хоршоо зэрэг нь тухайн төслийн хугацаанд үйл ажиллагаа явуулаад, төслийн хугацаа дуусахад үйл ажиллагаа нь зогсчихдог.<br>• Хэдийгээр төсөл хөтөлбөрүүд нөхөрлөл хоршоо дээр тулгуурлаж үйл ажиллагаа явуулдаг боловч нөхөрлөл хоршоо бүрд идэвхтэй 2-3 хүн л идэвхтэй ажилладаг. Тэгэхээр бусад гишүүдийг яаж идэвхжүүлэх вэ? гэдэг дээр | • Нөхөрлөл, хоршоог гол удирдах, чиглүүлэх хүмүүст зориулсан сургалтыг хийх, тэдгээр хүмүүсийн мэдлэгийг сайжруулах<br>• Иргэдийг татан оролцуулахын тулд зөвхөн мэдлэг олгохоос гадна тэдгээр хүмүүсийг **өдөөх хүчин зүйл** (motivation) байх хэрэгтэй<br>• ХӨШҮҮРЭГ ХЭРЭГТЭЙ-ТЭР НЬ ЮУ ВЭ?<br>• Хоршоо бий болгох, туршлага судлах аян, уулзалтууд хийх хэрэгтэй<br>• Өв уламжлалаа сэргээж, хашир туршлагатай малчдын мэдлэг, сургаалыг залуу малчдад хүргэх<br>• Хууль эрх зүйн орчныг сайн хөгжүүлэх, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг байх<br>• Бэлчээр ашигласны малын хөлийн татвар тогтоох<br>• Сум орон нутгийн иргэд малчид хамтран ажиллах<br>• Иргэдийн мэдлэг маш муу байгаа учраас суурь боловсрол дээр сайн анхаарч, мэдлэгийг багаас нь олгодог байх хэрэгтэй<br>• Орон нутгийн иргэдийг байгаль хамгаалагч чиглэлээр ажиллуулах нь үр дүнтэй байдаг<br>• Малын тоонд биш, чанарт анхаарах нь чухал |

| | | |
|---|---|---|
| | анхаарч, арга хэмжээ авах хэрэгтэй<br>• Маш цөөхөн юм хийх юмсан гэсэн хүмүүсээ дэмжиж ажиллахгүй байна<br>• Ойн нөхөрлөлүүдэд юу хийх нь их тодорхой байдаг. Гэтэл бэлчээр болон усыг хамгаалах нөхөрлөлүүдэд юуг яаж хамгаалах нь тодорхой бус байна | |

*Эх үүсвэр: Гол оролцогч талуудын гүнзгийрүүлсэн ярилцлага*

### 6.2. Сургалтад хамрагдсан байдал

Судалгаанд хамрагдсан иргэдийн 24 хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургалтад хамрагдсан байна. Аймгаар нь харьцуулан харвал Баянхонгор, Говь-Алтай аймгийн иргэдийн сургалтад хамрагдсан байдал хамгийн өндөр хувьтай байна. Байршлаар нь харвал сумын төвийн иргэдийн сургалтад хамрагдсан хувь 36, хөдөө орон нутгийн иргэд 18 хувьтай байна. **Сумын төвийн иргэдийн сургалтад хамрагдсан хувь хөдөө орон нутгийн иргэдээс хоёр дахин их байна.**

Сургалтын төрлөөр нь харвал *байгаль орчиндоо ээлтэй хандах, хайрлаж хамгаалах тухай; бэлчээрийг зүй зохистой ашиглах; нийгмийн халамж үйлчилгээ* зэрэг сургалтад илүү их хамрагдсан байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд дунджаар 2-3 удаа сургалтад хамрагдсан байна.

*Хүснэгт 33: Иргэдийн сургалтад хамрагдсан байдал, сургалтын төрлөөр*

| | Байршил | | Аймаг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | Нийт |
| Байгаль орчиндоо ээлтэй хандах, хайрлаж хамгаалах тухай | 9% | 3% | 5% | 1% | 3% | 8% | **5%** |
| Бэлчээрийг зүй зохистой ашиглах | 7% | 3% | 6% | 5% | 0% | 5% | **4%** |
| Нийгмийн халамж үйлчилгээ | 7% | 2% | 7% | 1% | 1% | 3% | **3%** |
| Өрхийн амьжиргааг сайжруулах | 5% | 2% | 4% | 0% | 2% | 4% | **3%** |
| Малын эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах холбоотой | 3% | 3% | 4% | 3% | 1% | 3% | **3%** |
| Байгаль цаг уурын болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх | 5% | 1% | 6% | 0% | 1% | 3% | **3%** |
| Мэргэжил олгох сургалт | 4% | 2% | 2% | 1% | 3% | 4% | **3%** |
| Ойг арчлах, хамгаалах тухай | 4% | 2% | 3% | 2% | 3% | 2% | **2%** |
| Малчдын эрүүл мэндтэй холбоотой мэдлэг олгох сургалт | 3% | 2% | 3% | 2% | 1% | 3% | **2%** |
| Ойн зохистой хэрэглээний тухай | 4% | 1% | 3% | 2% | 2% | 1% | **2%** |
| Малын чанар үйлдвэр угсааг сайжруулах | 2% | 2% | 2% | 1% | 1% | 3% | **2%** |
| Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах тухай | 4% | 1% | 3% | 2% | 0% | 2% | **2%** |
| Бэлчээрийн даацад таарсан эрсдэл багатай мал аж ахуй эрхлэх | 3% | 1% | 2% | 1% | 0% | 3% | **2%** |
| Банк болон санхүүгийн мэдлэг олгох тухай | 3% | 1% | 2% | 0% | 2% | 2% | **2%** |
| Малын даатгалтай холбоотой | 2% | 1% | 2% | 1% | 0% | 1% | **1%** |
| Малын тэжээл бэлтгэх, мал тэжээх | 2% | 1% | 1% | 2% | 0% | 1% | **1%** |
| Малын тэжээл тарих | 2% | 1% | 1% | 0% | 2% | 1% | **1%** |
| Ойн дагалдах баялгийг ашиглах | 1% | 0% | 1% | 0% | 1% | 0% | **0%** |
| Сургалтад огт хамрагдаагүй | 64% | 82% | 74% | 81% | 82% | 73% | **76%** |
| Сургалтад хамрагдсан хувь | 36% | 18% | 26% | 19% | 18% | 27% | **24%** |
| Сургалтад хамрагдсан тоо, өнгөрсөн нэг жилд | 3 | 2 | 3 | 2 | 2 | 3 | **3** |

Иргэдийн сургалтад хамрагдсан хувийг нас, хүйсээр нь харвал эмэгтэйчүүдийн сургалтад хамрагдсан байдал эрэгтэйчүүдээс 2 дахин их, насны хувьд 45-54 насны бүлэг хамгийн их сургалтад хамрагдсан байна. Цаашдын сургалтад хамрагдах хэрэгцээг харахад эмэгтэйчүүд илүү сургалтад суух сонирхолтой байна. Насны бүлгийн хувьд 55-аас дээш насны бүлэг сургалтад суух сонирхол хамгийн бага, бусад насны бүлгийн хувьд сургалтад суух сонирхол 78-82 хувьтай байна.

*Хүснэгт 34: Сургалтад хамрагдсан байдал, нас хүйсээр*

| | Хүйс | | Насны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрэгтэй | Эмэгтэй | 18-24 нас | 25-34 нас | 35-44 нас | 45-54 нас | 55-аас дээш |
| Сургалтад хамрагдсан хувь | 17% | 30% | 22% | 25% | 21% | 28% | 21% |
| Цаашид сургалтад хамрагдах хэрэгцээ | 77% | 80% | 82% | 82% | 78% | 82% | 64% |

Нийт судалгаанд оролцогчдын 21 хувь нь сургалтад хамрагдах сонирхолгүй, 79 хувь нь сургалтад хамрагдах сонирхолтой байна. Цаашид сургалтад хамрагдах хэрэгцээг тодруулахад *бэлчээрийг зүй зохистой ашиглах; байгаль орчиндоо ээлтэй хандах, хайрлаж хамгаалах тухай; малын чанар үйлдвэр угсааг сайжруулах* зэрэг сургалтад хамрагдах хэрэгцээ их байна. **Эдгээрээс гадна сүү цагаан идээ боловсруулах, ан амьтны ач тусын талаар, малчдын амьдрал ахуйд хэрэгцээтэй хуулийн талаарх сургалтад суух сонирхолтой байна.**

*Хүснэгт 35: Цаашид сургалтад хамрагдах хэрэгцээ, сургалтын төрлөөр*

| | Байршил | | Аймаг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | Нийт |
| Бэлчээрийг зүй зохистой ашиглах | 29% | 32% | 36% | 19% | 19% | 40% | **31%** |
| Байгаль орчиндоо ээлтэй хандах, хайрлаж хамгаалах тухай | 37% | 27% | 31% | 15% | 31% | 37% | **31%** |
| Малын чанар үйлдвэр угсааг сайжруулах | 17% | 22% | 24% | 18% | 8% | 25% | **20%** |
| Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах тухай | 16% | 20% | 23% | 9% | 5% | 27% | **19%** |
| Малын эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах холбоотой | 14% | 18% | 22% | 9% | 4% | 23% | **16%** |
| Ойг арчлах, хамгаалах тухай | 21% | 14% | 18% | 11% | 19% | 16% | **16%** |
| Байгаль цаг уурын болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх | 16% | 13% | 15% | 7% | 9% | 20% | **14%** |
| Өрхийн амьжиргаа сайжруулах | 21% | 11% | 18% | 5% | 9% | 18% | **14%** |
| Малчдын эрүүл мэндтэй холбоотой мэдлэг олгох сургалт | 14% | 14% | 19% | 5% | 8% | 18% | **14%** |
| Мэргэжил олгох сургалт | 17% | 12% | 18% | 7% | 13% | 15% | **14%** |
| Ойн зохистой хэрэглээний тухай | 16% | 12% | 14% | 12% | 14% | 13% | **13%** |
| Малын тэжээл тарих | 11% | 14% | 19% | 8% | 5% | 14% | **13%** |
| Малын тэжээл бэлтгэх, мал тэжээх | 8% | 13% | 17% | 9% | 2% | 13% | **11%** |
| Малын даатгалтай холбоотой | 9% | 10% | 15% | 6% | 5% | 11% | **10%** |
| Ойн дагалдах баялгийг ашиглах | 11% | 7% | 10% | 5% | 8% | 9% | **8%** |
| Нийгмийн халамж үйлчилгээ | 11% | 6% | 13% | 2% | 2% | 10% | **8%** |
| Банк болон санхүүгийн мэдлэг олгох тухай | 10% | 7% | 10% | 2% | 2% | 12% | **8%** |
| Сургалтад огт хамрагдах сонирхолгүй | 18% | 23% | 27% | 24% | 26% | 13% | **21%** |
| Сургалтад хамрагдах сонирхолтой | 82% | 77% | 73% | 76% | 74% | 87% | **79%** |

### 6.3. Мэдээллийн эх үүсвэр

*Мэдээ, мэдээлэл голчлон авдаг суваг*

**Мэдээллийн сувгийн хувьд телевиз хамгийн өндөр хувьтай буюу 91 хувьтай ашиглаж байна.** Орон нутгийн суваг үздэг хувь 23 хувьтай байна. Бусад мэдээллийн сувгийн хувьд 15 хувиас доош ашиглагдаж байна. Үүнд: интернэт төхөөрөмж, фм радио, хурал цуглаан зэрэг багтаж байна.

*График 38: Мэдээ мэдээлэл голчлон авдаг суваг*



Мэдээ, мэдээллийг голчлон авдаг сувгийг нас, хүйсээр харьцуулан харвал эмэгтэйчүүдийн телевиз үзэх байдал эрэгтэйчүүдээс хоёр хувиар илүү байна. Орон нутгийн суваг үзэх байдал эрэгтэйчүүдэд 3 хувиар илүү байна. Цахим интернэт ашиглах байдал эмэгтэйчүүдэд 6 хувиар илүү байна. Насны бүлгээр ашигладаг мэдээллийн сувгийг харвал нас нэмэгдэх тусам телевиз, радио, сонин, сэтгүүлийн хэрэглээ өсөж байхад интернэт, гар утасны мессежний хэрэглээ нас буурах тусам өсөж байна. Сургалт, хурал зөвлөгөөнд оролцох байдал 25-54 насны бүлэгт хамгийн өндөр байна.

*Хүснэгт 36: Мэдээ, мэдээлэл голчлон авдаг суваг, нас хүйсээр*

| | Хүйс | | Насны бүлэг | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрэгтэй | Эмэгтэй | 18-24 нас | 25-34 нас | 35-44 нас | 45-54 нас | 55+ нас | |
| Телевиз/Үндэсний хэмжээнд цацдаг/ | 90% | 92% | 83% | 93% | 94% | 91% | 93% | 91% |
| Орон нутгийн суваг | 24% | 21% | 23% | 23% | 23% | 23% | 20% | 23% |
| Цахим/Интернэт | 12% | 18% | 30% | 20% | 11% | 8% | 6% | 15% |
| Радио /Үндэсний хэмжээнд цацдаг/ | 11% | 8% | 6% | 7% | 9% | 11% | 15% | 9% |
| Хурал цуглаан | 7% | 7% | 3% | 10% | 7% | 8% | 7% | 7% |
| Хот айлын болон хөршүүдийн яриа/худаг дээр, бэлчээр дээр уулзаж | 4% | 5% | 5% | 3% | 4% | 6% | 4% | 4% |
| Сургалт | 2% | 3% | 1% | 4% | 3% | 3% | 1% | 3% |
| Гар утасны мессеж | 1% | 3% | 4% | 2% | 3% | 2% | 1% | 2% |
| Орон нутгийн фм радио | 3% | 1% | 1% | 1% | 3% | 2% | 2% | 2% |
| Өдөр тутмын сонин | 2% | 2% | 1% | 1% | 2% | 1% | 5% | 2% |
| Орон нутгийн сонин сэтгүүл | 1% | 2% | 1% | 1% | 2% | 2% | 2% | 1% |
| Мэргэжилтнүүдийн яриа | 1% | 2% | 1% | 2% | 1% | 1% | 1% | 1% |
| Хэвлэмэл материал | 1% | 1% | 0% | 0% | 1% | 2% | 1% | 1% |
| Сэтгүүл | 1% | 1% | 2% | 1% | 0% | 1% | 1% | 1% |
| Сурталчилгааны самбар | 1% | 1% | 0% | 1% | 1% | 2% | 0% | 1% |
| ХАА –н салбарын сонин, хэвлэл сэтгүүл | 1% | 1% | 1% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Үзэсгэлэн худалдаа | 0% | 1% | 0% | 0% | 1% | 1% | 1% | 1% |
| Туршлага судлах, солилцох арга хэмжээ | 0% | 0% | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% |

Мэдээллийн сувгийн хэрэглээг байршлаар харвал сумын төвд телевиз болон суурин интернэтийн хэрэглээ өндөр байхад хөдөө орон нутагт телевиз болон фм, радиогийн хэрэглээ илүү өндөр байна. Аймгаар харвал Архангай аймагт телевизийн хэрэглээ хамгийн өндөр (97%), Баянхонгор аймагт интернэт төхөөрөмжийн хэрэглээ хамгийн өндөр (24%), Говь-алтай аймагт фм радиогийн хэрэглээ хамгийн өндөр (23%) байна.

*Хүснэгт 37: Мэдээллийн сувгийн хэрэглээ, байршлаар*

| | Байршлаар | | Аймгаар | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай |
| Телевиз | 93% | 94% | 93% | 97% | 90% | 94% |
| Интернэт /Төхөөрөмж ашиглаж/ | 31% | 7% | 24% | 9% | 15% | 12% |
| Фм, радио | 8% | 13% | 6% | 5% | 4% | 23% |
| Интернэт /Гар утаснаасаа дата ашиглаж/ | 7% | 4% | 6% | 1% | 1% | 7% |
| Ам дамжсан яриа | 9% | 2% | 7% | 0% | 5% | 4% |
| Олон нийтийн газар байрлуулсан зар, сурталчилгаатай танилцах | 5% | 4% | 3% | 1% | 2% | 7% |
| Мэргэжилтнүүдтэй уулзах | 7% | 1% | 5% | 0% | 0% | 4% |
| Сонин | 6% | 1% | 4% | 1% | 3% | 3% |
| Сурталчилгааны самбар | 4% | 1% | 4% | 0% | 0% | 2% |
| Хэвлэмэл материал | 3% | 1% | 1% | 1% | 2% | 2% |

| | Байршлаар | | Аймгаар | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай |
| Туршлага судлах, солилцох арга хэмжээнд оролцох | 4% | 1% | 2% | 1% | 0% | 2% |
| Гар утасны мессеж | 0% | 2% | 0% | 1% | 3% | 1% |
| Хурал уулзалт зөвлөгөөнд оролцох | 2% | 0% | 1% | 0% | 0% | 1% |
| Сургалтад хамрагдах | 1% | 0% | 0% | 0% | 0% | 1% |
| Ямар ч мэдээллийн хэрэгсэл ашигладаггүй | 1% | 1% | 2% | 0% | 0% | 0% |
| Үзэсгэлэн худалдаанд оролцох | 1% | 0% | 0% | 0% | 0% | 1% |

Судалгаанд оролцогчдын голчлон ашигладаг мэдээллийн сувгийг улирлаар харьцуулан дараах хүснэгтэд дүрслэв. Мэдээллийн сувгийн хувьд улирлын ялгаа байхгүй байна.

*Хүснэгт 38: Голчлон ашигладаг мэдээллийн суваг, улирлаар*

| Мэдээллийн суваг | Зун | Намар | Өвөл | Хавар |
|---|---|---|---|---|
| Телевиз | 93% | 93% | 94% | 93% |
| Интернэт /Төхөөрөмж ашиглаж/ | 16% | 16% | 15% | 15% |
| Фм, радио | 12% | 11% | 11% | 12% |
| Интернэт /Гар утаснаасаа дата ашиглаж/ | 5% | 5% | 5% | 5% |
| Ам дамжсан яриа | 4% | 4% | 4% | 5% |
| Олон нийтийн газар байрлуулсан зар, сурталчилгаатай танилцах | 4% | 4% | 4% | 4% |
| Мэргэжилтнүүдтэй уулзах | 3% | 3% | 3% | 3% |
| Сонин | 3% | 3% | 3% | 3% |
| Сурталчилгааны самбар | 2% | 2% | 2% | 2% |
| Хэвлэмэл материал | 2% | 2% | 2% | 2% |
| Туршлага судлах, солилцох арга хэмжээнд оролцох | 1% | 2% | 2% | 2% |
| Гар утасны мессеж | 1% | 1% | 1% | 1% |
| Хурал уулзалт зөвлөгөөнд оролцох | 1% | 1% | 1% | 1% |
| Сургалтад хамрагдах | 1% | 1% | 0% | 1% |
| Ямар ч мэдээллийн хэрэгсэл ашигладаггүй | 1% | 0% | 0% | 1% |
| Үзэсгэлэн худалдаанд оролцох | 0.4% | 0.5% | 0.2% | 0.5% |

## *Судалгаанд оролцогчдын голчлон үздэг телевизийн суваг*

Нийт судалгаанд оролцогчдын голчлон үздэг сувгийг тодруулахад нэгдүгээрт МҮОНРТ (76%), хоёрдугаарт Малчин ТВ (68%), гуравдугаарт TV9 (16%)-иар эрэмбэлэгдэж байна.

*График 39: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг ТОП 10 суваг, олон нийт*




Судалгаанд оролцогчдын голчлон үздэг 20 сувгийг нас, хүйсээр харьцуулан дараах хүснэгтэд харуулж байна. Эрэгтэйчүүдийн хувьд МҮОНРТ, Малчин TV, TV9, MNB 2, Сүлд суваг, Эх орон зэрэг сувгийг илүү үзэж байна. Эмэгтэйчүүдийн хувьд Боловсрол, 25-р суваг, UBS, Mongoltv HD, Dream box зэрэг сувгийг илүү үзэж байна. Насны бүлгээр ялгааг харвал нас нэмэгдэх тусам МҮОНРТ, Малчин TV, TV9, MNB2, Орон нутгийн суваг зэргийг илүү үзэж байна. Нас буурах тусам Боловсрол ТВ, Movie Box, UBS, Сүлд /Спорт, өв соёл/, AsianBox, Mongoltv HD, Эх орон% OTV, DreamBox зэрэг сувгийг илүү үзэж байна.

*Хүснэгт 39: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг 20 суваг, нас хүйсээр*

| **Телевизийн суваг** | **Хүйс** | | **Насны бүлгээр** | | | | | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Эрэгтэй** | **Эмэгтэй** | **18-24 нас** | **25-34 нас** | **35-44 нас** | **45-54 нас** | **55+ нас** | |
| MNB 1 /МҮОНРТ/ | 77% | 75% | 63% | 77% | 78% | 85% | 74% | 76% |
| Малчин TV | 71% | 66% | 54% | 65% | 74% | 76% | 73% | 68% |
| TV9 | 20% | 13% | 11% | 16% | 19% | 20% | 16% | 16% |
| TV5 | 11% | 11% | 14% | 10% | 9% | 11% | 14% | 11% |
| Боловсрол | 6% | 14% | 17% | 12% | 10% | 6% | 4% | 10% |
| MNB - Монголын Мэдээ / MN2 / | 6% | 5% | 4% | 5% | 6% | 5% | 7% | 5% |
| 25-р суваг | 3% | 4% | 4% | 2% | 4% | 4% | 4% | 3% |
| Movie box /Кино/ | 3% | 3% | 11% | 2% | 2% | 1% | 1% | 3% |
| UBS | 2% | 5% | 5% | 3% | 2% | 4% | 2% | 3% |
| Орон нутгийн суваг | 3% | 2% | 1% | 3% | 2% | 3% | 3% | 2% |
| Сүлд суваг /Спорт, өв соёл/ | 3% | 1% | 3% | 2% | 2% | 2% | 1% | 2% |
| Asianbox | 2% | 2% | 7% | 2% | 2% | 0% | 0% | 2% |
| Монгол ТВ /HD Mongol/ | 1% | 2% | 4% | 1% | 3% | 0% | 1% | 2% |
| Эх орон | 3% | 1% | 3% | 2% | 3% | 0% | 1% | 2% |

| Телевизийн суваг | Хүйс | | Насны бүлгээр | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрэгтэй | Эмэгтэй | 18-24 нас | 25-34 нас | 35-44 нас | 45-54 нас | 55+ нас | |
| O TV | 1% | 1% | 4% | 0% | 0% | 0% | 1% | 1% |
| Нутаг21 | 1% | 1% | 2% | 0% | 1% | 1% | 2% | 1% |
| TV8 | 1% | 1% | 2% | 0% | 1% | 2% | 1% | 1% |
| Eagle TV | 1% | 1% | 1% | 0% | 1% | 1% | 1% | 1% |
| Өлзий ТВ | 1% | 1% | 1% | 1% | 1% | 0% | 2% | 1% |
| Dream box | 0% | 1% | 1% | 2% | 0% | 1% | 0% | 1% |

Судалгаанд оролцогчдын голчлон үздэг сувгийг байршлаар харьцуулан харвал сумын төвд МҮОНРТ, TV9, TV5, Боловсрол ТВ, MNB2, 25-р суваг, UBS, Орон нутгийн суваг, Mongoltv HD, Эх орон, Нутаг 21, Эх орон, TV8, OTV, Eagle TV, Өлзий ТВ, Dream box зэрэг сувгийг илүү үзэж байна. Сумын төвийн иргэдийн хувьд хөдөө орон нутгийн иргэдээс илүү олон төрлийн суваг үзэх хандлагатай байна. Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд Малчин TV –ийг илүү үзэх хандлагатай байна.

Судалгаанд оролцогчдын голчлон үздэг сувгийг аймгаар харьцуулан харвал Баянхонгор аймагт Боловсрол ТВ, MNB2, Dream box, Архангай аймагт Малчин TV, Movie box, Eagle TV, Завхан аймагт МҮОНРТ, TV9, TV5, 25-р суваг, UBS, Орон нутгийн суваг, TV8, OTV, Өлзий ТВ, Говь-Алтай аймагт Сүлд суваг, Монгол ТВ, Эх орон, Нутаг21 –ийг илүү үзэж байна.

*Хүснэгт 40: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг 20 суваг, байршлаар*

| Телевизийн суваг | Байршил | | Аймаг | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| MNB 1 /МҮОНРТ/ | 77% | 75% | 75% | 72% | 84% | 74% | 76% |
| Малчин TV | 56% | 75% | 72% | 75% | 53% | 71% | 68% |
| TV9 | 23% | 13% | 11% | 15% | 21% | 18% | 16% |
| TV5 | 16% | 9% | 9% | 5% | 21% | 11% | 11% |
| Боловсрол | 15% | 8% | 11% | 9% | 10% | 9% | 10% |
| MNB - Монголын Мэдээ / MN2 / | 6% | 5% | 8% | 4% | 5% | 4% | 5% |
| 25-р суваг | 6% | 2% | 2% | 1% | 9% | 3% | 3% |
| Movie box /Кино/ | 3% | 3% | 2% | 4% | 2% | 4% | 3% |
| UBS | 5% | 2% | 2% | 1% | 7% | 3% | 3% |
| Орон нутгийн суваг | 3% | 2% | 2% | 2% | 4% | 2% | 2% |
| Сүлд суваг /Спорт, өв соёл/ | 2% | 2% | 2% | 1% | 1% | 3% | 2% |
| Asianbox | 2% | 2% | 1% | 2% | 2% | 2% | 2% |
| Монгол ТВ /HD Mongol/ | 3% | 1% | 1% | 1% | 2% | 3% | 2% |
| Эх орон | 2% | 1% | 1% | 1% | 0% | 3% | 2% |
| Нутаг21 | 2.1% | 0.6% | 1.1% | - | - | 2.1% | 1.1% |
| TV8 | 1.2% | 1.0% | 1.1% | - | 3.2% | 0.4% | 1.1% |
| O TV | 1.9% | 0.7% | 0.3% | - | 5.2% | - | 1.1% |
| Eagle TV | 1.6% | 0.6% | 0.9% | 1.4% | 1.2% | 0.6% | 0.9% |
| Өлзий ТВ | 1.4% | 0.6% | 0.6% | - | 3.2% | 0.2% | 0.8% |
| Dream box | 1.2% | 0.6% | 1.4% | - | - | 1.0% | 0.8% |

### *Судалгаанд оролцогчдын голчлон үздэг нэвтрүүлэг*

Телевизээр голчлон үздэг нэвтрүүлгийг тодруулбал, өдөр тутмын мэдээ, цаг агаарын мэдээ, малчдын мэдээ, малчдын дуу, мэндчилгээ, олон ангит кино, нэг ангит кино, хошин шог зэрэг нэвтрүүлгүүд давамгайлж байна.

*График 40: Судалгаанд оролцогчдын голчлон үздэг нэвтрүүлэг*



Телевизээр голчлон үздэг нэвтрүүлгийг нас хүйсээр харьцуулан дараах хүснэгтэд дүрсэллээ. Эрэгтэй хүмүүсийн хувьд мэдээ, малчдын дууны мэндчилгээ, малчдад зориулсан сургалтын хөтөлбөр зэрэг малчдад зориулсан хөтөлбөрийг үзэх байдал эмэгтэй хүмүүсээс илүү байна. Насны бүлгээр харьцуулан харвал нас нэмэгдэх тусам мэдээ, малчдад зориулсан нэвтрүүлэг үзэх байдал нэмэгдэж байна. Нас буурах тусам кино, спорт, шинжлэх ухааны нэвтрүүлэг, дуу хөгжмийн нэвтрүүлэг үзэх хандлага нэмэгдэж байна.

*Хүснэгт 41: Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг, нас хүйсээр*

| Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг | Хүйс | | Насны бүлэг | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрэгтэй | Эмэгтэй | 18-24 нас | 25-34 нас | 35-44 нас | 45-54 нас | 55+ нас | |
| Өдөр тутмын мэдээ | 76% | 75% | 49% | 71% | 82% | 89% | 89% | 76% |
| Малчдын мэдээ | 36% | 30% | 20% | 33% | 33% | 42% | 36% | 33% |
| Малчдын дуу, мэндчилгээ | 23% | 20% | 18% | 23% | 22% | 22% | 21% | 21% |
| Олон ангит кино | 14% | 23% | 41% | 19% | 14% | 11% | 7% | 18% |
| Нэг ангит кино | 19% | 18% | 35% | 21% | 14% | 10% | 11% | 18% |
| Хошин шог | 14% | 19% | 30% | 19% | 14% | 9% | 11% | 17% |
| Теле-худалдаа | 18% | 14% | 9% | 16% | 17% | 19% | 21% | 16% |
| Малчдад зориулсан сургалтын хөтөлбөр | 16% | 13% | 8% | 15% | 16% | 19% | 11% | 14% |
| Цэнгээнт нэвтрүүлэг-ТВ шоу | 9% | 14% | 15% | 16% | 11% | 8% | 6% | 12% |
| Ярилцлага /Talk show /Монгол тулгатны 100 эрхэм,Цензургүй яриа г.м/ | 8% | 8% | 6% | 7% | 9% | 11% | 7% | 8% |
| Соёл урлагийн нэвтрүүлэг | 6% | 10% | 6% | 10% | 7% | 8% | 9% | 8% |
| Дуу хөгжмийн нэвтрүүлэг | 6% | 10% | 11% | 7% | 9% | 5% | 8% | 8% |
| Өглөөний нэвтрүүлэг | 7% | 9% | 8% | 8% | 7% | 6% | 9% | 8% |
| Нийгэм, улс төрийн хөтөлбөр | 8% | 7% | 4% | 6% | 5% | 9% | 17% | 7% |
| Бизнес мэдээ | 8% | 7% | 4% | 7% | 8% | 8% | 8% | 7% |
| Спортын нэвтрүүлэг | 9% | 5% | 14% | 7% | 7% | 4% | 3% | 7% |
| Шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг | 5% | 7% | 6% | 7% | 5% | 6% | 5% | 6% |
| Хүүхдийн нэвтрүүлэг/ Хүүхэлдэйн кино | 4% | 7% | 4% | 6% | 5% | 4% | 7% | 5% |
| Хувь хүний хөгжилтэй холбоотой нэвтрүүлэг | 7% | 3% | 5% | 5% | 6% | 5% | 3% | 5% |
| Эрүүл мэндийн нэвтрүүлэг | 2% | 6% | 4% | 5% | 4% | 3% | 3% | 4% |
| Баримтат кино/хөтөлбөр | 2% | 5% | 2% | 7% | 1% | 4% | 3% | 4% |
| Теле зохиомж | 3% | 4% | 2% | 5% | 4% | 2% | 5% | 3% |
| Дээр үеийн мал аж ахуйн тухай нэвтрүүлэг | 2% | 4% | 2% | 3% | 2% | 3% | 5% | 3% |
| Сурталчилгаа/Зар | 2% | 3% | 3% | 2% | 2% | 4% | 3% | 3% |
| Хэлэлцүүлэг /Монгол коммент, Нүүдэл шийдэл г.м / | 3% | 2% | 1% | 2% | 2% | 3% | 4% | 2% |
| Fashion /Хувцас загвар/ | 1% | 1% | 0% | 1% | 0% | 2% | 2% | 1% |

Телевизээр голчлон үздэг нэвтрүүлгийг байршлаар харьцуулан дараах хүснэгтэд дүрслэв. Малчдын мэдээ, малчдын дуу, мэндчилгээ, нэг ангит кино, малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг үзэх байдал хөдөө орон нутагт илүү өндөр хувьтай байна.

Аймгаар харьцуулан харвал Баянхонгор аймгийн иргэд илүү олон төрлийн нэвтрүүлгийг үздэг байна. Тэр дундаа малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг үзэх байдал 28 хувьтай байна.

*Хүснэгт 42: Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг, байршлаар*

| Телевизээр голчлон үздэг нэвтрүүлэг | Байршил | | Аймгийн нэр | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| Өдөр тутмын мэдээ | 81% | 73% | 79% | 64% | 83% | 76% | 76% |
| Малчдын мэдээ | 29% | 35% | 47% | 28% | 11% | 37% | 33% |
| Малчдын дуу, мэндчилгээ | 18% | 23% | 37% | 11% | 6% | 23% | 21% |
| Олон ангит кино | 19% | 18% | 17% | 16% | 18% | 21% | 18% |
| Нэг ангит кино | 17% | 19% | 18% | 13% | 18% | 21% | 18% |
| Хошин шог | 17% | 17% | 22% | 8% | 12% | 19% | 17% |
| Теле-худалдаа | 23% | 13% | 9% | 5% | 15% | 28% | 16% |
| Малчдад зориулсан сургалтын хөтөлбөр | 12% | 15% | 28% | 9% | 6% | 11% | 14% |
| Цэнгээнт нэвтрүүлэг-ТВ шоу | 14% | 11% | 13% | 8% | 10% | 13% | 12% |
| Ярилцлага /Talk show /Монгол тулгатны 100 эрхэм,Цензургүй яриа г.м/ | 10% | 7% | 7% | 0% | 8% | 13% | 8% |
| Соёл урлагийн нэвтрүүлэг | 11% | 7% | 14% | 0% | 6% | 8% | 8% |
| Дуу хөгжмийн нэвтрүүлэг | 10% | 7% | 9% | 2% | 7% | 10% | 8% |
| Өглөөний нэвтрүүлэг | 9% | 7% | 9% | 2% | 2% | 13% | 8% |
| Нийгэм, улс төрийн хөтөлбөр | 10% | 6% | 9% | 2% | 10% | 8% | 7% |
| Бизнес мэдээ | 8% | 7% | 4% | 5% | 4% | 13% | 7% |
| Спортын нэвтрүүлэг | 10% | 6% | 9% | 0% | 7% | 9% | 7% |
| Шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг | 8% | 5% | 7% | 2% | 7% | 6% | 6% |
| Хүүхдийн нэвтрүүлэг/ Хүүхэлдэйн кино | 5% | 6% | 8% | 1% | 3% | 6% | 5% |
| Хувь хүний хөгжилтэй холбоотой нэвтрүүлэг | 4% | 5% | 5% | 3% | 3% | 7% | 5% |
| Эрүүл мэндийн нэвтрүүлэг | 7% | 3% | 5% | 1% | 4% | 4% | 4% |
| Баримтат кино/хөтөлбөр | 5% | 3% | 7% | 1% | 4% | 2% | 4% |
| Теле зохиомж | 3% | 3% | 4% | 2% | 2% | 4% | 3% |
| Дээр үеийн мал аж ахуйн тухай нэвтрүүлэг | 4% | 2% | 4% | 1% | 1% | 4% | 3% |
| Сурталчилгаа/Зар | 3% | 2% | 3% | 0% | 1% | 5% | 3% |
| Хэлэлцүүлэг /Монгол коммент, Нүүдэл шийдэл г.м / | 4% | 2% | 3% | 1% | 1% | 3% | 2% |
| Fashion /Хувцас загвар/ | 1% | 1% | 2% | 0% | 0% | 1% | 1% |

ФМ, радиогоор голчлон сонсдог нэвтрүүлгийг тодруулбал, 72 хувь нь огт сонсдоггүй гэж хариулсан байна. ФМ радио сонсох байдал Говь-Алтай аймагт хамгийн өндөр байна. Говь-Алтай аймгийн иргэд өдөр тутмын мэдээ, малчдын мэдээ, дуу хөгжмийн нэвтрүүлэг зэргийг хамгийн их сонсож байна.

*Хүснэгт 43: ФМ радиогоор сонсдог нэвтрүүлэг, байршлаар*

| | **Байршил** | | **Аймгийн нэр** | | | | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Сумын төв** | **Хөдөө** | **Баянхонгор** | **Архангай** | **Завхан** | **Говь-Алтай** | |
| *Сонсдоггүй* | *80%* | *68%* | *76%* | *68%* | *91%* | *60%* | *72%* |
| Өдөр тутмын мэдээ | 10% | 17% | 14% | 5% | 6% | 25% | 15% |
| Малчдын мэдээ | 4% | 7% | 11% | 3% | 1% | 6% | 6% |
| Малчдын дуу, мэндчилгээ | 3% | 5% | 7% | 1% | 0% | 6% | 4% |
| Дуу хөгжмийн нэвтрүүлэг | 2% | 5% | 2% | 1% | 1% | 8% | 4% |
| Өглөөний нэвтрүүлэг | 3% | 4% | 2% | 3% | 1% | 7% | 4% |
| Малчдад зориулсан сургалтын хөтөлбөр | 1% | 2% | 4% | 0% | 0% | 2% | 2% |
| Нийгэм, улс төрийн хөтөлбөр | 1% | 1% | 1% | 0% | 0% | 2% | 1% |
| Бизнес мэдээ | 1% | 1% | 0% | 0% | 0% | 2% | 1% |
| Ярилцлага | 1% | 1% | 0% | 0% | 0% | 3% | 1% |
| Эрүүл мэндийн нэвтрүүлэг | 0% | 1% | 0% | 0% | 0% | 2% | 1% |
| Соёл урлагийн нэвтрүүлэг | 0% | 1% | 0% | 0% | 1% | 1% | 1% |
| Шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг | 0% | 1% | 1% | 0% | 0% | 1% | 1% |
| Дээр үеийн мал аж ахуйн тухай нэвтрүүлэг | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 1% |
| Спортын нэвтрүүлэг | 0% | 1% | 0% | 0% | 0% | 1% | 1% |
| Хэлэлцүүлэг | 0% | 0% | 0% | 0% | 0% | 1% | 0% |
| Сурталчилгаа/Зар | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Хүүхдийн нэвтрүүлэг | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Хувь хүний хөгжилтэй холбоотой нэвтрүүлэг | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |

Телевиз үздэг цаг болон фм, радио сонсдог цагийг тодруулахад телевиз үздэг оргил цаг 18:00 цагаас шөнийн 00:00 цаг хүртэл хамгийн их үздэг байна. ФМ, радио сонсдог оргил цаг нь өглөөний 6:00-6:59, үдийн 15:00-16:59 цагийн хооронд байна.

*График 41: Телевиз үздэг, фм радио сонсдог цаг*



*Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй суваг*

Нийт судалгаанд оролцогчдын хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй гол гурван суваг нь телевиз (86%), Орон нутгийн суваг (20%), радио (9%) байна.

*График 42: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй суваг*



Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй сувгийг нас, хүйсээр харьцуулан дараах хүснэгтэд дүрслэв. Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг телевизээр авахыг хүсэж буй хувь эмэгтэйчүүдэд 3 хувиар өндөр, Орон нутгийн сувгаар авахыг хүсэж буй хувь эрэгтэйчүүдэд 3 хувиар өндөр байна.

*Хүснэгт 44: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй суваг, нас хүйсээр*

| | **Хүйс** | | **Насны бүлэг** | | | | | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Эрэгтэй** | **Эмэгтэй** | **18-24 нас** | **25-34 нас** | **35-44 нас** | **45-54 нас** | **55+ нас** | |
| Телевиз/Үндэсний хэмжээнд цацдаг/ | 84% | 87% | 82% | 87% | 89% | 84% | 85% | 86% |
| Орон нутгийн суваг | 21% | 18% | 25% | 18% | 20% | 19% | 17% | 20% |
| Радио /Үндэсний хэмжээнд цацдаг/ | 10% | 9% | 8% | 6% | 10% | 11% | 11% | 9% |
| Хурал цуглаан | 8% | 9% | 7% | 9% | 7% | 8% | 13% | 9% |
| Сургалтаар | 6% | 7% | 5% | 6% | 5% | 11% | 5% | 7% |
| Цахим/Интернэт | 5% | 7% | 9% | 8% | 4% | 4% | 3% | 6% |
| Орон нутгийн фм радио | 3% | 2% | 3% | 1% | 4% | 2% | 4% | 3% |
| Гар утасны мессеж | 2% | 2% | 2% | 3% | 2% | 2% | 2% | 2% |
| Мэргэжилтнүүдийн яриа, зөвлөмж | 2% | 2% | 1% | 2% | 2% | 3% | 3% | 2% |
| Өдөр тутмын сонин | 2% | 2% | 1% | 1% | 2% | 2% | 5% | 2% |
| Орон нутгийн сонин сэтгүүл | 2% | 2% | 2% | 2% | 2% | 1% | 2% | 2% |
| Хэвлэмэл материал | 2% | 1% | 2% | 2% | 2% | 1% | 0% | 1% |
| Ам дамжсан яриа | 1% | 1% | 1% | 0% | 1% | 2% | 2% | 1% |
| Туршлага судлах, солилцох арга хэмжээ | 1% | 1% | 0% | 1% | 1% | 2% | 2% | 1% |
| Сурталчилгааны самбар | 1% | 1% | 1% | 1% | 0% | 2% | 0% | 1% |
| Салбарын сонин хэвлэл, сэтгүүл | 1% | 1% | 0% | 1% | 0% | 1% | 2% | 1% |
| Үзэсгэлэн худалдаа | 0% | 0% | 0% | 0% | 1% | 1% | 0% | 0% |

Судалгаанд оролцогчдын ХАА болон байгаль орчинтой холбоотой мэдээлэл авахыг хүсэж буй сувгийг байршлаар харьцуулан харвал хөдөө орон нутгийн иргэд телевиз, орон нутгийн суваг, радио, орон нутгийн радио, хэвлэмэл материалаар авахыг илүүд үзэж байна. Сумын төвийн иргэд хурал цуглаан, сургалт, интернэт, гар утасны мессеж, мэргэжилтнүүдийн яриа, өдөр тутмын сонин , орон нутгийн сонин сэтгүүл, туршлага судлах, солилцох арга хэмжээ, сурталчилгааны самбар, салбарын сонин хэвлэл, сэтгүүл, үзэсгэлэн худалдаа зэргийг илүүд үзэх байдал хөдөө орон нутгийн иргэдээс илүү өндөр байна.

ХАА болон байгаль орчинтой холбоотой мэдээлэл авахыг хүсэж буй сувгийг аймгаар харьцуулбал Баянхонгор аймгийн оролцогчдын хувьд телевиз, интернэт, мэргэжилтнүүдийн яриа, зөвлөмж, хэвлэмэл материал зэргийг илүүд үзэх байдал бусад аймгаас илүү өндөр байна. Завхан аймгийн оролцогчдын хувьд гар утасны мессеж, сургалтыг илүүд үзэх байдал бусад аймгаас илүү өндөр байна. Говь-Алтай аймгийн оролцогчдын хувьд орон нутгийн суваг, радио, хурал цуглаан, сургалт, орон нутгийн фм радиог илүүд үзэх байдал бусад аймагтай харьцуулахад илүү өндөр байна.

*Хүснэгт 45: Судалгаанд оролцогчдын ХАА болон байгаль орчинтой холбоотой мэдээлэл авахыг хүсэж буй суваг, байршлаар*

| | Байршил | | Аймаг | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| Телевиз/Үндэсний хэмжээнд цацдаг/ | 83% | 87% | 91% | 87% | 81% | 84% | 86% |
| Орон нутгийн суваг | 17% | 21% | 13% | 9% | 14% | 32% | 20% |
| Радио /Үндэсний хэмжээнд цацдаг/ | 9% | 10% | 6% | 4% | 2% | 18% | 9% |
| Хурал цуглаан | 13% | 6% | 10% | 3% | 7% | 11% | 9% |
| Сургалтаар | 9% | 5% | 6% | 3% | 8% | 8% | 7% |
| Цахим/Интернэт | 10% | 4% | 11% | 3% | 3% | 5% | 6% |
| Орон нутгийн фм радио | 2% | 3% | 1% | 0% | 0% | 6% | 3% |
| Гар утасны мессеж | 3% | 2% | 2% | 1% | 3% | 2% | 2% |
| Мэргэжилтнүүдийн яриа, зөвлөмж | 3% | 2% | 4% | 0% | 0% | 2% | 2% |
| Өдөр тутмын сонин | 3% | 1% | 4% | 0% | 0% | 2% | 2% |
| Орон нутгийн сонин сэтгүүл | 2% | 1% | 2% | 1% | 0% | 2% | 2% |
| Хэвлэмэл материал | 1% | 2% | 2% | 2% | 0% | 1% | 1% |
| Ам дамжсан яриа | 1% | 1% | 2% | 0% | 0% | 2% | 1% |
| Туршлага судлах, солилцох арга хэмжээ | 2% | 1% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Сурталчилгааны самбар | 2% | 1% | 0% | 1% | 1% | 1% | 1% |
| Салбарын сонин хэвлэл, сэтгүүл | 1% | 0% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Үзэсгэлэн худалдаа | 1% | 0% | 0% | 1% | 0% | 1% | 0% |

Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй хэлбэрийг тодруулахад телевизээр мэдээ, ярилцлага, сурвалжилга, малчдад зориулсан сургалтын нэвтрүүлэг зэрэг хамгийн өндөр хувьтай байна. ФМ, радиогоор цаг үеийн мэдээ, сонин сэтгүүлээр ХАА –н салбарын сонин сэтгүүл, хэвлэмэл материалаар төсөл хөтөлбөрүүдийн хэвлэмэл танилцуулга, цахим интернэтээр аймаг сумын албан ёсны веб сайт, ам дамжсан яриагаар сум орон нутгийн удирдлагын яриа, хурал уулзалт зөвлөгөөнөөр малчдын зөвлөгөөн, мэргэжилтнүүдийн яриагаар тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, хэлтсийн дарга мэргэжилтэн, сургалтаар аймгийн төвийн танхимын сургалт, сурталчилгааны самбараар сумын төвийн сурталчилгааны самбар зэрэг тус тус тэргүүлж байна.

*Хүснэгт 46: Хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээллийг авахыг хүсэж буй хэлбэр*

| МЭДЭЭЛЛИЙН ХЭЛБЭР | Байршил | | Аймаг | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| **Телевиз** | | | | | | | |
| Мэдээ | 59% | 66% | 73% | 65% | 54% | 62% | 64% |
| Ярилцлага | 21% | 19% | 19% | 23% | 16% | 21% | 20% |
| Сурвалжилга | 16% | 17% | 16% | 17% | 18% | 17% | 17% |
| Малчдад зориулсан сургалтын нэвтрүүлэг | 19% | 11% | 20% | 10% | 13% | 10% | 13% |
| Танин мэдэхүйн нэвтрүүлэг /эрүүл мэнд, боловсрол,шинжлэх ухаан/ | 11% | 7% | 7% | 3% | 7% | 12% | 8% |
| Баримтат кино | 10% | 4% | 8% | 2% | 7% | 6% | 6% |
| Ая дууны мэндчилгээ | 5% | 6% | 5% | 5% | 2% | 8% | 5% |
| Цэнгээнт нэвтрүүлэг | 4% | 5% | 4% | 2% | 3% | 7% | 5% |
| Теле зохиомж | 7% | 2% | 4% | 1% | 4% | 4% | 4% |
| Сурталчилгаа/Зар | 4% | 3% | 3% | 2% | 2% | 4% | 3% |
| Олон ангит кино | 2% | 3% | 4% | 1% | 1% | 3% | 3% |
| Бусад /Тодруулах/ | 2% | 2% | 3% | 0% | 2% | 1% | 2% |
| Нийгэм, улс төрийн нэвтрүүлэг | 2% | 1% | 1% | 1% | 0% | 2% | 1% |
| Хувь хүний хөгжилтэй холбоотой нэвтрүүлэг | 3% | 0% | 1% | 1% | 1% | 1% | 1% |
| ТВ форум/ хэлэлцүүлэг | 1% | 1% | 1% | 2% | 1% | 1% | 1% |
| ТВ шоп | 0% | 1% | 0% | 2% | 0% | 0% | 0% |
| **ФМ, радио** | | | | | | | |
| Цаг үеийн мэдээ | 5% | 5% | 3% | 2% | 2% | 9% | 5% |
| Ярилцлага | 3% | 2% | 2% | 2% | 1% | 3% | 2% |
| Сурвалжилга | 2% | 3% | 2% | 1% | 2% | 5% | 3% |
| Цаг агаарын мэдээ | 3% | 3% | 2% | 1% | 1% | 5% | 3% |
| Малчид, тариаланчдад зориулсан зорилтот нэвтрүүлэг | 2% | 0% | 1% | 0% | 0% | 1% | 1% |
| Алдагдсан малын зар | 1% | 0% | 0% | 0% | 0% | 1% | 0% |
| **Сонин, сэтгүүл** | | | | | | | |
| Хөдөө аж ахуйн салбарын сонин сэтгүүл | 4% | 2% | 5% | 1% | 2% | 3% | 3% |
| Өдөр тутмын сонин | 3% | 1% | 3% | 0% | 0% | 3% | 2% |
| Сэтгүүл | 2% | 1% | 2% | 0% | 0% | 2% | 1% |
| **Хэвлэмэл материал** | | | | | | | |
| Төсөл хөтөлбөрүүдийн хэвлэмэл танилцуулга | 1% | 1% | 1% | 2% | 0% | 1% | 1% |
| Малчдад зориулсан гарын авлага | 1% | 0% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Судалгааны материал, тайлан | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| **Цахим/Интернэт** | | | | | | | |
| Аймаг сумын албан ёсны веб сайт | 3% | 1% | 4% | 1% | 0% | 1% | 1% |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайт | 2% | 1% | 3% | 0% | 0% | 1% | 1% |
| Facebook –ын аймаг сумын албан ёсны пэйж хуудас | 2% | 1% | 3% | 0% | 1% | 1% | 1% |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайт | 2% | 1% | 3% | 0% | 0% | 1% | 1% |

| МЭДЭЭЛЛИЙН ХЭЛБЭР | Байршил | | Аймаг | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| Мэдээний сайтууд | 2% | 1% | 2% | 1% | 0% | 1% | 1% |
| Байгаль орчны чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ОУ –ын байгууллагын сайт | 1% | 0% | 2% | 0% | 1% | 0% | 1% |
| Facebook –ын постер | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 1% |
| YouTube –ийн бичлэг | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Facebook –ын байгаль орчны чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ОУ –ын байгууллагын албан ёсны пэйж хуудас | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| **Ам дамжсан яриа** | | | | | | | |
| Сум орон нутгийн удирдлага | 1% | 0% | 1% | 1% | 0% | 1% | 1% |
| Ноолуур болон махны ченжээс | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Найз нөхөд, гэр бүлийнхэн | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Хот айлын, хөршүүдийн болон танилын яриа | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| **Хурал, уулзалт зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг** | | | | | | | |
| Малчдын зөвлөгөөн | 4% | 2% | 1% | 0% | 5% | 4% | 3% |
| Багийн иргэдийн нийтийн хурлаар | 4% | 1% | 4% | 2% | 1% | 2% | 2% |
| Бүлэг, нөхөрлөл, хоршооны хурал | 3% | 1% | 3% | 1% | 1% | 2% | 2% |
| Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар | 3% | 1% | 3% | 0% | 2% | 1% | 2% |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дарга/мэргэжилтэн | .9% | .6% | 1.1% | .5% | .4% | .6% | .7% |
| Туршлага судлах аялал | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Хоршоологчдын зөвлөгөөн | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Үзэсгэлэн худалдаа | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| **Мэргэжилтнүүдийн яриа, зөвлөмж** | | | | | | | |
| Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, хэлтсийн дарга/мэргэжилтэн | 1.2% | .5% | 1.4% | 0.0% | 0.0% | .8% | .7% |
| Байгаль хамгаалагч | .9% | .5% | 1.4% | .5% | 0.0% | .4% | .6% |
| Байгаль орчны байцаагч | .9% | .3% | 1.1% | .5% | 0.0% | .4% | .5% |
| Мал зүйч | .7% | .3% | 1.4% | 0.0% | 0.0% | .2% | .5% |
| Малын эмч | .5% | .5% | 1.4% | 0.0% | 0.0% | .2% | .5% |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дарга/мэргэжилтэн | .2% | .5% | .6% | 0.0% | 0.0% | .6% | .4% |
| Ойн бодлого зохицуулалтын газрын дарга, мэргэжилтэн | .9% | .1% | 1.1% | 0.0% | 0.0% | .2% | .4% |
| Бусад /Тодруулах/ | .2% | .5% | .3% | 0.0% | 0.0% | .8% | .4% |
| Ус, цаг уур орчны шинжилгээний газрын дарга/мэргэжилтэн | .5% | .2% | .9% | 0.0% | 0.0% | .2% | .3% |
| Сумын засаг дарга/удирдлага | .5% | .2% | .6% | 0.0% | 0.0% | .4% | .3% |
| Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга/мэргэжилтэн | .2% | .1% | .3% | 0.0% | 0.0% | .2% | .2% |
| Олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдийн зохицуулагч | .2% | .1% | .3% | 0.0% | 0.0% | .2% | .2% |
| СИТХурлын тэргүүлэгч, төлөөлөгч | 0.0% | .2% | .3% | 0.0% | 0.0% | .2% | .2% |
| Сумын бэлчээр ашиглагчдын холбооны тэргүүн | .2% | .1% | .6% | 0.0% | 0.0% | 0.0% | .2% |
| Ойн нөхөрлөлийн тэргүүн | .2% | .1% | .6% | 0.0% | 0.0% | 0.0% | .2% |
| **Сургалт** | | | | | | | |
| Аймгийн төвд танхимын сургалт | 2% | 1% | 1% | 0% | 3% | 1% | 1% |
| Нийслэл хотод танхимын сургалт | 1% | 1% | 0% | 0% | 2% | 1% | 1% |
| Богино хугацааны мэргэшүүлэх сургалт /14 хүртэлх хоног/ | 1% | 0% | 0% | 1% | 1% | 0% | 1% |
| Урт хугацааны мэргэшүүлэх сургалт /14-өөс дээш хоног/ | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Талбайн үзүүлэх сургалт | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |

| МЭДЭЭЛЛИЙН ХЭЛБЭР | Байршил | | Аймаг | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын төв | Хөдөө | Баянхонгор | Архангай | Завхан | Говь-Алтай | |
| Сумын төвд танхимын сургалт | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Гэрээр мэдлэг олгох хөтөлбөр/Зайны сургалт | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| **Сурталчилгааны самбар** | | | | | | | |
| Сумын төвийн сурталчилгааны самбарууд | 2% | 0% | 1% | 0% | 0% | 1% | 1% |
| Банкин дээрх сурталчилгааны самбар | 1% | 0% | 1% | 0% | 0% | 1% | 1% |
| Дэлгүүр доторх сурталчилгааны салбар | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Худаг дээрх сурталчилгааны самбар | 1% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Эмнэлэг дээрх сурталчилгааны самбар | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |
| Нийгмийн даатгалын газар доторх самбар | 0% | 0% | 1% | 0% | 0% | 0% | 0% |

## *Иргэдэд хүргэх мессеж*

Иргэдэд ямар мессеж хүргэвэл зохистой талаар гол оролцогчдоос тодруулахад:

- Байгаль орчноо зөв зохистой ашиглах, хамгаалах чиглэлийн сургалт орох
- Бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуй эрхлэх
- Малын тоонд бус, чанарт анхаарах (Мянгат малчин сэтгэлгээнээс шилжих)
- Малын ашиг шимээс гадна, малчид өөрсдөө жижиг дунд үйлдвэрлэл нээх
- Бэлчээр, ойн доройтол, ан амьтны устал нь ямар хор нөлөөтэй талаар таниулах
- Байгаль орчны нөхөн сэргэлт нь малчдын хэрэгцээг хязгаарлаж байж хийгдэнэ гэдгийг ойлгуулах
- Бэлчээр, ойн доройтол, ан амьтны устлын шалтгааныг таниулах
- Бэлчээр, ой, ан амьтныг хамгаалах нь ямар ач тустай талаар таниулах
- Хууль дүрмийн талаар мэдээлэл хүргэх
- Гэр бүлийн гишүүдийн харилцааг сайжруулах сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (Сургуулийн хүүхдээс болоод малчид тусдаа амьдарч байгаа. Залуу гур бүлүүдэд маргаантай асуудлууд их гардаг. Эдгээр асуудлуудыг шийдэх талаар лекц орвол их үр дүнтэй санагдсан.)
- Амьжиргаагаа залгуулах санхүүгийн эх үүсвэрийн
- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хэрхэн зах зээлд худалдаалж борлуулах
- Амин хувиа хичээсэн сэтгэхүйг арилгах
- Насанд хүрэгсэд болон хүүхдүүдэд багаас нь боловсрол олгох зэрэг хэлбэрийг зөвлөж байна.

Эдгээр мессежийг ямар хэлбэрээр хүргэвэл илүү үр дүнтэй байх талаар тодруулахад мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтаар, туршлага солилцох хурал зөвлөгөөнөөр, хүмүүсийн туршлагыг таниулсан телевизийн нэвтрүүлгээр, нийтийг хамарсан тв шоу хэлбэрээр, туршлага, уламжлал ёс заншлыг хослуулан сургалт орох, видео хэлбэрээр танилцуулах, сургалт нь зөвхөн ХАА-н талаар бус эрүүл мэнд, нийгмийн даатгал, малын эрүүл мэнд, халамж гээд хүний амьдралд хэрэгтэй сэдвүүдийг хамарвал илүү олон хүн хамрагдана гэж үзэж байна.

## *Гол оролцогч талуудын ХАА, байгаль орчинтой холбоотой мэдээ, мэдээлэл авдаг суваг*

Гол оролцогч талуудын ХАА, байгаль орчинтой холбоотой мэдээ, мэдээлэл авдаг сувгийг тодруулахад үндэсний түвшний оролцогчид гол төлөв интернэт, тэр дундаа мэргэжлийн байгууллагуудын албан ёсны сайтууд, баримт бичиг, тайлан, холбогдох байгууллагаас мэдээлэл авдаг байна. Аймгийн түвшний оролцогчид албан ёсны сайт, холбогдох байгууллага, телевиз, сонин сэтгүүлээс мэдээлэл авах хандлага өндөр байна. Сумын түвшний оролцогчдын хувьд интернэт, телевиз, сургалт, хурал цуглаан, холбогдох байгууллага, радио, сонин сэтгүүлээс мэдээлэл авах байдал өндөр байна. Дараах хүснэгтэд гол оролцогчдын ХАА болон байгаль орчинтой холбоотой мэдээлэл авдаг сувгийг түвшин бүрээр задлан харууллаа.

*Хүснэгт 47: Гол оролцогч талуудын хөдөө аж ахуй болон байгаль орчинтой холбоотой мэдээ, мэдээлэл авдаг суваг*

| **Зорилтот бүлэг** | **Байгаль орчинтой холбоотой мэдээлэл авдаг суваг** | **Мэдээлэл авдаг хэлбэр** |
|---|---|---|
| **1. Үндэсний түвшний оролцогч** | | |
| 1.1 Төрийн байгууллагын ажилтан | Интернэт/Цахим сайт | • Холбогдох байгууллагуудын сайт (ХХААХҮЯ-ны сайт, БОАЖЯ -ны сайт)<br>• Судалгааны байгууллагын сайт<br>• Байгаль орчны мэдээллийн сан - eic.mn<br>• Үндэсний статистикийн хороо -nso.mn<br>• facebook<br>• Scholar буюу ШУ -ны судалгааны тайлан нийтэлдэг сайт |
| | Баримт бичгээр | • Тайлан<br>• Судалгааны материал<br>• Албан бичиг<br>• Ногоон хөгжлийн бодлогын баримт бичгүүд<br>• БОАЖЯ –ны мэдээ<br>• БОАЖЯ, ОУ-н хэвлэл мэдээлэл, судалгааны тайлан<br>• Яаманд ирж буй тайлан мэдээ<br>• Ном |
| | Холбогдох байгууллага | • Яамны дотоод нэгжүүд<br>• Аймаг, сум, багаас мэдээлэл авдаг<br>• Уулзалт, хурал цуглаан |
| | Бусад суваг | • Телевиз<br>• Сонин |
| 1.2 Олон улсын байгууллагын ажилтан | Интернэт/Цахим сайт | • Холбогдох байгууллагуудын сайт (ХХААХҮЯ-ны сайт, БОАЖЯ -ны сайт)<br>• Байгаль орчны мэдээллийн сан - eic.mn<br>• Үндэсний статистикийн хороо -nso.mn<br>• Хамтрагч байгууллагуудын албан ёсны веб сайт<br>• Бусад мэдээллийн сайт |
| | Холбогдох байгууллагаас | • Салбарын мэргэжилтнүүд<br>• Хамтрагч байгууллагууд |
| | Хэвлэмэл материал | • Сонин<br>• Дээр үеийн ном<br>• Судалгааны материал |
| | Цаашид мэдээлэл авахыг хүсэж буй суваг | • Телевиз<br>• Радио<br>• Хурал, уулзалт<br>• Интернэтэд суурилсан нэгдсэн мэдээллийн систем |
| 1.3 Хувийн хэвшил, нөхөрлөл | Интернэт/Цахим сайт | • Холбогдох байгууллагуудын сайт (ХХААХҮЯ-ны сайт, БОАЖЯ -ны сайт)<br>• ХХАА –н холбоо |
| | Бусад суваг | • Телевиз (мэдээ, нэвтрүүлэг)<br>• Ном |

| Зорилтот бүлэг | Байгаль орчинтой холбоотой мэдээлэл авдаг суваг | Мэдээлэл авдаг хэлбэр |
|---|---|---|
| | | • Сэтгүүл<br>• Мэргэжлийн хүмүүс |
| | Цаашид мэдээлэл авахыг хүсэж буй суваг | • Судалгаанд суурилсан сургалт, семинар<br>• Телевизийн хөтөлбөрийн 2 хувийг байгаль орчинтой холбоотой болгох<br>• Малчин ТВ –ээр богино, сурталчилгаа хэлбэрээр гаргах<br>• Цахим |
| **2. Аймгийн түвшний оролцогч** | | |
| 2.1 Төрийн байгууллагын ажилтан | Цахим сайт | • Хуулийн сайт (legalinfo.mn)<br>• Аймгийн ХАА –н газрын сайт<br>• Яамны сайтууд<br>• Facebook<br>o Малын үнэ ханштай холбоотой мэдээлэл<br>o Аймгийн page хуудас<br>o Бусад холбогдох байгууллагын page хуудас<br>• Аймгийн веб сайт |
| | Холбогдох байгууллагаас | • ХХААЯ<br>• БОАЖЯ<br>• Яам, агентлаг<br>• Олон улсын хамтрагч байгууллагууд<br>• Мэргэжилтнүүд<br>• Сум орон нутгийн байгууллагууд<br>• Иргэд хөдөлмөрчид |
| | Телевиз | • Малчин ТВ, Үндэсний олон нийтийн радио телевиз, TV9, TV5, UBS, Монгол ТВ<br>o Мэдээ<br>o Цаг уурын мэдээ<br>o Байгаль орчны нэвтрүүлэг<br>• Орон нутгийн суваг<br>o Мэдээ<br>o Бэлчээрийн даацын мэдээ (Баянхонгор аймаг) |
| | Сургалт, хурал цуглаан | • Төсөл хөтөлбөрийн сургалт<br>• Холбогдох байгууллагуудын сургалт, семинар<br>• Эрдэм шинжилгээний хурал |
| | Хэвлэмэл материал | • Сонин (Өдрийн сонин, Малчин сонин)<br>• Ном<br>• Судалгааны тайлан, мэдээ<br>• Хууль, дүрэм<br>• Гарын авлага |
| | Бусад | • Радио |
| 2.2 Олон улсын байгууллага | Интернэт/Цахим сайт | • БОАЖЯ, ХХААХҮЯ –ны албан ёсны сайт<br>• Нэгдсэн мэдээллийн сан |
| | Мэргэжилтнүүд | • Сум орон нутгийн мэргэжилтнүүд<br>• Өөрийн байгууллагын мэргэжилтнүүд |
| | Бусад | • Хурал цуглаан<br>• Телевиз (Малчин ТВ) |
| | Цаашид мэдээлэл авахыг хүсэж буй суваг | • Орон нутгийн иргэд, удирдлагуудаас шууд мэдээлэл авдаг байх<br>• Албан ёсны төр захиргааны байгууллагаас цуглуулсан мэдээллийн үнэн бодит байдлыг иргэдийн мэдээлэлтэй нийцэж байна уу гэдэгтэй дүн шинжилгээ хийчих боломжтой байх |
| 2.3 Нөхөрлөл хоршоо | Холбогдох байгууллагууд | • Төрийн байгууллагууд,<br>• Албан газрын дарга нар<br>• Иргэд |
| | Бусад | • Хууль, дүрэм журам<br>• Телевиз (Малчин ТВ)<br>• Интернэт<br>• Сошиал |

| Зорилтот бүлэг | Байгаль орчинтой холбоотой мэдээлэл авдаг суваг | Мэдээлэл авдаг хэлбэр |
|---|---|---|
| | | • Хэвлэмэл материал |
| | Цаашид мэдээлэл авахыг хүсэж буй суваг | • Хамтрагч байгууллагуудын харилцааг сайжруулах<br>• Гарын авлага<br>• Гар утас |

| Зорилтот бүлэг | Байгаль орчинтой холбоотой мэдээлэл авдаг суваг |
|---|---|
| **3. Сумын түвшний оролцогч** | |
| 3.1 Төрийн байгууллага | • Интернэт /Сошиал/Салбарын албан ёсны веб сайтууд<br>• ТВ (Малчин ТВ, МҮОНРТ)<br>• Сургалтаар<br>• Салбарын мэргэжилтнүүд<br>• Холбогдох байгууллагаас<br>• Радио<br>• Батлагдсан хууль дүрэм<br>• Иргэдээс<br>• Багийн даргаас<br>• Сонин<br>• Салбарын сэтгүүл<br>• Хурлаар<br>• Утсаар<br>• Судалгааны тайлан<br>• Төсөл хөтөлбөрүүдээс |
| 3.2 Нөхөрлөл хоршоо, төрийн бус байгууллага | • Телевиз (Малчин ТВ, МҮОНРТ)<br>• Интернэт/Сошиал<br>• Радио<br>• Иргэд/ Малчид<br>• Хурал цуглаан<br>• Холбогдох байгууллагууд<br>• Өөрийн байгууллагын дарга |

## ДҮГНЭЛТ

### *Бэлчээрийн доройтол*

Малчин өрхийн бүтцийг авч үзвэл нэг өрх дунджаар 4 хүн амьдарч байгаа ба хамгийн ихдээ 11 хүн амьдарч байна. Малчин өрхийн тэргүүн дунджаар 44 настай *(хамгийн залуу өрхийн тэргүүн 18 настай, хамгийн өндөр настай өрхийн тэргүүн 85 настай)* байна. Эрэгтэй малчин өрхийн тэргүүн дунджаар 42 настай, эмэгтэй малчин өрхийн тэргүүн дунджаар 52 настай байна.

Улсын хэмжээнд бодлого тодорхойлогчдын үзэж байгаагаар төслийн зорилтот сум орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахын тулд авах арга хэмжээ нь иргэд, сум орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийнхтэй ижил төстэй санал, санаачилгууд дурдагдаж байна. Тухайлбал, малын тоо толгойг бууруулж, чанарт илүү анхааран малын үүлдэр, угсаа чанаржуулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, цаашлаад бүлэг, хоршоодын зохион байгуулалтад оруулах, малчдыг нийгэмшүүлэх, мэдлэгжүүлэх зэрэг соён гэгээрэлтэй холбож байна. Өөрөөр хэлбэл, амьжиргааны түвшин сайжирвал, хүн анхдагч хэрэгцээгээ хангаж чадвал дараагийн мэдлэг, мэдээлэл боловсрол, амьдралын чанарыг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Үүнд, нүүдлийн мал аж, ахуйг сурталчлан аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол орны баялаг байгалиас эмийн ургамлын үр ашгийн талаар мэдлэгжүүлэх, мод үржүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах зэрэг байна.

Малчин өрх, орон нутгийн удирдлага, бодлого тодорхойлогчдын хувьд бэлчээрийн доройтол гэж бэлчээрийн даац хэтрэхийг ойлгодог байна.

Бэлчээрийн доройтлыг малчин өрх болон улс орны хэмжээнд ч нэн тэргүүний тулгамдсан асуудал мөн хэмээн тодорхойлж байна. Сум болон хөдөөгийн малчин өрх, аймаг сум, орон нутгийн онцлог зэргээс үл хамааран 96.1 хувь нь бэлчээр нь манай өрхийн амьдрал ахуйд чухал ач холбогдолтой гэсэн байна. Мөн сум орон нутгийнхаа хамгийн их тулгамдаж байгаа асуудал мөн хэмээн 91.9 хувь нь үзэж байсан ба бэлчээрийн доройтлыг бууруулахгүй бол байгалийн тэнцвэрт байдал алдагдана гэж 95.4 хувь нь үзэж байна.

Мөн малчид бэлчээрийн доройтол тулгамдсан асуудал мөн бөгөөд бууруулах шаардлагатайг мэдэж байгаа ч юу хийх, ямар арга хэмжээ авахаа 87.0 хувь нь мэдэхгүй байна. Нөгөөтээгүүр өрхөд тулгамдаж буй бусад асуудлаасаа дээгүүрт тавьж энэ тал дээр юу хийх, яаж бэлчээрийн доройтлыг бууруулахад амьдрал ахуйдаа анхаарч ажиллахад бэлэн байна. Өөрөөр хэлбэл бэлчээрийн доройтлыг бууруулах нь малчдын хувьд нэн тэргүүний тулгамдсан асуудал бөгөөд амьдрал ахуй нь бэлчээрээс шууд хамааралтайг мэддэг бөгөөд хэрхэн энэ асуудлаас гарах, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд юу хийх ёстойгоо мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

Бэлчээрийн доройтлын шалтгааныг цаг агаарын өөрчлөлт, дэлхийн дулаарал хур тунадас багассантай холбон 92.4 хувь нь буюу хамгийн өндөр хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Үүний дараагаар бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна гэдэгтэй 85.6 хувь нь санал нийлсэн байна. Малчдаас өөрсдөөс нь шалтгаалсан буюу зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж бэлчээр доройтсон гэдэгтэй 70.0 хувь нь санал нийлсэн байна. Дээр дурдсанчлан бэлчээрийн доройтол гэдэг нь бэлчээрийн даац хэтрэх гэж 51.4 хувь нь нэрлэж байсан бол үүний шалтгааныг цаг агаарын өөрчлөлттэй холбон ойлгодог байна. Өөрөөр хэлбэл, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан хур тунадас багасан малчид худаг, усаа бараадах болон аймаг, сумын төв үйлчилгээтэй холбоотойгоор нэг

дор төвлөрөн нутагладаг болсон нь бэлчээрийн даац хэтрүүлэн бэлчээр доройтоход хүргэж байна гэж харж болохоор байна.

Бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой гэж малчдын 83.1 хувь нь үзэж байгаа бол уг хандлагад сумын төвийн малчид хөдөөгийн малчдаас 2.9 пунктээр илүү санал нийлсэн байна.

Малчдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахад хүний нөлөө заавал байх ёстой энэ чиглэлээр малынхаа тоог бууруулах замаар оролцоход бэлэн байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Учир нь бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй (59.5 хувь), бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар нөхөн сэргээгдэнэ, үүнд хүний оролцоо огт хэрэггүй (40.0 хувь) гэх хандлагуудтай хамгийн бага санал нийлсэн үр дүн гарсан байна.

Мөн нөгөөтээгүүр, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй 79.9 хувь нь санал нийлсэн байна. Тус үзүүлэлт Баянхонгор болон Архангай аймагт 83.8 хувь байгаа бол Завхан, Говь-Алтай аймагт 76.8 хувьтай байгаа юм.

Баянхонгор аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам нь малчдынхтай ижил малын тоо толгойг бууруулах, малын чанар, чанартай цөөн тооны малтай болох, бэлчээрийг хашиж хамгаалах, бэлчээрийг сэлгэж ашиглах зэрэг байна. Үүнээс гадна, ажлын байрыг нэмэгдүүлэх, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах, сумын бүх багийн малчдыг бэлчээр ашиглалтын хэсгийн зохион байгуулалтад оруулах зэрэг ажлуудыг хийх шаардлагатай гэж хэлсэн байна.

Архангай аймгийн сумдын удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам нь малчдынхтай ижил малын тоо толгойг бууруулах, малын чанар, чанартай цөөн тооны малтай болох, бэлчээрийг хашиж хамгаалах, бэлчээрийг сэлгэж ашиглах зэрэг байна. Үүнээс гадна, иргэдийн ухамсар, мэдлэг, туршлагад анхаарч ажиллах шаардлагатайг бараг бүх ярилцлагад оролцогчид дурдаж байгаа нь маш том давуу тал юм. Мөн бэлчээрийн чанар бүх хүний амьдралд нөлөөлдөг тул тодорхой хэмжээний хууль эрх зүйн үндэстэй, төрийн бодлоготой уялдаа холбоотойгоор бүсчлэн татвар авах, авсан татвараа бэлчээрийн доройтлыг бууруулахад зориулж байх гэсэн санаа олон давтагдаж байгаа нь Архангай аймгийн удирдлага болон мэргэжилтнүүд татварын асуудал болон хуулийн зохицуулалт зэрэгт сэтгэл зүйн бэлтгэлтэй байгаа нь харагдаж байна.

Завхан аймгийн сумдын удирдлагуудын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малын тоо толгойг бууруулж, чанаржуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, бүх оролцогчдоос бэлчээр сэлгэх нүүдлийг хийх шаардлагатай гэсэн санаа гарч байсан юм.

Говь-Алтай аймгийн сумдын хувьд бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малын тоо толгойг бууруулж, нөгөө 3 аймгаасаа харьцангуй их бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд бэлчээрийн зүй зохистой хуваарилалтыг хийхийг хичээдэг болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд бүх сумдад бэлчээрийн сэлгэлтийг хийхийг шаардаж ажилладаг байна.

## *Ойн доройтол*

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 13 сумын 30 багийн хувьд 11 сумын 25 баг нь тодорхой хэмжээгээр ойтой байна.

Ойн доройтлыг малчин өрхийн хувьд тулгамдсан асуудал мөн эсэхэд Завхан, Архангай аймгийн хувьд 98.2 хувьтай санал нийлэх хандлагатай байгаа бол Баянхонгор, Говь-Алтай аймгийн хувьд 87.5 хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Дунджаар нийт аймгуудын малчин өрхийн 92.9 хувь нь ойг өрхийн амьдрал ахуйд ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн сум орон нутгийнхаа хамгийн их тулгамдаж байгаа асуудал мөн хэмээн 91.5 хувь нь үзэж байсан ба ойн доройтлыг бууруулахгүй бол байгалийн тэнцвэрт байдал алдагдана гэж 95.7 хувь нь үзэж байна.

Мөн малчид ойн доройтол тулгамдсан асуудал мөн бөгөөд бууруулах шаардлагатайг мэдэж байгаа ч юу хийх, ямар арга хэмжээ авахаа 88.3 хувь нь мэдэхгүй байна. Нөгөөтээгүүр ойн доройтлыг бууруулахад амьдрал ахуйдаа анхаарч ажиллахад бэлэн байгаа хандлага 67.8 хувьд нь байна. Өөрөөр хэлбэл ойн доройтлыг бууруулах нь малчдын хувьд нэн тэргүүний тулгамдсан асуудал бөгөөд амьдрал ахуй нь ойтой хамааралтайг мэддэг бөгөөд хэрхэн энэ асуудлаас гарах, ойн доройтлыг бууруулахын тулд юу хийх ёстойгоо мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

Ойн доройтлын шалтгааныг дэлхийн дулаарал хуурайшилт ихэссэнтэй холбон 93.0 хувь нь буюу хамгийн өндөр хувьтайгаар санал нийлэх хандлагатай байна. Малчдаас өөрсдөөс нь шалтгаалсан буюу зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж ой доройтсон гэдэгтэй 90.2 хувь нь санал нийлсэн байна. Үүний дараагаар ойн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна гэдэгтэй 89.7 хувь нь санал нийлсэн байна.

Ойн доройтлыг бууруулахын тулд малчид болон сум орон нутгийн удирдлагууд хамтран ажиллах ёстой гэдэгтэй 93.3 хувиар санал нийлсэн нь ойн доройтлыг бууруулах боломжийн хувьд хамгийн өндөр санал нийлсэн тодорхойлолт байгаа юм.

Дэлхийн дулаарал, хуурайшилтаас болж ой доройтож байгаа гэдэгтэй хамгийн өндөр санал нийлсэн малчид ойн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ ч юу ч өөрчлөгдөхгүй гэсэн хандлагатай 61.9 хувь нь санал нийлсэн байна.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн иргэдийн хувьд ойгоо түлшний зориулалтаар хамгийн өндөр буюу 45.6 хувь нь ашигладаг байна.

Баянхонгор аймгийнхны хувьд 16.2 хувь нь ашиг шим хүртдэггүй буюу ойгоо ашигладаггүй гэх хандлагатай байна.

Архангай аймгийнхан хашаа барих (29.3 хувь), жимс түүх (23.4 хувь) байдлаар ашиглаж байна.

Завхан аймгийнхны хувьд хамгийн ихээр буюу 71.8 хувь нь жимс, жимсгэнэ түүж ашиглаж байна.

Ойн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг агаар цэвэршүүлдэг гэж 37.0 хувь нь, булаг шандыг усаар тэтгэдэг гэж 34.2 хувь нь, хүчил төрөгч ялгаруулдаг гэж 26.2 хувь нь, элсний нүүдлийг зогсоодог гэж 22.3 хувь нь, зэрлэг амьтдын амьдрах орчин болдог гэж 20.8 хувь нь,

дэлхийн дулаарлыг бууруулдаг гэж 14.2 хувь нь, хүлэмжийн хийг шингээдэг гэж 11.4 хувь нь тус, тус мэддэг байна.

Ойгоос хамгийн их жимс түүж ашиг шим хүртдэг Завхан аймгийнхны 14.9 хувь нь мөнх цэвдгийг тогтоон барьдгийг мэддэг байна. Тэдний түүж ашигладаг жимс, жимсгэнэ нь мөнх цэвдэгт хөрсөнд ургадгийг ерөнхийдөө мэддэг хүмүүс байдаг байна.

Говийн бүсийн аймгууд болох Баянхонгор (34.4 хувь), Говь-Алтай (33.8 хувь), аймгийнхны хувьд элсний нүүдлийг зогсоодгийг мөн ерөнхийдөө мэддэг байна.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн ойн доройтлыг бууруулахын тулд мод тарих гэсэн үзүүлэлт хамгийн өндөр буюу 34.1 хувьтай нэрлэгдсэн байна. Үүний дараагаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох гэсэн үзүүлэлт 21.5 хувь, тарьсан модоо арчилж хамгаалах гэж 17.7 хувь, иргэд олон нийтийг эерэг хандлагатай болгох гэж 14.7 хувь нь үзэж байна.

Ойгоос хүртдэг хамгийн олон төрлийн ашиг шим хүртдэг Завхан аймгийнхны хувьд ойн доройтлыг бууруулахын тулд юу ч хийдэггүй гэж 56.5 хувь нь хариулсан байна. Архангай аймгийнхны 32.0 хувь нь, Говь-Алтай аймгийнхны 25.7 хувь нь, Баянхонгор аймгийнхны 9.1 хувь нь тус, тус юу ч хийдэггүй гэж хариулсан байна. Ойдоо ахуйн хог хаягдал хаяхгүй байх нь малчдын ойн доройтлыг бууруулахын тулд хийж байгаа хамгийн том ажил байна. Энэ нь дунджаар 18.5 хувьтай байна.

Малчин өрхийн амьжиргаагаа залгуулж буй гол эх үүсвэр нь мал аж, ахуйгаас авч буй малын ашиг шим юм. Малын ашиг шим бол бэлчээрээс 100 хувь хамаардаг. Гэвч Монгол орны хувьд бүхэлдээ бэлчээрийн доройтолд өртсөн байгаа. Бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаан нь малын тоо, толгойн хэт өсөлт болж байна. Иймд бэлчээрийн доройтлыг бууруулах гол арга зам нь малын тоо, толгойг бууруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх болж байна.

Үүнийг малчид болон аймаг, сумын удирдлага, бодлого тодорхойлогчид аль, аль талдаа мэдэж байгаа боловч авах арга хэмжээгээ буюу малын чанар, үүлдэр угсааг яаж чанаржуулахаа мэдэхгүй байгаа нь, үүний тулд юу хийх ёстойгоо мэдэхгүй байна.

Мал бол малчдын өмч учраас шууд тоо, толгойг нь бууруул гэж удирдлагын зүгээс нэгдсэн арга хэмжээ авч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, малчид малын тоо, толгойг бууруулах ёстойгоо мэдэж байгаа ч ийм арга хэмжээ авахгүй байна. Нэг талаас малчид төр засгийн бодлого шийдвэр, хууль эрх зүйн орчны зохицуулалтыг хүлээж байна. Нөгөө талаас сум, аймаг орон нутгийн удирдлагууд малчдын хандлагыг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд бэлчээр сэлгэж нүүлгэх, нүүх шаардлагатайг мэдэж байгаа ч худаг, ус, бэлчээрийн зохион байгуулалтаас болоод хаашаа нүүлгэхээ мэддэггүй байна.

### *Ховор ан амьтан, ургамал*

Ховор ан амьтанд хандах иргэдийн хандлага бэлчээр, ойн асуудалд хандах хандлагаас харьцангүй бага байна. Ховор ан амьтныг хамгаалах нь **байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах ач тустай** бөгөөд хамгаалах нь зөв гэдэгтэй санал нийлж байна. Гэсэн хэдий ч хэрхэн яаж хамгаалах талаар мэдэхгүй байна. Мөн байгаль орчны тэнцвэрт байдалд ямар нөлөөтэй талаар нарийн ойлголт бүх түвшиндээ дутмаг байгаа нь судалгаанаас харагдлаа. Ховор ан амьтны устал нь байгаль цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагаатай холбоотой гэж иргэд үзэж байна. Хүний үйл ажиллагаа дотроо малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн зүй зохисгүй ашиглалт, хотжилт, хууль бус ан агнуур зэрэг гол нөлөө үзүүлж байна. Эдгээр

шалтгаанаас болж ховор ан амьтад хоол тэжээлийн хомсдолд орох, усны хомсдолд орох, амьдрах орон нутаггүй болж дайжих зэрэг асуудал үүсэж байна.

Иргэдийн хувьд ховор ан амьтны талаар ач тусыг тэр дундаа байгаль орчиндоо яг ямар нөлөөтэй талаар мэдлэг дутмаг байна. Иймд байгаль орчиндоо ямар нөлөө үзүүлдгийг таниулах нь тухайн амьтдыг цаашид хайрлаж хамгаалахад ач тустай.

Ховор ан амьтныг хамгаалахын тулд өвс, мөс тавьж өгөх биотехнологийн аргыг гол төлөв ашиглаж байна. Цаашид хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, хууль бус анг таслан зогсоох, хууль ангийн хуулийг чангалж, хяналтыг сайжруулах, байгаль хамгаалагчийн тоог нэмэгдүүлэх, усны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Ховор ургамлын хувьд говийн аймгуудаас улаангоёо, хармаг ургамлын талаарх хандлагыг тодрууллаа. Улаангоёо, хармаг ургамал нь устах аюул орсон гэдэгтээ санал нийлэх байдал өндөр байна. Гэвч эдгээр ургамлыг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэгтээ санал нийлэх байдал харьцангуй бага байна.

## *Мэдээллийн сувгийн төлөвлөгөө*

Иргэдийн байгаль орчноо хамгаалах нөхөрлөл хоршоонд нэгдсэн байдал 7 хувьтай байна. Иргэдийн хувьд ойн нөхөрлөлд нэгдэх байдал хамгийн өндөр байна.

Иргэдийн өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургалтад хамрагдсан байдал 24 хувьтай байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургалтад хамрагдсан тоо дунджаар 3 байна. Сумын төвийн иргэд сургалтад хамрагдах байдал хөдөө орон нутгийн иргэдээс илүү өндөр байна. Цаашид сургалтад хамрагдах сонирхол 78 хувьтай байна. Тэр дундаа эмэгтэй хүмүүс сургалтад хамрагдах сонирхол илүү өндөр байна.

Иргэдийн голчлон мэдээлэл авдаг сувгийг тодруулахад телевиз 91 хувьтай хамгийн өндөр буюу гол мэдээлэл авдаг суваг нь байна. Сумын төвийн иргэдийн хувьд интернэтэд орох байдал хөдөө орон нутгийн иргэдээс илүү өндөр буюу 31 хувьтай байна.

Мэдээллийн сувгийн хэрэглээнд улирлын нөлөө байхгүй байна. Харин насны бүлгийн хувьд нас нэмэгдэх тусам уламжлал медиа хэрэглээ (телевиз, фм радио, сонин), нас буурах тусам дижитал медиа хэрэглээ (интернэт, гар утас) нэмэгдэж байна. Сургалт, хурал цуглаанд хамрагдах байдал 25-44 насны бүлэгт хамгийн өндөр хувь эзэлж байна.

Иргэдийн голчлон үздэг телевизийн суваг нь МҮОНРТ, Малчин ТВ сувгууд зонхилж байна. Телевиз үздэг оргил цаг нь оройны 19 цагаас 23 цагийн хооронд байна. Голчлон үздэг нэвтрүүлэгт мэдээний хөтөлбөр, малчдад зориулсан хөтөлбөр, кино зэрэг багтана.

Цаашид мэдээ, мэдээлэл авахыг хүсэж буй сувагт телевиз, сургалт, зөвлөгөөн, интернэт, радио зэрэг багтаж байна.

Сургалтын зохион байгуулахдаа зөвхөн байгаль орчинтой холбоотой сэдвээр бус иргэдийн амьдрал ахуйд өдөр тутам хэрэг болох иргэний эрүүл мэнд, малын эрүүл мэнд, малын чанарыг сайжруулах арга аргачлал, ТУРШЛАГА, нийгмийн даатгал, өрхийн амьжиргаа, санхүүгийн боловсрол зэрэг сэдвийг хамруулбал иргэдийн хамрагдах байдал илүү өндөр байна гэж үзэж байна. Мөн сургалтыг хамгийн чухал сэдвүүдийнхээ хүрээнд сумын түвшинд бус багийн түвшинд зохион байгуулбал сумаас алслагдмал иргэдэд хүрэх магадлал өснө.

Гол оролцогч талуудын мэдээлэл авдаг гол эх сурвалж нь интернэт бөгөөд тэр дундаа холбогдох байгууллагын албан ёсны веб сайтаас мэдээ, мэдээллийг авдаг байна. Мөн хамран ажиллаж буй байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүдээс, судалгааны тайлан, сургалт, хурал зөвлөгөөнөөс мэдээлэл авах байдал өндөр байна.

Иргэдэд мэдээлэл хүргэхэд анхаарах зүйл нь малчдын хандлагыг малын тооноос чанарт анхаарахад чиглэсэн, малын тоо толгой бууруулах, бэлчээрийн зүй зохистой хэрэглээг нэвтрүүлэх, дадал хэвшил болгох, бэлчээр, ойн доройтол, ховор ан амьтны устлын талаарх хор уршгийг таниулах, эдгээр хүчин зүйлийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг таниулах сургалт, мэдлэг мэдээлэл хүргэх хэрэгтэй байна.

## ЗӨВЛӨМЖ

### Олон нийтийн хувьд гол хүргэх мессеж

| Асуудал | Хүргэх мессеж |
|---|---|
| **Бэлчээр** | |
| Олон нийтийн хувьд бэлчээрийн доройтлыг тулгамдсан асуудал гэж үзэж байгаа ч ямар арга хэмжээ авах талаар мэдэхгүй байна. | • Бэлчээрийн доройтлыг бууруулах арга замыг таниулах<br>• Иргэдийн үүрэг, оролцоог ойлгуулах<br>• Сүргийн бүтцэд өөрчлөлт оруулах |
| Малын тоо толгойн өсөлтөөс болж бэлчээр доройтож байгааг мэддэг ч малын тоо толгойгоо хэрхэн бууруулах талаар мэдэхгүй | • Малын үүлдэр угсааг сайжруулж, нэг малаас авах ашиг шимээ нэмэгдүүлэх<br>• Зах зээлд хэрхэн борлуулах талаар таниулах |
| Малынхаа чанарыг нэмэгдүүлсэн ч тоог бууруулах сонирхолгүй иргэд байна | • Иргэдийн хандлагыг өөрчлөх. Ингэхийн тулд малын тоо нэмэгдэх тусам малын чанар муудаж, авах ашиг шим нь буурдаг гэдгийг ойлгуулах |
| **Ой** | |
| Ойн доройтол нь байгаль цаг уурын өөрчлөлттэй холбоотой, төр засгаас дорвитой арга хэмжээ авахгүй байна | • Ойн доройтолд хүний үйл ажиллагаа нөлөөлж, хүний гараар арчлах арчилгаа дутагдсанаас болж доройтолд хүрч байна гэдгийг ойлгуулах. |
| Хүн хувийн ашиг олохгүй л бол нөхөрлөл хоршоонд идэвхтэй ажилладаггүй байдаг | • Мэргэжлийн байгууллагуудтай хамтарч нутгийн иргэдийг татан оролцуулах, идэвхжүүлэх |
| **Ховор ан амьтан, ургамал** | |
| Ховор ан амьтныг байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал нөлөөтэй гэдгийг мэддэг ч яг ямар ач тустай талаар ойлголтгүй | • Ховор ан амьтны байгаль орчинд яг ямар нөлөө үзүүлдгийг таниулах |
| Ховор ан амьтныг хамгаалахын тулд юу ч хийдэггүй | • Ховор ан амьтныг хамгаалах арга замыг таниулах<br>• Иргэдийн оролцоо чухал байгааг ойлгуулж, нөхөрлөлүүдийг идэвхжүүлэх |
| Улаангоёоны ховордож буй шалтгааныг дийлэнх хувь нь мэдэхгүй байна. | • Улаангоёог зөв түүж бэлтгэвэл нөөц нь нэмэгдэх боломжтой гэдгийг таниулах |

**Олон нийтэд хүргэх мессеж, гол оролцогч талуудын үзэж байгаагаар:**

- Байгаль орчноо зөв зохистой ашиглах, хамгаалах чиглэлийн сургалт орох
- Бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуй эрхлэх
- Малын тоонд бус, чанарт анхаарах (Мянгат малчин сэтгэлгээнээс шилжих)
- Малын ашиг шимээс гадна, малчид өөрсдөө жижиг дунд үйлдвэрлэл нээх
- Бэлчээр, ойн доройтол, ан амьтны устал нь ямар хор нөлөөтэй талаар таниулах
- Байгаль орчны нөхөн сэргэлт нь малчдын хэрэгцээг хязгаарлаж байж хийгдэнэ гэдгийг ойлгуулах
- Бэлчээр, ойн доройтол, ан амьтны устлын шалтгааныг таниулах
- Бэлчээр, ой, ан амьтныг хамгаалах нь ямар ач тустай талаар таниулах
- Хууль дүрмийн талаар мэдээлэл хүргэх
- Гэр бүлийн гишүүдийн харилцааг сайжруулах сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (Сургуулийн хүүхдээс болоод малчид тусдаа амьдарч байгаа. Залуу гур бүлүүдэд маргаантай асуудлууд их гардаг. Эдгээр асуудлуудыг шийдэх талаар лекц орвол их үр дүнтэй санагдсан.)
- Амьжиргаагаа залгуулах санхүүгийн эх үүсвэрийн
- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хэрхэн зах зээлд худалдаалж борлуулах
- Амин хувиа хичээсэн сэтгэхүйг арилгах
- Насанд хүрэгсэд болон хүүхдүүдэд багаас нь боловсрол олгох зэрэг хэлбэрийг зөвлөж байна.

## Гол оролцогч талуудын хувьд гол хүргэх мессеж

| Асуудал | Шийдвэрлэх арга зам | Хүргэх мессеж |
|---|---|---|
| **Бэлчээр** | | |
| Гол оролцогч талууд Монголд хууль эрхзүйн орчин бүрдээгүй учраас бэлчээрийн доройтол, малын тоо толгойн өсөлт хяналтаас гарсан | • Хууль эрх зүйн орчныг сайжруулах<br>• Хоорондоо уялдаатай бодлого явуулах | • Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг танилцуулах |
| **Ой** | | |
| Шийдвэр гаргагч түвшний хүмүүс болон олон нийт, нөхөрлөл хоорондын хамтарч, уялдаа холбоотой ажиллах байдал бага байна.<br>Нөхөрлөлүүдийн оролцоо сул байна. Иргэд нөхөрлөлд орж ажиллах байдал, нэгдсэн ч идэвхтэй ажиллах байдал сул | • Нөхөрлөлүүдэд эрх мэдэл олгох<br>• Нөхөрлөлүүдийг мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллуулах<br>• Чадавхжуулах<br>• Иргэдийг татан оролцуулах боломж бололцоогоор хангаж өгөх | • Иргэд, нөхөрлөл, мэргэжлийн байгууллага хамтран ойн доройтлыг бууруулах боломжтой гэдгийг таниулах<br>• Иргэдийн оролцоог хангах зорилгоор тэдний үүрэг оролцоо маш чухал байгааг ойлгуулах, хөшүүрэг өгөх |
| **Ховор ан амьтан, ургамал** | | |
| Ховор ан амьтны талаарх ойлголт, байгаль орчинд үзүүлэх нөлөөний талаарх мэдлэг дутмаг | • Ховор ан амьтан ургамал нь хэрхэн байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалдаг талаарх мэдлэг, ойлголт өгөх | • Байгаль орчинд үзүүлэх нөлөө ач тусын талаар таниулах<br>• Ховор ан амьтныг хамгаалахын тулд нөхөрлөл хоршоог идэвхжүүлж, сум орон нутаг, бүх түвшний шийдвэр гаргагчид, орон нутгийн иргэд олон талаар хамтран ажиллах, нэгдсэн зохион байгуулалт, бодлого боловсруулах |

| | | |
|---|---|---|
| Тусгай зориулалтын ангаас орсон орлогыг эргээд амьтан хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах нь хангалтгүй байна | • Ховор ан амьтан хамгаалах үйл ажиллагааны төсвийг тусгай зориулалтын ангийн төлбөрөөс бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих | • Ховор ан амьтныг хамгаалах төсвийн зарцуулалтын талаар хуульчилж, хяналт хэрэгжилтийг сайтар хангах |

## ХАВСРАЛТ

*Хүснэгт 48: Хандлага, нас, хүйс, орлогоор*

| Үзүүлэлтүүд | Нас | | Хүйс | | Өрхийн орлого | |
|---|---|---|---|---|---|---|
| | 18-39 нас | 40+ нас | Эрэгтэй | Эмэгтэй | <600.000 | 600.000< |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| **БЭЛЧЭЭРИЙН ДОРОЙТОЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | | |
| Q2.1. Бэлчээр нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 4.37 | 4.38 | 4.38 | 4.37 | 4.35 | 4.41 |
| Q2.2 Бэлчээрийн доройтол нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудал мөн | 4.15 | 4.26 | 4.24 | 4.16 | 4.22 | 4.17 |
| Q2.3 Бэлчээрийн доройтлыг бууруулахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.22 | 4.25 | 4.25 | 4.21 | 4.24 | 4.23 |
| Q2.4 Бэлчээрийн доройтол нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.97 | 4.00 | 3.95 | 4.01 | 4.02 | 3.90 |
| Q2.5 Бэлчээрийн доройтлоос илүү анхаарал хандуулах асуудал малчдад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.41 | 3.42 | 3.44 | 3.39 | 3.51 | 3.24 |
| Q2.6 Бэлчээрийн доройтол нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж үүсэж байна | 3.62 | 3.67 | 3.60 | 3.70 | 3.66 | 3.65 |
| Q2.7 Бэлчээрийн доройтолд цаг агаарын өөрчлөлт нөлөөлөх (дэлхийн дулаарал буюу хур тунадас багасах) | 4.14 | 4.21 | 4.18 | 4.15 | 4.17 | 4.17 |
| Q2.8 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна. | 3.98 | 4.04 | 4.06 | 3.96 | 4.04 | 3.97 |
| Q2.9 Бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой | 3.94 | 3.94 | 3.93 | 3.95 | 3.95 | 3.93 |
| Q2.10 Бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.28 | 3.36 | 3.39 | 3.24 | 3.41 | 3.17 |
| Q2.11 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малчин би малаас авах ашиг шимээ нэмэгдүүлэн тоо толгойгоо цөөрүүлэн ажиллана | 3.90 | 4.02 | 4.04 | 3.87 | 3.94 | 3.98 |
| Q2.12 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.81 | 3.84 | 3.80 | 3.85 | 3.85 | 3.79 |
| Q2.13 Сум орон нутгийн удирдлагаас бэлчээрийн менежментийн арга хэмжээг бэлчээр ашиглалтын хэсэг байгуулахыг дэмжин зохион байгуулах | 4.21 | 4.17 | 4.17 | 4.21 | 4.16 | 4.25 |
| Q2.14 Бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар (ган зудад нэрвэгдэж) нөхөн сэргээгдэнэ. Үүнд хүний оролцоо огт хэрэггүй. | 2.81 | 2.87 | 2.85 | 2.82 | 2.87 | 2.75 |
| **ОЙН ДОРОЙТОЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | | |
| Q13.1. Ой нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 4.08 | 4.17 | 4.15 | 4.09 | 4.16 | 4.07 |
| Q13.2 Ойн доройтол нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудал мөн | 3.95 | 4.11 | 4.06 | 3.99 | 4.00 | 4.08 |

| Үзүүлэлтүүд | Нас | | Хүйс | | Өрхийн орлого | |
|---|---|---|---|---|---|---|
| | 18-39 нас | 40+ нас | Эрэгтэй | Эмэгтэй | <600.000 | 600.000< |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| Q13.3 Ойн доройтлыг бууруулахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.18 | 4.22 | 4.23 | 4.18 | 4.20 | 4.22 |
| Q13.4 Ойн доройтол нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.91 | 3.99 | 3.93 | 3.97 | 4.00 | 3.85 |
| Q13.5 Ойн доройтлоос илүү анхаарал хандуулах асуудал малчдад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.33 | 3.29 | 3.29 | 3.33 | 3.42 | 3.11 |
| Q13.6 Ойн доройтол нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж үүсэж байна | 3.92 | 3.93 | 3.96 | 3.89 | 3.98 | 3.87 |
| Q13.7 Ойн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна. | 4.04 | 3.99 | 4.04 | 3.99 | 4.03 | 3.99 |
| Q13.8 Дэлхийн дулаарал, хуурайшилт нөлөөлж байна. | 4.03 | 4.18 | 4.09 | 4.11 | 4.10 | 4.11 |
| Q13.9 Ойн доройтлыг бууруулах бүрэн боломжтой | 3.98 | 3.99 | 4.00 | 3.97 | 3.97 | 4.01 |
| Q13.10 Ойн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.20 | 3.18 | 3.21 | 3.18 | 3.30 | 3.00 |
| Q13.11 Ойн доройтлыг бууруулахын тулд малчид болон сум орон нутгийн удирдлагууд хамтарч ажиллах ёстой | 4.27 | 4.28 | 4.30 | 4.24 | 4.24 | 4.36 |
| Q13.12 Ойн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.95 | 3.94 | 3.88 | 4.01 | 3.96 | 3.92 |
| Q13.13 Ой өөрөө байгалийнхаа хуулиар нөхөн сэргээгдэнэ. Үүнд хүний оролцоо огт хэрэггүй. | 2.64 | 2.56 | 2.61 | 2.60 | 2.70 | 2.42 |
| **ХОВОР АН АМЬТАНД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | | |
| Q23.1 Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 3.29 | 3.37 | 3.34 | 3.31 | 3.34 | 3.28 |
| Q23.2 Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн | 3.74 | 3.84 | 3.80 | 3.77 | 3.77 | 3.81 |
| Q23.3 Ховор ан амьтныг хамгаалахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.14 | 4.16 | 4.15 | 4.15 | 4.13 | 4.18 |
| Q23.4 Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.96 | 3.99 | 3.98 | 3.98 | 4.01 | 3.93 |
| Q23.5 Ховор ан амьтны устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.53 | 3.57 | 3.55 | 3.54 | 3.61 | 3.44 |
| Q23.6 Ховор ан амьтны устал нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж байна | 3.82 | 3.84 | 3.84 | 3.81 | 3.83 | 3.82 |
| Q23.7 Ховор ан амьтныг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 3.75 | 3.83 | 3.79 | 3.78 | 3.83 | 3.71 |
| Q23.8 Ховор ан амьтныг хамгаалах бүрэн боломжтой | 4.12 | 4.12 | 4.16 | 4.08 | 4.10 | 4.16 |

| Үзүүлэлтүүд | Нас | | Хүйс | | Өрхийн орлого | |
|---|---|---|---|---|---|---|
| | 18-39 нас | 40+ нас | Эрэгтэй | Эмэгтэй | <600.000 | 600.000< |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| Q23.9 Ховор ан амьтныг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.15 | 3.30 | 3.23 | 3.21 | 3.28 | 3.13 |
| Q23.10 Ховор ан амьтныг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.95 | 4.00 | 3.97 | 3.98 | 3.97 | 3.98 |
| Q23.11 Ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй. | 3.05 | 3.11 | 3.11 | 3.05 | 3.11 | 3.02 |
| **ХОВОР УРГАМАЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | | |
| Улаангоёо ургамал нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 3.06 | 3.24 | 2.91 | 3.37 | 3.31 | 2.98 |
| Улаангоёо устах нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.77 | 4.02 | 3.84 | 3.96 | 3.85 | 3.97 |
| Улаангоёо устахаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.72 | 3.60 | 3.60 | 3.71 | 3.78 | 3.52 |
| Улаангоёо устах нь бэлчээрийн нөлөөгөөр хармаг багассанаас болж байна | 3.98 | 3.87 | 3.80 | 4.04 | 3.93 | 3.91 |
| Улаангоёог түүж хэрэглэснээс тархац нөөц нь багасаж байна | 3.76 | 3.77 | 3.81 | 3.72 | 3.75 | 3.78 |
| Улаангоёо ургамлыг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 4.10 | 3.94 | 3.91 | 4.13 | 4.13 | 3.93 |
| Улаангоёог хамгаалах бүрэн боломжтой | 4.02 | 4.10 | 4.08 | 4.03 | 4.03 | 4.08 |
| Улаангоёо ургамлыг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.39 | 3.25 | 3.35 | 3.28 | 3.51 | 3.12 |
| Улаангоёо ургамлыг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.85 | 3.97 | 3.87 | 3.94 | 3.93 | 3.89 |
| Улаангоёог зөв түүж бэлтгэвэл нөөц нь нэмэгдэх боломжтой гэж үздэг | 2.74 | 2.74 | 2.51 | 2.99 | 2.69 | 2.80 |
| Улаангоёо ургамал нь байгалийн жамаараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. | 2.57 | 2.65 | 2.44 | 2.80 | 2.58 | 2.65 |

*Хүснэгт 49: Хандлага, Байгаль орчныг хамгаалах нөхөрлөл, хоршоонд нэгдсэн байдлаар*

| Үзүүлэлтүүд | Нэгдсэн эсэх | | Нөхөрлөл, хоршооны төрөл | | |
|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Малчдын бүлэг | Бэлчээр ашиглагчдын холбоо | Ойн нөхөрлөл |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| **БЭЛЧЭЭРИЙН ДОРОЙТОЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | |
| Q2.1. Бэлчээр нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 4.45 | 4.37 | 4.71 | 4.56 | 4.24 |
| Q2.2 Бэлчээрийн доройтол нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудал мөн | 4.14 | 4.20 | 4.21 | 4.38 | 3.93 |
| Q2.3 Бэлчээрийн доройтлыг бууруулахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.23 | 4.23 | 4.21 | 4.13 | 4.29 |
| Q2.4 Бэлчээрийн доройтол нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.84 | 3.99 | 3.76 | 3.75 | 3.78 |
| Q2.5 Бэлчээрийн доройтлоос илүү анхаарал хандуулах асуудал малчдад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.55 | 3.40 | 3.92 | 3.20 | 3.59 |
| Q2.6 Бэлчээрийн доройтол нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж үүсэж байна | 3.59 | 3.65 | 3.57 | 3.50 | 3.58 |
| Q2.7 Бэлчээрийн доройтолд цаг агаарын өөрчлөлт нөлөөлөх (дэлхийн дулаарал буюу хур тунадас багасах) | 4.17 | 4.17 | 4.18 | 4.19 | 4.10 |
| Q2.8 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна. | 3.96 | 4.01 | 3.96 | 3.71 | 4.05 |
| Q2.9 Бэлчээрийн доройтлыг бууруулах бүрэн боломжтой | 4.03 | 3.93 | 4.04 | 4.29 | 4.00 |
| Q2.10 Бэлчээрийн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.09 | 3.33 | 3.56 | 2.73 | 2.83 |
| Q2.11 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд малчин би малаас авах ашиг шимээ нэмэгдүүлэн тоо толгойгоо цөөрүүлэн ажиллана | 4.08 | 3.95 | 4.00 | 4.40 | 4.10 |
| Q2.12 Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.77 | 3.83 | 3.81 | 3.60 | 3.87 |
| Q2.13 Сум орон нутгийн удирдлагаас бэлчээрийн менежментийн арга хэмжээг бэлчээр ашиглалтын хэсэг байгуулахыг дэмжин зохион байгуулах | 4.24 | 4.19 | 4.19 | 4.27 | 4.20 |
| Q2.14 Бэлчээр өөрөө байгалийнхаа жамаар (ган зудад нэрвэгдэж) нөхөн сэргээгдэнэ. Үүнд хүний оролцоо огт хэрэггүй. | 2.80 | 2.84 | 3.50 | 3.06 | 2.35 |
| **ОЙН ДОРОЙТОЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | |
| Q13.1. Ой нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 4.21 | 4.11 | 4.17 | 4.13 | 4.28 |

| Үзүүлэлтүүд | Нэгдсэн эсэх | | Нөхөрлөл, хоршооны төрөл | | |
|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Малчдын бүлэг | Бэлчээр ашиглагчдын холбоо | Ойн нөхөрлөл |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| Q13.2 Ойн доройтол нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудал мөн | 4.00 | 4.03 | 3.79 | 4.00 | 4.10 |
| Q13.3 Ойн доройтлыг бууруулахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.22 | 4.20 | 4.29 | 4.22 | 4.18 |
| Q13.4 Ойн доройтол нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.78 | 3.96 | 4.07 | 3.89 | 3.67 |
| Q13.5 Ойн доройтлоос илүү анхаарал хандуулах асуудал малчдад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.21 | 3.32 | 3.43 | 3.25 | 3.13 |
| Q13.6 Ойн доройтол нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж үүсэж байна | 3.79 | 3.94 | 3.85 | 3.50 | 3.83 |
| Q13.7 Ойн доройтлыг бууруулахын тулд төр засаг дорвитой ажил хийхгүй байна. | 3.93 | 4.02 | 3.79 | 4.00 | 3.88 |
| Q13.8 Дэлхийн дулаарал, хуурайшилт нөлөөлж байна. | 4.16 | 4.09 | 4.14 | 4.00 | 4.18 |
| Q13.9 Ойн доройтлыг бууруулах бүрэн боломжтой | 3.92 | 3.99 | 3.79 | 4.00 | 4.10 |
| Q13.10 Ойн доройтлыг бууруулах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.09 | 3.20 | 3.21 | 2.63 | 3.08 |
| Q13.11 Ойн доройтлыг бууруулахын тулд малчид болон сум орон нутгийн удирдлагууд хамтарч ажиллах ёстой | 4.18 | 4.28 | 4.64 | 4.22 | 4.05 |
| Q13.12 Ойн доройтлыг бууруулахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 3.72 | 3.96 | 3.85 | 3.57 | 3.80 |
| Q13.13 Ой өөрөө байгалийнхаа хуулиар нөхөн сэргээгдэнэ. Үүнд хүний оролцоо огт хэрэггүй. | 2.59 | 2.60 | 3.14 | 2.89 | 2.30 |
| **ХОВОР АН АМЬТАНД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | |
| Q23.1 Ховор ан амьтан нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 3.30 | 3.33 | 3.61 | 3.43 | 3.08 |
| Q23.2 Ховор ан амьтны устал нь манай сум орон нутагт хамгийн их тулгамдсан асуудал мөн | 3.76 | 3.79 | 3.92 | 3.57 | 3.73 |
| Q23.3 Ховор ан амьтныг хамгаалахгүй бол байгаль орчны тэнцвэрт байдал алдагдана | 4.09 | 4.15 | 4.22 | 4.07 | 3.97 |
| Q23.4 Ховор ан амьтны устал нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.85 | 3.99 | 4.13 | 3.53 | 3.69 |
| Q23.5 Ховор ан амьтны устлаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.43 | 3.56 | 3.54 | 3.53 | 3.38 |
| Q23.6 Ховор ан амьтны устал нь зөвхөн хүний үйл ажиллагаанаас болж байна | 3.80 | 3.83 | 3.92 | 3.43 | 3.87 |

| Үзүүлэлтүүд | Нэгдсэн эсэх | | Нөхөрлөл, хоршооны төрөл | | |
|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Малчдын бүлэг | Бэлчээр ашиглагчдын холбоо | Ойн нөхөрлөл |
| | Mean | Mean | Mean | Mean | Mean |
| Q23.7 Ховор ан амьтныг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 3.86 | 3.78 | 3.85 | 3.57 | 3.76 |
| Q23.8 Ховор ан амьтныг хамгаалах бүрэн боломжтой | 4.21 | 4.11 | 4.33 | 4.33 | 4.10 |
| Q23.9 Ховор ан амьтныг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 3.09 | 3.23 | 3.24 | 2.64 | 3.00 |
| Q23.10 Ховор ан амьтныг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 4.00 | 3.97 | 4.17 | 3.93 | 4.05 |
| Q23.11 Ховор ан амьтан нь байгалийн хуулиараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. Үүнд хүний оролцоо хэрэггүй. | 2.98 | 3.09 | 3.36 | 3.07 | 2.77 |
| **ХОВОР УРГАМАЛД ХАНДАХ ХАНДЛАГА** | | | | | |
| Улаангоёо ургамал нь манай өрхийн амьдрал ахуйд маш чухал ач холбогдолтой | 3.53 | 3.13 | 4.20 | 3.33 | 3.33 |
| Улаангоёо устах нь тулгамдсан асуудал мөн хэдий ч би ямар арга хэмжээ авах талаар сайн мэдэхгүй байна | 3.75 | 3.92 | 4.60 | 4.00 | 3.67 |
| Улаангоёо устахаас илүү анхаарал хандуулах асуудал надад олон байна. Энэ бол дараагийн асуудал | 3.56 | 3.67 | 3.00 | 4.33 | 4.17 |
| Улаангоёо устах нь бэлчээрийн нөлөөгөөр хармаг багаснаас болж байна | 3.79 | 3.93 | 3.60 | 4.50 | 3.80 |
| Улаангоёог түүж хэрэглэснээс тархац нөөц нь багасч байна | 3.80 | 3.76 | 4.20 | 4.00 | 3.83 |
| Улаангоёо ургамлыг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй байна | 3.94 | 4.02 | 3.60 | 4.33 | 3.83 |
| Улаангоёог хамгаалах бүрэн боломжтой | 4.19 | 4.05 | 4.60 | 4.33 | 4.00 |
| Улаангоёо ургамлыг хамгаалах нь миний мэдэх асуудал биш, би хичээлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй | 2.69 | 3.36 | 2.00 | 2.00 | 3.67 |
| Улаангоёо ургамлыг хамгаалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх ёстой | 4.13 | 3.89 | 4.60 | 3.67 | 3.83 |
| Улаангоёог зөв түүж бэлтгэвэл нөөц нь нэмэгдэх боломжтой гэж үздэг | 3.39 | 2.71 | 2.70 | 3.00 | 4.67 |
| Улаангоёо ургамал нь байгалийн жамаараа өсөж үржиж, тоо хэмжээ нь нэмэгдэж чадна. | 3.29 | 2.57 | 2.40 | 2.75 | 4.83 |

*Хүснэгт 50: Бэлчээр, ойгоосоо хүртдэг ашиг шим, нас, хүйс, өрхийн орлогоор*

| | Нас | | Хүйс | | Өрхийн орлого | |
|---|---|---|---|---|---|---|
| | 18-39 нас | 40+ нас | Эрэгтэй | Эмэгтэй | <600.000 | 600.000< |
| **Бэлчээрээс хүртдэг ашиг шим** | | | | | | |
| Амьжиргаагаа залгуулдаг | 48% | 51% | 51% | 47% | 49% | 48% |
| Малаа бэлчээдэг | 65% | 65% | 70% | 60% | 65% | 65% |
| Орлогын эх үүсвэр болдог | 46% | 46% | 48% | 44% | 44% | 48% |
| Түлш түүдэг /аргал, хомоол, хамхуул/ | 37% | 45% | 42% | 39% | 43% | 38% |
| Малынхаа хужрыг авч ашигладаг | 37% | 41% | 41% | 37% | 42% | 35% |
| Хадлан тэжээлээ бэлтгэдэг | 23% | 27% | 26% | 24% | 27% | 23% |
| Сэтгэлийн баяр баясал мэдэрдэг | 18% | 20% | 20% | 18% | 20% | 18% |
| Эмийн болон ховор ургамал авч ашигладаг | 11% | 10% | 10% | 10% | 12% | 9% |
| Хэлж мэдэхгүй | 4% | 5% | 4% | 5% | 4% | 5% |
| **Ойгоосоо хүртдэг ашиг шим** | | | | | | |
| Түлшинд ашигладаг | 29% | 26% | 26% | 30% | 24% | 33% |
| Хэлж мэдэхгүй | 14% | 16% | 16% | 13% | 17% | 12% |
| Ашиг шим хүртдэггүй | 7% | 10% | 8% | 8% | 7% | 9% |
| Эмийн ургамал түүдэг | 3% | 6% | 4% | 5% | 4% | 6% |
| Жимс, жимсгэнэ түүдэг | 4% | 1% | 2% | 3% | 2% | 4% |
| Амьжиргаагаа залгуулдаг | 2% | 2% | 2% | 2% | 2% | 2% |
| Хашаа барих | 1% | 2% | 1% | 2% | 1% | 2% |
| Мал бэлчдэг /Тэмээ/ | 2% | 2% | 3% | 1% | 2% | 2% |
| Мөөг түүдэг | 1% | 2% | 2% | 1% | 1% | 2% |
| Байшин барих | 0% | 1% | 0% | 1% | 0% | 1% |
| Модон эдлэл хийдэг | 0% | 0% | 0% | 0% | 0% | 1% |
| Хусны шүүс, модны бохь зэрэг модноос шууд авч ашиглаж болохоор зүйлс | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |
| Мод бэлтгэж худалдаалдаг | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% |

*Хүснэгт 51: Бэлчээр, ойгоос хүртдэг ашиг тус*

| | Нэгдсэн эсэх | | Нөхөрлөл, хоршооны төрөл | | |
|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Малчдын бүлэг | Бэлчээр ашиглагч дын холбоо | Ойн нөхөрлөл |
| **Бэлчээрээс хүртдэг ашиг шим** | | | | | |
| Амьжиргаагаа залгуулдаг | 74% | 47% | 69% | 85% | 88% |
| Малаа бэлчээдэг | 70% | 65% | 73% | 77% | 75% |
| Орлогын эх үүсвэр болдог | 61% | 45% | 62% | 62% | 50% |
| Малынхаа хужрыг авч ашигладаг | 35% | 39% | 46% | 46% | 13% |
| Түлш түүдэг /аргал, хомоол, хамхуул/ | 28% | 42% | 38% | 38% | 0% |
| Хадлан тэжээлээ бэлтгэдэг | 28% | 25% | 31% | 31% | 25% |
| Сэтгэлийн баяр баясал мэдэрдэг | 19% | 19% | 27% | 31% | 0% |
| Эмийн болон ховор ургамал авч ашигладаг | 13% | 10% | 12% | 31% | 25% |
| Хэлж мэдэхгүй | 4% | 5% | 4% | 8% | 0% |
| **Ойгоос хүртдэг ашиг шим** | | | | | |
| Түлшинд ашигладаг | 26% | 27% | 35% | 31% | 38% |
| Хэлж мэдэхгүй | 13% | 15% | 8% | 8% | 38% |
| Хэрэглэдэг зүйл байхгүй | 11% | 12% | 4% | 8% | 25% |
| Жимс, жимсгэнэ түүдэг | 2% | 3% | 4% | 0% | 0% |
| Эмийн ургамал түүдэг | 2% | 5% | 4% | 0% | 0% |
| Мөөг түүдэг | 2% | 1% | 4% | 0% | 0% |
| Амьжиргаагаа залгуулдаг | 0.0% | 2.2% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Байшин барих | 0.0% | 0.4% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Хашаа барих | 0.0% | 1.5% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Хусны шүүс, модны бохь зэрэг модноос шууд авч ашиглаж болохоор зүйлс | 0.0% | 0.3% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Мод бэлтгэж худалдаалдаг | 0.0% | 0.1% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Модон эдлэл хийдэг | 0.0% | 0.4% | 0.0% | 0.0% | 0.0% |